



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

## НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 10
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	11 - 73

---

1. <i>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	14 - 29
2. <i>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	29 - 33
3. <i>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	33
4. <i>Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	34
5. <i>Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	35
6. <i>Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын Чингис хаан банкинд байршиж буй сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар болон Капитал банкны эрх хүлээн авагчийн мэдээлэл</i>	36
7. <i>Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан</i>	54 - 72
8. <i>“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	72 - 73

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны 6 дугаар сарын 27-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 32 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Саранчимэг;  
Чөлөөтэй: Б.Баярсайхан, Д.Сарангэрэл;  
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Оюунчимэг нар үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд нэмж оруулах гэсэн горимын санал гаргав. /10.28/

**П.Анужин:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Гэрэлсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, С.Одонтуяа, Ц.Туваан нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн

бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэний дагуу санал хураалт явуулав.*

**П.Анужин:** 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож, үлдэгдлийг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 7

Бүгд: 13

46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**П.Анужин:** Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**П.Анужин:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрөл: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсний дагуу санал хураалт явуулав.*

**П.Анужин:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “байгууллагаас” гэснийг “үйлдвэрчний эвлэлээс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрөл: 11  
Татгалзсан: 2  
Бүгд: 13  
84.6 хувийн саналаар санал гуравны хоёроор дэмжигдлээ.

**П.Анужин:** Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдсэн тул Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “байгууллагаас” гэснийг “үйлдвэрчний эвлэлээс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Гэрэлсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, М.Оюунчимэг нар үг хэлэв.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Гэрэлсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсний дагуу санал хураалт явуулав.*

**П.Анужин:** Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “зүйлийн 11.1, 11.2-т” гэснийг “хуулийн 11.1-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**П.Анужин:** Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдсэн тул Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “зүйлийн 11.1, 11.2-т” гэснийг “хуулийн 11.1-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Гэрэлсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

**П.Анужин:** 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7, 14.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно.”

14.7.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн

хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.9. Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Гэрэлсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Байнгын хорооны дарга П.Анужин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-д заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.



**П.Анужин:** Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа.Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын Чингис хаан банкинд байршиж буй сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар болон Капитал банкны эрх хүлээн авагчийн мэдээлэл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Х.Булгантуяа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Капитал банкны эрх хүлээн авагч Т.Дэлгэрхүү, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Р.Сансармаа, Ц.Сүхбаатар, Л.Төр-Од, Б.Баяраа, Э.Энхжаргал, Х.Буянжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ахлах аудитор, шинжээч Б.Анхбаяр, Э.Одонтуяа, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны мэргэжилтэн Н.Сэлэнгэсайхан, Н.Энэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Ц.Элбэгзаяа нар байлцав.

Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын Чингис хаан банкинд байршиж буй сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Х.Булгантуяа, Капитал банкны эрх хүлээн авагч Т.Дэлгэрхүү, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Ц.Сүхбаатар нар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Капитал банкны эрх хүлээн авагч Т.Дэлгэрхүү, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын Чингис хаан банкинд байршиж буй сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар болон Капитал банкны эрх хүлээн авагчийн мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 11 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо.Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Х.Булгантуяа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Капитал банкны эрх хүлээн авагч Т.Дэлгэрхүү, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Р.Сансармаа, Ц.Сүхбаатар, Л.Төр-Од, Б.Баяраа, Э.Энхжаргал, Х.Буянжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ахлах аудитор, шинжээч Б.Анхбаяр, Э.Одонтуяа, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны мэргэжилтэн Н.Сэлэнгэсайхан, Н.Энэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Ц.Элбэгзаяа нар байлцав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Бейсен, Ц.Туваан нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Х.Булгантуяа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Ц.Сүхбаатар, Х.Буянжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг сонсов.

*Уг асуудлыг 12 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

***Найм. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт тухайн асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана гэж заасны дагуу “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэл хэсэгт “34.3 дахь хэсэг” гэсний дараа “Монгол Улсын эмийн үнэ, хүртээмж, худалдан авах боломж, үнэ бүрдлийн судалгаа, эмийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг шалгах шаардлагыг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 56 минут үргэлжилж, 17 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 76.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 28 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

П.АНУЖИН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”  
танхим  
9 цаг 32 минут

## **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**П.Анужин:** Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 52.9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя.

Б.Бейсен гишүүн ирсэн,  
Б.Жаргалмаа гишүүн ирсэн,  
М.Оюунчимэг гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Ц.Туваан гишүүн ирсэн, Ж.Чинбүрэн гишүүн ирсэн, С.Чинзориг гишүүн ирсэн, Ц.Идэрбат нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна. С.Одонтуяа гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Хоёр.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Гурав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Тав.Чингис хаан банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар Капитал банкны эрх хүлээн авагчийн мэдээлэл.

Зургаа.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Нэр авъя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасалъя. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлнэ.

**Ж.Чинбүрэн:** Миний бие Улсын Их Хурлын нэр бүхий 28 гишүүний хамт Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Эмийн үнэ, түүний өсөлтийн шалтгаан, нөхцөлийн асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын

Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурал тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалт тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан тогтоолын төсөлд Хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгах нь зүйтэй гэсэн горимын санал гаргасныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.3-д заасны дагуу санал хураалт явуулахад чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэнтэй холбоотой тогтоолын төслийг үндэслэлийн хэсгийг дараах байдлаар нийцүүлэн шийдвэрлэж өгнө үү гэж байгаа юм.

Тэгээд энэ санал дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4-ийн тогтоолыг төслийг тогтоох хэсэгт уг тогтоолоор шийдвэрлэх асуудлыг энгийн ойлгомжтой байдлаар томъёолж бичнэ гэж заасны дагуу “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэл хэсэгт “34.3 дахь хэсэгт” гэсний дараа “Монгол Улсын эмийн үнэ, хүртээмж, худалдан авах боломж, үнэ бүрдлийн судалгаа, эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг шалгах шаардлагыг” гэж нэмж оруулахаар тогтоолд өөрчлөлт нэмж орууллаа.

Тэгээд үүнийг хэлэлцэх асуудалд оруулж өгөөч ээ.

**П.Анужин:** Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн албан бичгээр заавал өгнө. Ж.Чинбүрэн гишүүний гаргасан Эмийн хянан шалгах түр хороо байгуулах саналыг өнөөдөр хэлэлцэх асуудлын дараалалд оруулж өгнө үү гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

70.0 хувиар санал дэмжигдлээ. Тийм. Хэлэлцье.

Хассуурийн Ганхуяг гишүүн уг.

**Х.Ганхуяг:** Өглөөний мэнд. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүддээ өглөөний мэндийг хүргэе.

Өнгөрсөн долоо хоногийн чуулган дээр яг энэ малчны нийгмийн даатгалтай холбоотой асуудал дээр бас байр сууриа илэрхийлсэн байдаг. Яах вэ, түүн дээр бас нэг алдаатай юм болсон байна лээ.

Манай П.Анужин, манай Х.Булгантуяа сайд хоёр буруугүй юм билээ. Энэ чинь өмнөх сайдад нь оруулж ирсэн асуудал байна лээ.

Гэхдээ би П.Анужин даргад бас хэлэх гээд байгаа юм. Энэ заалтаас чинь болж энэ хууль чинь унах вий. Энэ малчны нийгмийн даатгалыг яахаараа улсын төсвөөс төлдөг юм бэ?

Энэ Үндсэн хуулийн цэцэд очих заалт шүү. Хэн нэгний сонгуулийн амлалтыг, хэн нэгний сонгуулийн мөнгийг улсын төсвөөс өгнө гэж бол байхгүй шүү. Би бүр энэ хатуу анхааруулчихъя.

Хэрвээ энэ заалт батлагдах юм бол би өөрөө Үндсэн хуулийн цэцэд өгнө өө гэж би хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлнэ.

**М.Оюунчимэг:** Өглөөний мэнд хүргэе. Би бас Х.Ганхуяг гишүүний саналтай төстэй санал хэлэх гэсэн юм.

Ер нь Үндсэн хуулиар бүх хүн тэгш эрхтэй гэж заасан байдаг. Тэгээд бид нар энэ малчны тэтгэврийн 50 хувийг төр даавал 50 хувийг нь одоо өөрсдөө төлөөл 50 хувийг нь төр даана гэж оруулж ирж байгаа нь өөрөө ялгаварласан, иргэдээ ийм буруу үзэл рүү оруулж байгаа юм.

Ялангуяа нийгмийн даатгалын багц хууль гэсэн ийм том хуулиар буруу жишиг тогтоох нь өөрөө нийгэмд маш буруу.

Малчид өөрсдөө ч зарим нь бол ийм байр суурьтай байна шүү дээ. Тэгээд судалгаанууд аваад үзэхэд малчдыгаа ядуу, орлогогүй, ирээдүйд халамжийн тэтгэвэрт өртөж магадгүй гэсэн тийм нэг бараг буруу яривал нөгөө монгол хүн чинь амны бэлгээр гэдэг. Муу ёрын юм шиг ингэж бодоод тэгээд төлөхгүй бол одоо ирээдүйд манайд 13 их наядын хохирол, халамжийн тэтгэвэр авах болно, энэ нь дарамт болно гэх мэт буруу тийм прагматик биш, бодит бус тооцоо судалгаа яриад байх нь бол өөрөө буруу юм.

Одоо жишээлбэл эндээс 128 тэрбум төгрөг гарна гэхэд зөрүү нь бол 44 тэрбум төгрөг байгаа юм билээ. Тэгээд малчид дотроо аваад үзэхэд мянгат малчин болон түүнээс илүү орлоготой малчид бас цөөхөн. Ихэнх нь туслах малчин болоод туслах малчид төр 50 хувийг нь даалаа гэсэн ч өөрсдөө 50 хувийг нь даах боломжгүй гэсэн судалгаанууд байдаг юм байна.

Тэгээд ингээд үзэх гэхэд бид нар зөвхөн энэ малчдын 50, 50 гээд үзэхэд өнөөдөр байгалийн гамшигт үзэгдэл хэцүү нөхцөл байдалд ажилладаг малчдаа төрөөс харж үзэж байна гэвэл яагаад тариаланчид тэгвэл бид нарыг бас болохгүй байгаа юм, яагаад ногоочид болохгүй байгаа юм гээд.

Улаанбаатар хотын тухайд өрхийн бизнес эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа, сайн дураараа зах дээр борлуулалт хийгээд зогсож байгаа хүмүүст өнөөдөр ингэж хандаж байна шүү дээ.

Яагаад иргэдээ та нар ялгаварлаад байгаа юм бэ гээд. Тэгээд ер нь бол аливаа нэг ажлын хэсэг бол өөр байдаг шүү дээ. Оруулж ирсэн юман дээр бид нухацтай ханддаг. Нийгмийн даатгалын багц хууль дээр жишээлбэл өмнө Төрийн нарийн бичгийн дарга байхдаа Г.Өнөрбаяр дарга бүх манай Байнгын хороодын гишүүдэд тайлбарлаад ингэхэд орон нутаг болоод явсан хэлэлцүүлэг дээр Д.Анужин дарга бол хот дахь энд хоёрт нь суусан байх.

Би одоо тэр хоёр, гурван хэлэлцүүлэг дээр ч очсон. Малчдыг ингэж ялгаварлах нь өөрөө буруу шүү. Та нар үүнийгээ яг тооцоо судалгаатайгаар зөв хандлага бий болгох нь өөрөө зөв шүү гэсэн хүмүүс босоод үг хэлж байсан шүү дээ. Хөдөө орон нутагт хүртэл. Дархан, Эрдэнэтийн хэлэлцүүлгүүдийг харсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын энэ ажилтнууд нь өөрсдөө явж байсан. Тэгээд одоо энд ийм буруу ойлголт өгөөд. Тэгээд одоо энэ нь эргээд. Зарим хүмүүсийг ч гэсэн хардахад хүргэж байна шүү дээ. Өөрсдөө сонгуулийн шоу хийх гэж гээд. Яг бодит хэрэг дээр уг нь ажлын хэсэг, ажлын хэсгийн ахлагч, ажлын

хэсгийн гишүүд иймэрхүү зүйл дээр бүгдээрээ ярья. Хүн бүхнийг суулгаж байгаад нухацтай асуудалд ханддаг.

Ц.Мөнх-Оргил гишүүнээр ахлуулсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр бүх хүн биечлэн ажлын хэсэг дээрээ оролцож байгаад энэ асуудал дээр саналаа хэлье. Тэгээд гараа өргөөд ингэж ажиллая гээд. Ажиллах хүчин дээр ч тэгдэг.

Тэгээд одоо сая ингээд харахад ингээд хайрцаглаад дэд ажлын хэсэг дээрээ ч гурав, дөрвөн хүн нь тэр Баянголын н.Энхчимэг гэдэг төлөөлөгч, тэр н.Дэлгэрсайхан, энэ хэд хэдэн хүн бид нар дэд ажлын хэсэгт оруулчихсан хэрнээ мэдээлэл өгөхгүй байсаар байгаад шууд чуулганд оруулсан. Ийм төр байдаг юм уу гээд шүүмжлээд байгаад байна л даа.

Бид ийм буруу жишиг ийм том хуулиар тогтоож болохгүй. Тэгээд сая том ажлын хэсэг дээр ч гэсэн бид нарыг анзаараад байхад бүх ажлын хэсгийн хуралдаан байхад, Төрийн ордонд байж байхад орох уу гээд нэг нарийн бичгийн

даргаас нь мессеж ирээд. Уг нь бүх гишүүд рүүгээ утасдаад энд болж байна. Энэ юм олон юм давхцаж байхад бид нар чинь яаж ийгээд л ажлын хэсгийн хуралд ороод ингэдэг.

Тэгээд дараа нь хүүе яагаад мэдэгдээгүй юм бэ гэхээр мессежээр танд мессеж явуулсан шүү дээ гээд. Тэр болгон зарим нь мессежээ анзаарахгүй шүү дээ. Тэгээд бүгдийг нь суудаг. Тэгээд хайрцаглаад л хайрцаглаад л аль болохоор хурдан батлуулчих гээд л.

Нийгмийн даатгалын багц хуулийг энэ хаврын чуулганаар батлаасай гэдэг дээр би санал нэг байгаа. Энэ хууль гарах ёстой. Гарахдаа харин нийтийн эрх ашиг бүх хүнд хамаатай хууль учраас үүнийг бид маш нухацтай ажиллах ёстой.

Өчигдөр хэд хэдэн зүйл дээр бид яаж ажиллаа. Орж ирээд л тэгээд ингээд бүр том утгаараа энэ санхүүгийн механизмтай холбоотой асуудлууд байгаа.

**П.Анужин:** Хэлэлцэх асуудлын талаар гишүүд үг хэлж дууслаа.

---

**Нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**

*/Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

---

Нийгмийн даатгалын багц хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Ажлын хэсгийг танилцуулъя. А.Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн

даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ц.Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Д.Ренчиндорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Б.Гэрэлсайхан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн. Ийм бүрэлдэхүүнтэйгээр хүрэлцэн ирсэн байна.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгыг Та бүхэндээ танилцуулъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанаар 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр явуулсан билээ.

Анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын даргаас Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслүүд дээр гарсан зарчмын зөрүүтэй 2 саналыг хураалгалгүй гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

Түүнчлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч нийт гишүүдийн гуравны хоёр дэмжүүлж, дахин санал

хураалгах зарчмын зөрүүтэй 2 саналыг ажлын хэсгээс бэлтгэлээ. Үүнд:

1.“Даатгуулагч нас барвал түүний мөнгөжүүлсэн орлогыг” гэснийг орлогын тодорхой хувийг болгон өөрчилж хууль ёсны залгамжлагчид нь өвлүүлэх төслийн 29.6 дахь хэсгийн төслийн заалт буюу “орлогыг” гэснийг хэвээр үлдээж 29.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найрууллаа.

29.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол гэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож үлдэгдлийг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.

2.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн 35.1.2-т нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагаас гэснийг “Үйлдвэрчний эвлэлээс” гэж өөрчлөхөөр.

3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд анхны хэлэлцүүлгээр санал хурааж, дэмжигд, дэмжигдсэн заалттай холбогдуулан эшилсэн заалтыг хасахаар.

4.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөлд даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж үйлчилгээний



чанарт хяналт тавих журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэснийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл батална гэж өөрчлөн найрууллаа.

Мөн 1991 онд батлагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсрууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Эцсийн хэлэлцүүлгийг бэлтгэсэн талаарх танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Цэвэгдоржийн Туваан гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

**С.Чинзориг:** Үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын саналыг манай ажлын хэсэг хэрхэн авч судалж хуулийн төсөлд тусгасан юм бол.

Өчигдөр надад үйлдвэрчний эвлэлийн холбооноос 8 орчим санал дээр анхаарах шаардлагатай байна гэсэн ийм санал ирүүлсэн. Энэ саналуудыг би

өчигдөр Б.Батжаргал руу явуулсан даа. Зургийг нь аваад. Үүнийг та бүхэн ажлын хэсэг дээр ярьж үзсэн үү, үгүй юу. Өчигдөр хамгийн гол нь ажлын хэсгийн хуралд орж амжихгүй учраас анхаарах болов уу гээд ингээд явуулсан юм.

Тэгээд энэ саналуудыг бас нэг анхаараад ярих хэрэгтэй байна. Б.Батжаргал нэг хариулт өгөөч.

Хоёр дахь асуудал нь, өмнө нь уг нь ярьдаг байсан юм. Тэгээд энэ хуульд ороогүй юм болов уу.

Хууль тав дахь өдөр чуулганаар ярьсны дараа над руу 5, 6 ээжүүд гээд баахан улсууд мессеж бичүүлээд байсан. Анхаарч өгөөч гээд.

Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ байнга гэрээрээ харж асарч байдаг ээжүүд ажил, хөдөлмөр хийх, орлого олох боломжгүй байдаг.

Ажил хөдөлмөр эрхэлж орлого олох боломж нь хязгаарлагдмал байдаг учраас нийгмийн даатгалын шимтгэлээ төлж чадахгүй байна. Тэтгэвэр авч чадахгүй бид хохирдог. Тийм учраас байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асарч ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа ээжүүдийн шимтгэлийг төр хариуцах талаар бас заалт оруулаач ээ гээд ийм маш их одоо хүсэл саналт ирээд байгаа юм.

Үүнийг хэрхэн яаж одоо тооцож үзэх юм? Энэ тусаагүй болоод л тэр ээжүүд ингээд над руу баахан санал явуулаад байх шиг байна.

Гурав дахь асуудал нь, чуулган дээр хэлэлцэх асуудал дээр засаг 29

дүгээр зүйлийг гүйцээн боловсруулах гээд Их Хурлын даргаас чиглэл өгсөн.

Тэгэхээр тэр 29 дээр байгаа ипотекийн зээлд хамруулж болно, өвлүүлж болно, эрүүл мэнд, боловсролын зардал зарцуулж болно гэсэн заалтууд чинь олон жилийн дараа хэрэгжих заалтууд шүү дээ.

Тэгэхээр одоо үүнийг ингээд намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт байгаа гээд хэрэгжихгүй заалтыг 10 жилийн дараа, магадгүй 20 жилийн дараа хэрэгжих заалтыг одоо хуульд оруулах нь хэр оновчтой юм бэ?

Тэр саяын миний хэлж байгаа тэр гурван зардалтай холбоотой өвлүүлэх, ипотекийн зээлд зарцуулж болох, эрүүл мэнд боловсролын зардалдаа зарцуулж болно гээд байгаа энэ заалтуудыг хэрэгжих хугацаа нь олон жилийн дараа юм чинь наана нь иргэдэд ингээд буруу ойлголт өгөөд хүлээлт үүсгээд нийгмийг бухимдуулахын л нэмэр шүү дээ.

Тэгээд үүнийг би хуралд орж чадахгүй нь, хасах саналтай байна гээд уг нь өчигдөр ажлын хэсгийн вайбер бичихээр нь бас санал авдаг юм бодоод бичсэн. Тэгээд хариу өгөөгүй л дээ.

Одоо ч гэсэн тэр ажлын хэсгийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн санал дээр орж ирээгүй юм шиг байна. Энэ саналуудыг юу гэж үзэж байгаа юм бэ гэж. Хэрвээ та бүхэн үүнийг авч үзээгүй бол би зарчмын зөрүүтэй саналын томъёолол бичээд тэгээд санал хураалгая гэсэн ийм саналтай байгаа юм. Энэ 3 асуудал дээр нь хариулт өгөөч.

**П.Анужин:** С.Чинзориг сайдын нэг асуултад би хариулъя.

Тэр байнгын асаргаатай хүүхдүүдийн аав, ээж нарт зориулсан ямар зохицуулалт орсон бэ гэж.

Энэ хуулийн төслийн 21.22-т эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмж хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө гэсэн ийм нарийн зохицуулалт орсон байгаа.

Үлдсэн хоёр асуудлыг Үйлдвэрчний эвлэлийн тусгасан саналууд болоод гүйцээн боловсруулах чиглэлд өгсөн асуултад А.Хишигбаяр дарга хариулъя. Хэдэн номерын микрофон байна. 2 номерын микрофон.

**А.Хишигбаяр:** С.Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн 29 дүгээр зүйлд бид ерөнхийдөө бодлогын бичиг баримт буюу “Алсын хараа-2050”, мөн Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 оны хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл дээр Монгол Улс хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоо руу үе шаттай шилжинэ.

Мөн нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг цаашдаа хуримтлуулах нөхцөл рүү шилжүүлж, өвлүүлэх харилцаагаар шилжүүлнэ.

Мөн хуримтлалын нэгдсэн сантай байна. Монгол Улс гэдэг ийм зорилтуудыг тусгасан байгаа.

Энэ бодлогын бичиг баримттай уялдуулж бид хуулийн төсөлдөө нэрийн дансны үлдэгдлийг мөнгөжүүлэх, хийсвэр үлдэгдлийг мөнгөжүүлэх, мөн шимтгэл төлж байгаа даатгуулагчийн шимтгэлийн тодорхой хувийг бас мөнгөжүүлж явъя гэсэн ийм байдлаар хуулийн томъёололд тусгасан байгаа.

Энэ өвлүүлэх харилцаа бол 2030 оноос өвлүүлж явах боломж байна гэдэг байдлаар тодорхойлж болохоор болсон байгаа.

Үйлдвэрчний эвлэлийн саналын тухайд яг Үйлдвэрчний эвлэл нь үндэсний зөвлөлд яг үйлдвэрчний эвлэлийн байгууллага гэдэг төлөөллөөрөө сүүлийн төсөлд тусгах энэ саналыг оруулж ирсэн байгаа. Зарчмын хувьд ажлын хэсэг дээр үүнийг дэмжиж болно гэдэг чиглэлээр ажиллаж байгаа.

**П.Анужин:** Б.Батжаргал дарга. Үйлдвэрчний эвлэлтэй хамгийн сүүлд өнгөрсөн нэг дэх өдөр бүх саналуудаа эцэслээд, тохироод тийм ээ, бүх саналууд орсон байна гэдэг дээр санал нэгдсэн байгаа.

Үүнийгээ манай ажлын хэсгийн гишүүд тодорхой хэлье. Та нар энэ хурал дээр юм уу, чуулган дээр суухаараа ерөөсөө хийсэн, тооцоолсон бүх юмаа тодорхой ярьж чадахаа больчих юм. Ямар учир байдаг юм. Б.Батжаргал гишүүн та тодорхой хариул даа.

Саналуудыг нэгтгээгүйгээр орж ирнэ гэж байхгүй шүү дээ.

**Б.Батжаргал:** С.Чинзориг гишүүний асуултад хариулья.

С.Чинзориг гишүүнд хандсан Үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгч С.Эрдэнэбатын гарын үсэгтэй албан тоот

болон албан тоотын хавсралтаар дурдсан саналуудыг өчигдөр над руу бас С.Чинзориг гишүүн явуулсан.

Үүнийг ингээд үзэхээр нэгдүгээр санал бол хоол, унааны зардлыг шимтгэл ногдуулах орлогоос хасаач ээ, эсвэл хязгаар тавиаач ээ гэсэн ийм санал байсан.

Энэ дээр манай хуулийн төсөл дээр бэлэн мөнгөөр олгож байгаа тохиолдолд л авна. Түүнээс биш бусад хэлбэрээр олгож байгаа тохиолдолд огт авахгүй гэсэн зарчмаараа туссан байгаа.

Хоёр дахь санал нь, хуулийн төслийн 35.1.2 27.2.2 дахь заалтыг хэвээр үлдээх буюу даатгуулагчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалсан Үйлдвэрчний эвлэлийг төлөөлсөн 3 хүн гэж хуучнаар нь үлдээж өгөөч ээ гэсэн заалт, саналыг оруулсан байгаа.

Үүнийг өчигдөр ажлын хэсгийн хурлаар хэлэлцсэн гэж ойлгосон.

Гуравдугаар санал нь болохоор 20-иос доошгүй жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд нас барсан эхнэр, нөхөр аль нэгийнх нь тэтгэврийг нэмэгдүүлье гэсэн ийм санал байгаа.

Энэ дээр угаасаа хуулийн төслийн эрх үүсвэр заалт угаасаа хоёр тохиолдолд үүсэхээр оруулсан байгаа. Өндөр нас дээр. Энэ бол нэгдүгээрт 20 ба түүнээс дээш жил. Эсвэл хувь тэнцүү тэтгэвэр бол 10-аас 20 жил гэсэн ийм заалтын зохицуулалт нь орчихсон байгаа гэж ойлгож байгаа.

Дөрөв дүгээр санал бол нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн 20 хувийг бага байна. Үүнийг нийгмийн даатгалын сангийн чадамжийг харгалзан энэ хувийг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн ийм санал гаргасан байна лээ.

20-иос илүү байвал энэ бол сангийн зардал дээр нэлээн ачаалал өгнө. Тэгээд энэ бол зөвхөн ямар нэгэн байдлаар эхний харилцаа. Одоо эхний харилцааг 20 хувиар эхлүүлж байна гэсэн байдлаараа бид яаман дээрээ ярилцсан.

Дараагийн санал бол энэ дээр 7 жилээр тэтгэврээр тогтоолгосон тэтгэвр авагчийн тэтгэврийг нэг удаа шинэчлэн тогтооно гэж өөрчлөн найруулж өгнө үү гэсэн ийм санал ирсэн байгаа.

Тэгээд үүнийг хуулийн төсөл дээр тусгасан байгаа. Үүнийг тусгаад явж байгаа.

Дараагийн санал нь хүнд нөхцөлийг хуулийн төслөөс бүүр авч хаяач ээ. Үүнийг бүүр байхгүй болгооч ээ гэсэн ийм санал ирүүлсэн байна лээ. Тэгээд энэ бол одоо яг хуулийн саналыг нь аваад энэ заалтыг бол одоо байхгүй болгосон. Энэ хүчингүй болгосон гэх юм уу. Одоо хуулийн төслөөс авсан.

Дараагийн нэг багц саналууд дотор тэтгэврийн томьёотой холбоотойгоор тэтгэврийн томьёог тухайлсан нэг жилүүд, ажил, мэргэжил дээр өөр өөрөөр бодож өгөөч ээ. Жишээлбэл, зарим хүмүүсийн тэтгэврийг 45, түүнээс дээш жил дээр 1.5 биш 1.53 ч юм уу ингэж бодож өгөөч ээ гээд энэ ажил мэргэжлээр нь ангилаад өгөөч ээ гэсэн ийм заалт байна лээ.

Тэгэхээр ийм ажил, мэргэжил болгон дээр өөр өөр томьёо боддог улс орон бол дэлхийд алга. Тухайн улс орны тэтгэврийн бодлого бол нэг бодлогоор л явна, нэг бодолтоор л явж байгаа үндсэн зарчмаа эвдэхгүй баймаар байна гэсэн ийм асуудлуудыг бид ярьж байна.

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн багш, эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, түргэн тусламжийн жолоочийг нь тэтгэврийн насыг багасгаж өгөөч ээ гэсэн ийм санал ирсэн байна лээ.

Энэ саналыг урьд нь ийм санал Үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас ирж байгаагүй. Тэгээд энэ дээр нэгдсэн.../минут дуусав/

**П.Анужин:** Содномын Чинзориг сайд тодруулья.

**С.Чинзориг:** А.Хишигжаргал тэр ипотекийн зээлд зарцуулж болно, эрүүл мэнд, боловсролын зээлд зарцуулж болно гэж байгаа чинь мөнгөжүүлсэн орлогыг хэдэн оноос юм бэ? Өвлүүлэхийг нь бол та нар 2030 гэж бүдэг бадаг яриад байгаа юм.

Тэр эрүүл мэнд, боловсролын зардалд зарцуулж болно, ипотекийн зээлд зарцуулж болно гэдгийг ерөөсөө он хэлэхгүй байгаа юм. Хэзээ хэрэгжих юм бэ? Энэ тэгээд мөд бүтэх юм уу, үгүй юм уу?

Тэр үйлдвэрчний чинь санал чинь тэтгэвэрт гарах шимтгэл төлөлтийн хугацаатай холбоотой асуудал, 25 жилийг 20 болгооч ээ гэсэн юм бас бичсэн байгаа юм даа. Тэгээд тэрийг Б.Батжаргал ерөөсөө сая ярьсангүй дээ.

20-иос доошгүй гэж, 25-аас доошгүй гэдгийг 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бол тэтгэвэрт гарч болно гэдэг санал бичсэн байна лээ. Тэрийг нь чи ерөөсөө сая ярьсангүй дээ. Шимтгэлтэй холбоотой юмыг нь. Тэрийг нь яах юм?

**П.Анужин:** Б.Батжаргал дарга хариулъя.

**Б.Батжаргал:** С.Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Б.Батжаргал.

20-иос доошгүй жил шимтгэл төлсөн даатгуулагчийн хувьд яах вэ гэдэг энэ зохицуулалт нь өөрөө манай хуулийн, одоо ч байгаа хуулийн концепц болохоор нөгөө хувь тэнцүүлсэн тэтгэвэртэй байна гэсэн заалтаар хаагаад яваад байгаа юм л даа.

20 ба түүнээс дээш жилтэй бол бүрэн тэтгэврийн харилцаа нь үүсээд. Тийм. Одоо 3 сараар өсөөд 25 руу явж байгаа шүү дээ. Тийм ээ. Бид тэр шимтгэл төлсөн байх хугацааны доод хязгаараа хэмжээгээ нэг бага ч болтугай нэмэгдүүлж өгөх шаардлага бас гараад байгаа юм л даа.

**П.Анужин:** А.Хишигбаяр дарга. Их Хурлын даргын зүгээс гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. 29 дүгээр зүйлтэй холбогдуулж С.Чинзориг сайд асуулт асууж байна. Өвлүүлэх асуудал хэдэн оноос юм бэ гэж.

Тэгээд ипотек, эрүүл мэнд, боловсролдоо зарцуулна гэж орсон. Үүний хэрэгжих заалт орсон уу, ороогүй юу гэж байна.

**А.Хишигбаяр:** С.Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн 29.5.2 дээр мөнгөжүүлсэн орлогыг эрүүл мэнд боловсрол, орон сууцын ипотек санхүүжүүлж болохоор оруулсан байгаа.

Гэхдээ энэ хуулийг Нийгмийн даатгалын энэ ерөнхий хуулиар зохицуулахгүй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газраас бас Хуримтлалын нэгдсэн сангийн хуулийн төслийг боловсруулж байгаа.

Энэ хуулийн төсөл дээр яг нарийвчилсан ипотекийн зээл, боловсрол, эрүүл мэндэд хэрхэн яаж зарцуулах юм бэ, хэдэн оноос хэрэгжих юм бэ гэдгийг энэ хуулиар зохицуулна.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль дээр энэ гурван төрлийн санхүүжилт санхүүжүүлж болно. Үэхдээ үүнийг тусгай хуулиар зохицуулна гэдэг нэг ийм зохицуулалтын л заалт орж ирсэн байгаа.

Цаашдаа Хуримтлалын нэгдсэн сангийн хууль маань батлагдаад ирэхээрээ түүнтэйгээ холбогдуулаад энэ заалт маань яг тухайн хуулиараа нэрлэгдээд явна.

Тэгэхээр энэ яг ипотеكتэй холбоотой зохицуулалт хуримтлалын нэгдсэн сангийн хуулийн хүрээнд хэрэгжинэ. Тэгэхдээ ер нь мөнгөжүүлсэн орлогыг ипотекийн зээлд оруулна гэж.../минут дуусав/

**П.Анужин:** Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууя.

**С.Одонтуяа:** Тэгэхээр хэд хэдэн ярьж байсан заалтууд орчихсон юм байна. Тийм учраас би давхар асуугаад яах вэ? Энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асарч байгаа эцэг, эхийн зардлууд.

Үйлдвэрчний эвлэлийнх нь тэр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр байгууллага гэснийг Үйлдвэрчний

эвлэл гэж үлдээх гэдэг энэ орж байгаа юм байна.

Нөгөө 7 жил чинь 5 жилээрээ орж байгаа юм байна.

Тэтгэвэр өвлөх, хүүхдээ асарч байгаа эцэг, эх гээд.

Энэ асуудлууд дээр ямар ч байсан орсон байна.

Миний гол ярих гээд байгаа юм бол ерөөсөө л энэ малчны тэтгэвэр байна. Тэгээд би Байнгын хорооны даргаас асуух гэсэн юм.

Монгол Ардын намын бүлэг дээр ер нь яг ярьсан юм уу? Хэрвээ яриад та нар нэгдсэн шийдэлд хүрсэн бол өнөөдөр гишүүд чинь ингээд энд орж ирчхээд бүгд эсрэг бас ярихгүй байсан байх. Эсвэл ер нь үүнийг зарчмын чухал заалтуудыг заавал намын бүлэг дээрээ ярьдаг. Тэгэхгүй бол орж ирээд л задраад л тэгээд л гишүүд өөрсдийнхөөрөө батлуулах гэж байтал яг эцсийн хэлэлцүүлэг дээр намын бүлэг тэгсэн гээд явчихдаг.

Тэгэхээр энэ зүйлээ та нар ер нь үүнийг ярьсан юм уу гэдгийг нэгдүгээрт би асуумаар байна.

Ерөөсөө зүүний нам гэхээрээ нэг зүүн баруунгүй цацна гэдэг ойлголт байж болохгүй шүү дээ. Тэгээд энэ улс орныг чинь ерөөсөө ингэж эдийн засаг, нийгмийн асуудлыг нь ингэж сүйрүүлж болохгүй.

Хамгийн гол нь та нар энэ шударга хөдөлмөр эрхэлж байгаа, энэ татвараа төлөх гээд чадан ядан зүтгэж байгаа энэ хүмүүсийн зүгээр ажиллах урам зориг руу л ус цацаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр чинь яах юм. Хүмүүс. Бүх юм ажлаа хаяад л өнөөдөр бүгд гадагшаа явж байна шүү дээ. Энэ Монгол Улс чинь эзэнгүй айл шиг болж байна шүү дээ. Би сая дүүргээрээ явлаа ажил хийдэг хүн олдохоо больсон байна.

Тэгэхээр иймэрхүү шийдвэрүүд чинь том утгаараа эдийн засгийг сүйрүүлээд байдаг юм.

Тийм учраас үүнийг та нар 30 жил ер нь энэ хүмүүсийн сэтгэхүйг ухраах ийм юм руу орууллаа шүү гэдгийг би хэлчихье.

Дээрээс нь би ажлын хэсгээс юм асуумаар байна. Энэ малчны нийгмийн даатгалын 50 хувийг төрөөс төлнө гээд. Яг ямар хүнийг малчин гэдэг шалгуур байгаа. Одоо би нэг юм ярих гээд байна л даа. Анх Монгол Ардын нам тэр шинэ гэрлэсэн хосуудад 500 мянга өгнө гэсэн чинь л яалаа. Баахан хуурамч гэрлэлт гарсан. Тэгээд түүнтэй адилхан монголчууд чинь бүгдээрээ нэг малчин малчин гээд яваад нийгмийн даатгалаа төлүүлдэг ийм юм руу орчих юм биш үү?

Тэгэхээр энэ шалгуур нь ямар байх юм. Үүнийг асууя. Тэгээд ер нь бид нар энэ нийгмийн даатгалыг сонгодог утгаар нь л хөгжүүлэх ёстой шүү дээ. Яаж мөнгөжүүлэх вэ, яаж одоо тэр өр ширийг нь барагдуулах вэ, яаж энэ хүмүүсийн нэрийн дансаа хүмүүс хэрэглэдэг байх вэ гээд. Үүнийг чинь сонгодог утгаар нь хөгжүүлэхгүй дандаа нэг хачин замхруулаад хаячих юм.

Тэгээд сонгуулийн хуульд бид оруулсан шүү дээ. Иймэрхүү поп хийдэг зүйлийг ерөөсөө хууль батлахаа больё гээд. Тэгээд л одоо сонгууль дөхөж байгаа. Одоо яах гэж байгаа юм. Малчид

дээр очоод л баахан попрех гээд байгаа юм уу, хаашаа юм.

Ийм асуудлуудаараа та нар хэлэлцүүлэг сайн хийх хэрэгтэй шүү дээ. Энэ чинь маш том асуудал байхгүй юу. Сая энэ зааланд ерөөсөө маш олон. Тэгээд мах иддэггүй юм уу гээд С.Чинзориг сайд гуйвуулаад байх хэрэг байхгүй. За юу. Би мах иддэг. Гэхдээ би бас энд татвар төлөгчдийн олон мянган хүний төлөөлөл болоод сууж байгаагийн хувьд үүнийг хэлэх эрхтэй.

Тэгээд та нар ингээд юмыг ингэж нэг сонгодог утгаар нь эдийн засаг, зах зээл, хувь хүмүүсийн хариуцлага гэдэг юмыг ерөөсөө байхгүй болгож байгаа байхгүй юу. Дахиад л буцаад л нөгөө халамжийн орон руугаа орох гэж байна.

Тэгэхээр ингэж болохгүй ээ. Үүнийгээ нийт ард нийтэд хэлэлцүүлэг ч хийхгүй ингээд нэг хулгайн заалт оруулж ирдэг, батлуулдгаа болих хэрэгтэй.

Тэгээд асуултууддаа хариулт авъя.

**П.Анужин:** Энэхүү нийгмийн даатгалын багц хууль маань Монгол Ардын намын бүлэг дээр танилцуулагдаад явсан.

Хувь гишүүд маань юу гэж хэлэх нь энэ хувь гишүүний өөрсдийнх нь асуудал.

Хэлэлцүүлэг яваагүй гэж байна. Нийгмийн даатгалын багц хуулийн тухай хэлэлцүүлэг хөдөө орон нутагт 10 удаагийн хэлэлцүүлэг, нийслэл Улаанбаатар хотод нийт 7 удаагийн хэлэлцүүлэг, 14 хоногийн өмнө уг хуульд саналаа өгч тусгасан 33 мянга орчим иргэд байгаа.

С.Одонтуяа гишүүний асуусан тэр малчдын оруулж ирсэн заалт, судалгаа тооцооны талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам А.Хишигбаяр дарга хариулъя.

**А.Хишигбаяр:** С.Одонтуяа гишүүний асуултад хариулъя.

Малчин гэдгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульдаа малчин гэдэг нэр томъёоны тодорхойлолт байдаг. Байнгын улирлын чанартай малчнаар ажилладаг. Тэгээд байнгын өрхийн өрхийн орлогоо мал аж ахуйгаараа эрхэлж байгаа энэ хүнийг малчин гэнэ гэж хэлдэг.

Мөн мал аж ахуй эрхэлж, үндсэн орлогоо мал аж ахуйгаасаа олдог энэ иргэнийг малчин гэнэ гэдэг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд малчны тодорхойлолтыг тусгасан байгаа.

Мөн нийгмийн даатгалын байгууллага малчин гэсэн хүнийг тодорхойлохдоо бас “А” данс буюу мал тооллогын бүртгэлээр малчдыгаа тодорхойлж өнөөдөр тэтгэврийг тогтоогоод явж байгаа.

Тэгэхээр малчдыг мал тооллогоор нь, малын бүртгэлээр нь малчдаа тодорхойлоод явах боломж байгаа.

Малчдын өнөөдөр шимтгэлийн 50 хувийг яагаад энэ хуулийн хүрээнд улсын төсвөөс даахаар оруулж ирсэн бэ гэх юм бол өнөөдөр нийгмийн даатгалын багц хуулийг боловсруулахад тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого, 2030 он хүртэл баримтлах бодлогыг 2015 онд баталсан байгаа.

Энэ бодлогын бичиг баримттай үндэслэж хуулийн төслөө бид боловсруулсан байгаа.

Энэ дээр малчдын нийгмийн даатгалыг тусгай хөтөлбөрүүдийг боловсруулах ёстой. Албан журмын даатгал руу малчдыг цаашдаа албан журмын даатгуулагч болох ёстой гэсэн ийм зорилтуудыг дэвшүүлсэн байгаа.

Энэ хүрээнд бид малчдыг тодорхой хөтөлбөрийг Монгол Улс бас хоёр, гурван удаа хийж үзсэн байгаа.

Нэгд ажилласан жил, тэтгэврийн даатгалын тухай хуулийг 2012 онд баталсан. Энэ хүрээнд малчдыг 90 оноос хойших 11 жилийг нөхөн шимтгэлд хамруулсан байгаа.

Ингээд тодорхой үр дүнд хүрч чадаагүй. Мөн 2020 оноос эхлээд бас хууль баталж малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх тухай хуулийг 2 жил хэрэгжүүлсэн байгаа.

Энэ дээр нийт улсын хэмжээнд 220 гаруй мянган малчин байхад 30 гаруй мянган л малчин нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн.

Энэ хугацаанд энэ хуулийн хүрээнд бүр 20 энэ жилийг бид нөхөн төлөх боломжийг олгосон. Ингээд 30 гаруй мянган л хүн нийгмийн даатгалын шимтгэлд хамрагдсан байгаа.

Ингээд малчид маань цаашдаа нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй яваад байх юм бол нэг талаасаа халамжийн тэтгэвэр авагчид бий болох гээд байна. Ирээдүйд.

Нөгөө талаасаа богино хугацааны тэтгэмжид хамрагдаж чадахгүй маш их эрсдэлтэй. Ялангуяа Монгол Улс шиг цаг агаарын ийм эрс тэс уур амьсгалтай энэ улс орны хувьд эрсдэлд орох хамгийн үнэ

хүндрэлтэй ийм цочролын үед ажилладаг ийм хүмүүс байгаа.

Ийм учраас нийгмийн баталгаа алдагдах ийм нөхцөл байдал үүсэх гээд байна.

Нөгөө талаас Монгол Улс мал аж ахуйд түшиглэсэн ийм эдийн засагтай улс орон байгаа. Энэ хүрээнд малчдын тоо маш их багасаж байна. Ялангуяа залуу малчид, ялангуяа эмэгтэй малчдын тоо маш их цөөрч байна. Ийм учраас Монгол Улсад зайлшгүй тулгараад байгаа асуудал байна гэж үзэж бид малчдын шимтгэлийн 50 хувийг 5 жилийн хугацаанд улсын төсвөөс даая.

5 жил шимтгэлээ төлчихсөн байгаа малчин 5 жил шимтгэл төлөөд хамгийн багадаа хувь тэнцүүлсэн тэтгэврийн эрх үүсэх ийм нөхцөл боломж бол үүснэ.

Нөгөө талаас богино хугацааны хөдөлмөрийн чадвар түр алдсан, үйлдвэрлэлийн осолд орсон зэрэг эрсдэлүүдэд бас хамгаалах боломж байна гэсэн ийм байдлаар томъёолж хуулийн төсөлд оруулсан байгаа.

Шууд албан журмын даатгуулагч болгоё гэх юм бол өнөөдрийн хувьд малчдын хувьд бас боломжгүй байна. Зөвхөн улирлын чанартай орлого олдог. Ийм учраас энэ хүмүүсийг байнга албан журмаар та бүхэн сар болгон шимтгэлээ төлөөд яв гэдэг асуудлыг бид өнөөдрийн хуулийн төсөлд орох юм бол арай цаг хугацааны хувьд бас боломжгүй байна гэж харсан байгаа.

Ийм учраас 5 жилийн хугацаанд л малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг төлчих юм бол цаашдаа халамжийн тэтгэвэр авагч буюу одоо улсын төсвөөс тэтгэвэр авдаг хүний тоо



буурна. Нөгөө талаас малчин 50 хувийг нь төр хариуцлаа гэхэд.../минут дуусав/

**П.Анужин:** Салдангийн Одонтуяа гишүүн тодруулъя.

**С.Одонтуяа:** Би нэг ийм юм асуугаад байгаа юм. Одоо тэр хуурамч гэрлэлт гээд гарсан дээр би харин асуугаад байгаа байхгүй юу. Түүн шиг одоо энэ хуурамч хүмүүс бий болох ийм нөхцөл гарах уу? Би эрсдэлийг нь түрүүлж хармаар байна. Ийм эрсдэл үүсэх үү?

Одоо гадуур зүгээр хүмүүс ярьж байгаа нь зарим нь хошигнож л байгаа байх, зарим нь жинхэнээсээ ярьж л байгаа байх. Үгүй ээ, ерөөсөө малчин болчихъё л доо. Хэдэн мал аваад өөр дээрээ бичүүлээд нийгмийн даатгалыг нь шимтгэлээ талыг нь төлүүлчихье гээд зүгээр ингээд яригдаж байгаа юм.

Дээрээс нь одоо бид хүүхдийн мөнгөн дээр зөндөө хэлсэн шүү дээ. Та нар бүгдээрээ л сууж байсан. Хүүхдийн мөнгийг ялгаварлахаар маш их асуудал гарна шүү. Тэр нэг 9-хөн хувийг та нар өгөх гэж түүн дээр маш их асуудал үүснэ. Энэ чинь Үндсэн хууль зөрчсөн гээд яригдана гээд л зөндөө хэлсэн. Би ч хэлсэн. Манай Ардчилсан намын бүлэг ч хэлсэн. Болно. Чухамхүү бүх нарийн тооцоо хийчихсэн гэсэн. Юу боллоо. Бөөн будилаан болсон.

Түүн шиг энэ дээр чинь дахиад малчид дээр бөөн хэрүүл үүсэхгүй гэсэн баталгаа.../минут дуусав/

**П.Анужин:** А.Хишигбаяр дарга ээ, энэ бас нийгмийн сүлжээгээр ч гэсэн явж байна. Нэг ямаа аваад гаднаа авчхаад тэгээд малчин болоод нийгмийн даатгалынхаа шимтгэлийг төлүүлье ээ ч гэдэг юм уу.

Тэгэхээр яг энэ Монгол төрийн бодлого талаас нь А.Хишигбаяр дарга аа, анхаарлаа хандуулж байгаад. Тодорхой хариулт өгье. Тэгээд тэр эрсдэлүүд.

**А.Хишигбаяр:** Малчныг өнөөдөр “малчин”, “мал бүхий иргэд” гэж хоёр хуваагаад байгаа.

“Мал бүхий иргэд” гэдэг маань өөрөө тодорхой хэмжээний малтай мөртлөө өөрөө бас өөр хөдөлмөр эрхэлдэг, давхар хөдөлмөр эрхэлдэг ийм хүмүүс байгаа. Жишээ нь, сумын төв дээр ажиллаж байгаа төрийн албан хаагчид малтай л байгаа. Гэхдээ өөрөө төрийн албан хаагч. Сумын төв дээрээ ажилладаг. Тодорхой хөдөлмөр эрхэлдэг.

Энэ хүмүүсийг “мал бүхий иргэд” гэж хэлээд байгаа.

Яг “малчин” гэж байгаа бол яг мал аж ахуйгаа эрхэлж байгаа энэ хүмүүсийг малчин гэж хэлээд байгаа. Жил болгон Үндэсний статистикийн бас малын тооллого хийж байгаа. Энэ малын тооллого дээр бид малын тооллогын бүртгэл дээр, дахиад дээр нь нийгмийн даатгалд бүртгэлд албан журмаар ажил, хөдөлмөр эрхэлж байна уу гэдгээ бид ялгаад харах бүрэн боломж өнөөдөр байгаа.

Өнөөдөр бас шимтгэлээс гадна малчныг 5 жилийн өмнө тэтгэвэр тогтоолгох.../минут дуусав/

**П.Анужин:** А.Хишигбаяр дарга гүйцээж хариулъя.

**А.Хишигбаяр:** 2018 онд нийгмийн даатгалын хуульд бас өөрчлөлт оруулсан байгаа.

Тэгээд малчдыг эмэгтэй 15 жил малчнаар ажилласан, нийт 20 жил шимтгэл төлсөн эмэгтэй малчин 50 насандаа, эрэгтэй малчин 55 насандаа тэтгэвэр тогтоолгодог ийм эрх зүйн орчин нээгдсэн байгаа.

Энэ дээр бид бас өнөөдөр малын тооллого, “А” бүртгэл энэ бүгдийг нь үндэслэж байгаад тэтгэврийг нь эрт тогтоодог ийм нөхцөл байгаа. Энэ дээр ямар нэгэн өнөөдөр хэн нэгэн хуурамчаар өөрийгөө малчин гэж үзээд тэтгэвэр тогтоолгож байгаа ийм нөхцөл байхгүй байгаа.

Тэгэхээр өнөөдөр шимтгэлийг ч гэсэн энэ зохицуулалтаараа явахад өнөөдөр бүрэн боломжтой гэж харж байгаа.

Хоёрт, нийгмийн даатгал өнөөдөр бас харьцангуй цахимжчихсан байгаа учраас албан журмын даатгал өгчхөв үү, сайн дурын даатгал өгчхөв үү, мал тооллогын бүртгэл нь үү гэдгийг бүгдийг нь харах өнөөдөр бүрэн боломжтой байгаа.

**П.Анужин:** Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлье.

**Ц.Туваан:** Энэ эцсийн хэлэлцүүлэг явж байгаа. Ажлын хэсэг энэ дээр сайн ажилласан.

Бүх юмнуудаа оруулаад явсан. Мэдээж бүгдийг нь 100 хувь оруулна гэж байхгүй.

Энэ малчид дээр яриад байх юм. Үүнийг би дэмжиж байгаа. Зөв. Харин энэ дээр тэр хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа тариаланч, ногоочдыг уг нь нэмчихсэн бол бас бүр л пүүл болоод явах байсан.

Яагаад гэхээр энэ чинь одоо энэ хөдөө аж ахуйн салбарыг бид дэмжих бодлого. Энэ хүнсээр гол хангаж байгаа энэ бодлого, хөнгөн үйлдвэрүүдээ түүхий эдээр хангаж байгаа энэ салбартаа ер нь яагаад дэмжиж болдоггүй юм.

Ерөнхийлөгчийн санаачилгаар Хүнсний хангамж, аюулгүй байдал гээд хөтөлбөр гаргаад бид дэмжээд л явж байгаа шүү дээ.

Яг үнэндээ жилээс жилд малчин, хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын ажиллах нөхцөл маш доройтож байгаа шүү. Энэ жил гантай маш олон сумд байна. Дээрээс нь зүүн аймагт зуны халуунаар өнөөдөр түймэр гараад л, Дорнод аймагт түймэр гараад л байж байна. Энэ ирэх намар өвөл асар хүндэрнэ.

Тэгэхээр малчнаар ажиллана гэдэг бол тийм амар ажил биш. Тэгэхээр энэ дээр төрөөс хамгийн том секторынхныгаа тодорхой дэмжлэг. Энэ чинь сайн дураар сардаа 74 мянга 250 төгрөг. Үүний 50 хувь буюу 37 мянган төгрөгийг л төр тодорхой хугацаанд даах асуудал яригдаж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлыг дэмжиж байгаа.

Энэ өвлүүлэх асуудал бид өнөөдөр зарчмын зөрүүтэй саналаар оруулж ирж байна. “Өвлүүлэх” гэдэг үндсэн харилцаа чинь энэ Хувийн тэтгэврийн тухай хууль дотор орж байгаа шүү.

Тэгэхээр Байнгын хороон дарга энэ Хувийн тэтгэврийн тухай хууль чинь сүргээсээ тасраад үлдчихсэн явж байгаа. Үүнийгээ энэ хаврын чуулганд багцаар нь батлуулах тал дээр бид анхаарах ёстой шүү.

Яагаад гэхээр бид хөдөө орон нутгаар нийгмийн даатгалын багц хуулийг ярьж явахдаа ард иргэддээ бид олон давхаргат болгоно гэж ярьсан. Одоо нөгөө олон давхарга чинь бүр байхгүй болоод одоо хувийн тэтгэвэр маань юмыг яаж мэдэх вэ ингээд үлдчих юм бол яг хуучнаараа ганц давхаргат тогтолцоотойгоо л үлдэх гэж байгаа шүү.

Тэгэхээр үүнийгээ би бас санаа зовж хэлж байгаа юм. Энэ харилцаагаа хэдүүлээ аваад явах ёстой.

Тэгэхээр энэ дээр тэтгэврээ өвлүүлэх гэдэг асуудал чинь бол гол харилцаа нь түүн дээр байгаа учраас үүнийгээ сайн харж яваарай гэж хэлэх гэсэн юм.

Энэ дээр энэ 7 жилийг 5 жилээр бодох хуулиуд орсон байна. Энэ дээр уг нь тэр тодорхой гишүүд санал болгоод өгчихсөн байгаа. Нэгэнт л буцаад орж байгаа юм бол энэ нөхөн олгох асуудлыг нь сая энэ хүүхдийн мөнгө нөхөн олгож байгаа шиг олгочихвол бас сайн байх байсан юм гэж ингэж бодож байна.

Дээрээс нь Хамтын тэтгэврийн тухай хууль гэж Ардчилсан намын үед баталсан хуулийг эрх баригчид цуцалчихсан юм. Уг нь үүнийг цуцлахгүй явж л байх байсан юм. Энэ чинь иргэний л төлөө хууль байсан байхгүй юу.

Тэгэхээр одоо дахиад энэ хуульд нэг нь нас барсан тохиолдол 20 хувиар гээд суугаад орж ирж байгаа нь чамлахаар чанга атга гэсэнтэй адилхан асуудал болж байна гэж бодож байна.

Тэр хүнд, хортой нөхцөл хоёрыг ялгаад явж байсан. Тэгээд энэ хортой нөхцөлийг нь арилгаж чадаагүй байж үүнийг ялгаж байгааг ойлгохгүй байсан.

Тэгэхээр энэ хууль дээр бас одоохондоо энэ бол шаардлагагүй ээ гэдэг байдлаар хасаад явж байгааг нь зөв шийдлээ гэж харж байгаа.

Иргэдтэй уулзаад явж байхад хамгийн их гарсан нэг санал байгаа. Тэгээд энэ дээр дэгийн тухай хөндөгдөөгүй санал гээд явчих юм шиг байна. Би тэгэхдээ энэ дээр зарчмын зөрүүтэй санал уг нь болбол гаргамаар байна.

Тэр нь юу гэхээр тэтгэврийн насыг дээшээ өндрөөр, эрэгтэй 65, эмэгтэй 60 байхаар хуульчилчихсан байгаа.

Тэгэхдээ 55, 60 дээр сонголттой ийм хувилбар явж байгаа.

Тэгтэл тодорхой салбарууд. Бага ангийн багш, цэцэрлэгийн багш, биеийн тамирын багш гэсэн ийм мэргэжилтэй хүмүүс дээр маш их саналууд гарсан. Тэр нь юу гэхээр хэрвээ дээшээ сонголт байдаг юм бол бид нарын насыг бас өөрсдөө сонгоод.../минут дуусав/

**П.Анужин:** Ц.Туваан гишүүн минут нэмж авах уу? Ц.Туваан гишүүн үгээ хэлж гүйцээе.

**Ц.Туваан:** Доошоо буюу энэ цэцэрлэгийн багш, бага ангийн багш, биеийн тамирын багш нар өөрсдөө хүсвэл тэр эрэгтэй 60, эмэгтэй 55 хүрэлгүйгээр сонголт хийгээд тэтгэврийн насаа наашлуулаад авах нөхцөлийг нь хуулиар олгож өгвөл зүгээр байгаа юм.

Маш олон цэцэрлэгийн багш нар бид нарыг багшаа гэж хүн харахгүй байна гэдэг асуудал ярьж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлыг бас уг нь зарчмын зөрүүтэй санал оруулаад явъя

гэсэн. Тэгээд дэгийн асуудал ямар байх нь вэ?

Тэр юун дээр түрүүн бас хэлчихлээ. Эмэгтэй малчин чинь 12 жил, 6 сар гэдэг нь хэвээрээ байгаа биз дээ. Би буруу сонсчов уу? Тэр нь 12 жил, 6 сар. Харин эрэгтэй нь 15 жил болсон байх. Тийм ээ? Ийм зүйлүүдийг хэлье.

Тэгээд Байнгын хороон даргаас тэр зарчмын зөрүүтэй саналын боломж байгаа юу гэдэг асуулт. Бусад нь санал байна.

**П.Анужин:** Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууж байна.

Өмнө нь эхний хэлэлцүүлэгт хөндөгдөөгүй энэ асуудлууд эцсийн хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй санал хураах боломжгүй ийм дэгтэй байгаа гэдгийг Цэвэгдоржийн Туваан гишүүнд хэлье.

Сая тэгээд маш олон үнэ цэнтэй саналууд хэллээ. Ц.Туваан гишүүн ер нь бас ажлын хэсэгт орж ажиллахдаа энэ саналуудаа өөрөө хэлсээр, хамгаалж, бас мэтгэлцэж шийдэх тал дээр маш идэвхтэй ажилласан.

Ер нь манай ажлын хэсгийн гишүүд, Сайнхүүгийн Ганбаатар, мөн энэ салбарт ажиллаж байсан Содномын Чинзориг, Ц.Туваан гишүүн нар энэ нийгмийн даатгалын санг хамгаалах, алдагдалгүй байх тал дээр бас хатуу байр суурьтай зогсож маш үнэ цэнтэй саналуудаа оруулж, маш идэвхтэй ажилласан гэдгийг би хэлэхийг хүсэж байна. Энд.

Бүгдээрээ хэлэлцэх асуудалдаа орёё.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд ээ,

Улсын Их Хурлын даргын өгсөн чиглэлийн дагуу болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2 дахь хэсэгт заасны дагуу ажлын хэсгээс эцсийн хэлэлцүүлэгт зарим саналуудыг бэлтгэж оруулж ирснийг Та бүхэнд танилцуулсан.

Гүйцээн боловсруулахаас энгийн горимоор анхны хэлэлцүүлгээр санал хураалгаж дэмжигдсэн боловч уг саналыг дахин хураалгах шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр дахин хураалгах нь зүйтэй гэж дэмжсэний дараа энгийн горимоор тухайн зарчмын зөрүүтэй саналыг хураалгах дэгтэйг Та бүхэндээ танилцуулъя.

Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу гүйцээн боловсруулах санал.

1.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож, үлдэгдлийг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.”

Санал хураалт. Ажлын хэсгийн санал. Дэмжинэ. Ажлын хэсгийн өчигдрийн боловсруулж оруулж ирсэн санал. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн, С.Одонтуяа гишүүн, М.Оюунчимэг гишүүн, С.Чинзориг гишүүн нар эсрэг дарсан байна. Тийм.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн санал гаргая.

**М.Оюунчимэг:** Саяын санал хураалтыг дахин явуулж өгөхийг хүсэж байна. Яагаад гэхээр сая нөгөө “Б” танхимд хуралтай байж байгаад ороод ирэх хооронд санал хураалт явагдсан байна.

Тэгэхээр дэмжиж байгаа тул дахин санал хураалт явуулж өгнө үү гэж хүсэхээр байна. Баярлалаа. Саяынхыг хүчингүй болгоод.

**Ц.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан саналаар саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

58.3 хувиар санал дэмжигдлээ.

Одоо санал хураалт. Түрүүн томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт явуулья.

70.6 хувиар дэмжигдсэн.

Санал хураалт явуулья. 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “байгууллагаас” гэснийг “үйлдвэрчний эвлэлээс” гэж өөрчлөх санал байгаа.

Энэ саналаар дахин санал хураалт явуулах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь дэмжиж байж энэ томьёоллоор бид санал хураалт явуулах юм.

Санал хэлэх гишүүн байна уу? Сайнхүүгийн Ганбаатар гишүүн санал хэлье.

**С.Ганбаатар:** Эрхэм гишүүд ээ, энэ саналыг дэмжиж өгөөч. Энэ ажлын дэд хэсэг болон ажлын анхны хэлэлцүүлгүүд дээр энэ “байгууллага” гэдэг үг байгаагүй юм.

Үйлдвэрчний эвлэлээс гэж явж байсан. Тэгээд эцсийн хэлэлцүүлгийн томьёолол дотор ороод ирсэн байна. Та нар маань дэмжээч.

Учир нь гэвэл Нийгмийн даатгалын хуулиас гадна Хөдөлмөрийн хууль, гурван талт хэлэлцээрүүдийн тухай хуулиуд дээр түншлэлийн бүхий л баримт бичгүүд дээр улсын гурван талт хэлэлцээрт ч гэсэн Монголын Үйлдвэрчний эвлэл, үйлдвэрчний эвлэл гэдэг үг явж байгаа.

Өнөөдөр нийгмийн түншлэл, нийгмийн даатгалын асуудал дээр эзэн биегүй байгууллага гэж хаяж болохгүй.

Өнөөдөр Монголд байгууллага гэдэг хуулийн этгээд нэг ч байхгүй. Энэ бол эзэн биегүй хаяна гэсэн үг. Тэгэхээр нийгмийн түншлэгч байгууллагаа яаж чадавхжуулах вэ, яаж хариуцлагажуулах вэ гэдэг дээр төр анхаарч ирсэн. Энэ

утгаараа үүнийг нь бүр устгаад алга болгочхож болохгүй ээ гэдэг санааг минь гишүүд маань дэмжинэ гэдэгт би итгэлтэй байна.

Ажлын хэсэг дээр гишүүд дэмжсэн. Инститацийн хувьд төр түншлэгчээ чадавхжуулж ингэж үйлдвэрчнийг дэмжиж байгаа явдал бол нийгмийн даатгалын шимтгэл бол татварын мөнгө биш. Энэ төрийн гэхээс илүү яг даатгал төлөгчдийн мөнгө. Шимтгэл.

Ингээд энэ дээр дэмжиж өгч туслаач ээ. Баярлалаа. Та нартаа баярлаж байгаа шүү.

**П.Анужин:** С.Ганбаатар гишүүнд баярлалаа.

Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтыг хэлэлцэх нь зүйтэй гэж үзэхийн тулд гишүүдийн гуравны хоёр дэмжсэн байх ёстой. Гишүүд ээ, санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдэж, уг саналын талаар санал хураах нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзлээ.

Одоо энгийн горимоор санал хураалт явуулна. Уншиж танилцуулъя.

Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “байгууллагаас” гэснийг “үйлдвэрчний эвлэлээс” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлгийг Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн, Цэвэгдоржийн Туваан нарын гишүүд дэмжсэн тул протоколд дэмжсэнээр тэмдэглэж үлдээнэ үү.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн нь бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийг томилж байна.

---

**Хоёр.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Васгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

---

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Эцсийн хэлэлцүүлэгтэй холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн, Содномын Чинзориг гишүүн нар асуулт асууна.

Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

**С.Чинзориг:** Би зүгээр үг хэлдэг юм уу.

С.Одонтуяа гишүүн яриад байх юм даа. Малчдын шимтгэлийг төр хариуцах юм байна. Болохгүй гээд л байх юм.

Нийт улсын хэмжээгээр байгаа ажиллагсдын чинь бараг л ч 20 хувь нь малчид эзэлж байгаа шүү дээ. 20 хувь нь 200-аад мянган малчид байдаг.

Тэгээд малчдын нийгмийн хамгааллын асуудал маш их олон жил орхигдож явж ирсэн. Ер нь малчин хүний хөдөлмөр бас амаргүй хүнд хөдөлмөр, цаг наргүй хөдөлмөр. Байгалийнхан аясаар байдаг. Байгаль цаг агаар сайхан бол малчид сайхан байна л гэдэг. Цаг агаар хатуурвал малчид тэгээд л хавчигнаад л, үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг л дандаа отор нүүдэл гээд явдаг шүү дээ.

Ер нь нар салхинд хамгийн их гандаж элээгдэж явдаг хүмүүс бол малчид. Малчдын хөдөлмөр бол амаргүй хөдөлмөр.

Тэр утгаараа өмнөх 4 жилд Их Хурал малчдын хөдөлмөрөөс амаргүй, хүнд хөдөлмөр гээд малчдын тэтгэвэрт гарах насыг өөрчлөлт оруулж байсан, шимтгэлийг нь нөхөн төлүүлэх асуудлууд бас шийдэж л байсан.

Малчид тогтмол орлогогүйн улмаас гишүүд ээ, сар болгон нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлж чадахгүй байгаа гэдэг ийм асуудал түгээмэл байгаа юм.

Нийт ажиллагсдын чинь 20 хувийг бүрдүүлж байгаа атлаа нийгмийн даатгалын төлөлт нь маш бага.

Одоо нийгмийн даатгалд сайн дураараа даатгуулаад шимтгэл төлж байгаа малчид нийт малчдын 20 хувь нь л байгаа шүү дээ.

Тэгээд энэ одоо ингээд удаан цаашаа үргэлжлэх юм бол малчдын нийгмийн хамгааллын асуудал дордоно. Нөгөө талдаа ажлын хэсэг ч яриад байна лээ.

Цаашдаа ингээд малчид нийгмийн даатгалын шимтгэл төлөлт нь муу байх юм бол 60 нас хүрэхээр бүгд улсын төсвөөс халамжийн тэтгэвэр авах ийм нөхцөл байдал руу л орно шүү дээ.

Тийм учраас малчдыг нийгмийн даатгалын төлөлтийг нь нэмэгдүүлэх, малчид нийгмийн даатгал, шимтгэл төлж сурах, хэвшүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Тэгээд энэ утгаар нь Засгийн газраас малчдын шимтгэлийн 50 хувийг төр хариуцъя. Гэхдээ энэ чинь тодорхой хугацаанд 5 жилээр л төр хариуцаад тэгээд хэвшүүлэх л ийм асуудал шүү дээ.

Тийм учраас үүнийг нь дэмжих нь зүйтэй болов уу гэж би бодож байна. Гэхдээ яах вэ нэгэнт зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас энэ дахиж хөндөгдөхгүй ингээд батлагдаад явчих болов уу гэж бодож байгаа юм.

Тийм учраас малчдыг нийгмийн хамгааллыг дэмжиж, сайжруулж зайлшгүй шаардлагатай.

Нөгөө талаас ер нь малчид энэ хөдөөгийн амьдралтай холбоотой, мал аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого,

малчдын хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг ч гэсэн бас Их Хурал зориуд бодлого болгож яримаар байгаа юм.

Ялангуяа малчдын залуу халааг бэлтгэх асуудал өнөөдөр тулгамдсан асуудал мөн үү мөн. Хөдөө хамгийн залуу малчин хэдэн настай хүн байна вэ гэхээр ер нь 40-өөс доош насны залуу малчин гэж ер нь байхгүй. Дандаа 40-өөс дээш насны залуу малчин л байна гэж л одоо ярьж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ малчдын нийгмийн даатгал шимтгэлтэй холбоотой асуудлыг Үндсэн хууль зөрчлөө гэж асуудал үүсэхгүй болов уу гэж бодож байна.

Тийм учраас үүнийг дэмжээд явах нь зүйтэй гэж ийм бас тайлбар хэлж байгаа юм.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлнэ.

**М.Оюунчимэг:** С.Чинзориг гишүүн маань нэгдлийг барьж яриад байна л даа. Өвөрхангайн малчдад энэ чухал байх.

Гэхдээ малчдыг бид зөвхөн 50 хувийг нь та нар төлчихвөл би 50 хувийг тэтгэврийг чинь даагаад өгье гээд гэдэг дэмжлэг малчдыг дэмжих дэмжлэг биш ээ.

Бид малчдаа дэмжье гэвэл харин малынх нь бүх төрлийн үр шимийг үнэ цэнд хүргэх, мал аж ахуйгаа эрүүлжүүлэх, хөгжүүлэх, татварын бодлогоор дэмжих, залуу малчдыг хөхиүлэн дэмжих үүднээс хөдөө орон нутагт очвол тэд нарт орон сууц, байр сав одоо өөр бусад хөнгөлөлтүүдийг

эдлүүлэх, тэднийг бэлтгэх гээд маш олон боломж байгаа.

Бараа, бүтээгдэхүүнийг экспортод гаргах тэр нөхцөлийг нь бүрдүүлэх ч боломж байхад зөвхөн малчдын нийгмийн асуудлыг бид шийдэх ёстой гээд ингээд 50 хувийг нь төр дааж байна. Энэ 50 хувь чинь тэгээд зүгээр нэг сангаас гарч байгаа мөнгө биш шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгө байхгүй юу.

Миний, надаас, танаас, тэнд хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсээс, ногоочдоос, жолооч нараас, тэр хүйтэнд наранд салхинд явж байгаа тариаланчдаас хүртэл гарч байгаа мөнгө шүү дээ.

Тэгэхээр нэг нь нийгмийн асуудлыг шийдэхийн тулд нөгөөдүүлээс нь мөнгө аваад төлнө гэдэг бол өөрөө дэндүү шударга бус зүйл байхгүй юу. Энэ бол ялгаварлан гадуурхалт.

Бид нийгмийн даатгалын багц хуулийн ийм чухал хуулийг, ийм том хуулийг ганц ийм буруу жишиг тогтоогоод татан унагаах нь өөрөө маш буруу жишиг.

Малчид ч гэсэн үүнийг бас дургүйцэж байгаа байх гэж би бодож байгаа. Яагаад гэвэл манай малчид бас их тийм өөр хүмүүс шүү дээ.

Мянгат малчид гээд хамгийн идээ будаа, цагаа бүх юм нь бэлэн зэлэн. Бид тэрийг ямар ч татвар төлдөггүй. Бүх талаар дэмжиж байгаа. Сая бас Азийн хөгжлийн банкны шугамаар малчдын хашааг нь бүгдийг нь бариад өгье гээд л төсөл орж ирж байсан.

Туслах малчид өнөөдөр хэдэн хувь нь байна. Жинхэнэ мянгат малчин, ажил олгогч малчин хэдэн хувь нь байна гээд



аваад үзэхэд энэ зөрүү нь цөөхөн юм байна лээ шүү дээ.

Туслах малчид та 50 хувиа төлчих өө. Төр таны 50 хувийг төлье. Тэгээд та халамжийн тэтгэвэрт орохгүйгээр нөхцөл бүрдэнэ гэж хэлбэл түүн шиг худлаа юм үгүй юм байна лээ.

Туслах малчид 50 хувийг нь төр даая гэсэн ч төлөхгүй. Бид нөгөө малчдын нийгмийн асуудлыг шийдэх гээд бас нэг хууль гаргаад 2020, 2021 онд хэрэгжүүлсэн 34 мянга орчим малчин л хамрагдсан гэсэн.

Энэ хууль хэрэгжихгүй байгаа учраас одоо дахиад ийм заалт оруулж ирж байна шүү дээ.

Малчдаа дэмжих, мал аж ахуйгаа, хөдөө аж ахуйгаа дэмжих нь бидний чухал зорилго, Монгол төрийн хар хайрцгийн бодлого. Гэхдээ ингэж ялгаварлаж дэмжих нь өөрөө буруу юм.

Одоо ингээд бусад сайн дураараа татвар төлж байгаа хүмүүс, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс, зах дээр бизнес хийж байгаа хүмүүс, махны ченж нар, өрхийн үйлдвэрлэл хашаандаа эрхлээд бас л мэдээж өдөр шөнөгүй тэр хүмүүс ажиллаж байна. Баялаг бүтээж байна. Ажлын байрыг бий болгож байна.

Тэгээд яагаад ийм үед миний мөнгийг авч өөр хүмүүстээ төлөх гээд байгаа юм бэ? Надад тэгвэл ямар дэмжлэг байгаа юм бэ гээд бид нарт одоо энэ ногоочдын холбооноос, тариаланчдын холбооноос, сая С.Ганбаатар гишүүн маань үйлдвэрчний эвлэл гэж байна. Тэд нарыг дэмждэг холбоодоос хүртэл бичгүүд ирж эхэлж байна шүү дээ. Хууль маань гараагүй байгаа дээр.

Ингэж би болохгүй ээ гэж бодож байгаа. Түүнээс бид малчдаа бүх талаар дэмжих нь зүйн хэрэг. Дэмжиж ч ирсэн. Харин ингээд ирээдүйд халамжийн тэтгэвэр эд нарт авхуулахгүйн тулд өнөөдөр ийм юм хийж байгаа гээд бодит бус тооцоо, хийсвэр тоо гаргаж ирчхээд тэгээд ингээд нэг айлгах ч юм уу, эсвэл нэг малчдыг сугалж авчхаад ингээд явна гэдэг бол байж болохгүй.

Энэ чинь өөрөө юу гээч. 50 хувийг нь төрөөс даана гэдэг чинь ядуу, орлогогүй хүмүүсийг ингэх халамжийн бодлого явж байна.

Тэгтэл малчид маань ядуу байна, хэд нь ядуу байна, хэд нь орлогогүй байна. Тийм тооцоо судалгаа байна уу.

Ер нь тэгдэг шүү дээ. Энэ халамжийн тэтгэвэр гэдэг чинь орлогогүй, ядуу гээд статус нь өөр ийм үндэслэл дээр тулгуурлаж төрөөс энэ хүмүүсийн тодорхой хэмжээгээр нийгмийн одоо нөгөө социал демократ гэдэг шиг одоо бас нэлээд амаргүй байгаа нэг хэсгээ нийгэмд татаж явъя гэж.

Тийм үүднээс халамжийн тэтгэврийн тухай асуудал яригддаг шүү дээ. Халамж, тэтгэвэр хоёр чинь өөр зүйл.

Гэтэл малчид маань тийм байна уу. Ядуу гэдэг эгнээнд хэдэн хувь нь орж байгаа юм, орлогогүй гэдэгт хэдэн хувь нь орж байгаа юм. Ингээд тооцоод үзвэл.../минут дуусав/

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн санал хэллээ.

Гишүүд үг хэлж, саналаа хэллээ. Нийгмийн даатгалын тэтгэврийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын

чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг томилж байна.

---

**Гурав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

---

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд оръё.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн санал хураалт явуулах зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

Энэхүү санал нь анхны хэлэлцүүлгээр зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэн учир нийцүүлэх хэсэгт өөрчлөлт оруулсан болно.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “зүйлийн 11.1, 11.2-т” гэснийг “хуулийн 11.1-д” гэж өөрчлөх санал байгаа.

Энэ саналаар дахин санал хураалт явуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

Мөн түрүүний явуулсан саналтай ижилхэн дэгийн тухай хуулийн 42.2.3-д

заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроор дэмжих ёстой. Хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь дэмжих ёстой. Санал хураалт явуулъя. /алх цохив/

75.0 хувиар гишүүд санал хураах нь зүйтэй гэж үзлээ.

Одоо санал хураалт явуулна.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “зүйлийн 11.1, 11.2-т” гэснийг “хуулийн 11.1-д” гэж өөрчлөх саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

75.0 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмааг томилъё.

Дараагийнхаа асуудалд оръё.

**Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Эцсийн хэлэлцүүлэгтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу гүйцээн боловсруулах санал хураалт. Нэг санал байгаа.

Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу гүйцээн боловсруулах нэг санал байгаа.

Тодорхой журмыг Засгийн газар батална гэснийг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл батална гэж өөрчилж байгаа. Санал хураалт.

1.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7, 14.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно.”

14.7.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний

төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.9.Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарыг томилж байна.

**Тав.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль  
хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай  
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Нийгмийн даатгалын  
ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан,  
анхны хэлэлцүүлэг/**

Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын тэтгэмжийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

1991 онд батлагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр байгаа юм.

Тиймээс энэ хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсныг та бүхэнд танилцуулъя.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай.

1 дүгээр зүйл. 1991 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Асуух, саналтай гишүүд байхгүй байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Анхны хэлэлцүүлэг дээр санал гараагүй учир дэгийн тухай хуулийн 39.22-г заасны дагуу анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нь нэгтгэн явуулах горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд ээ. /алх цохив/

54.5 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэнг томилж байна.

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд оръё.

---

**Зургаа.Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын  
Чингис хаан банкинд байршиж буй сангийн мөнгөн хөрөнгийг  
барагдуулах үйл ажиллагааны талаар болон  
Капитал банкны эрх хүлээн авагчийн  
мэдээлэл**

---

“Чингис хаан” банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар болон “Капитал банк”-ны эрх хүлээн авагчийн мэдээллийг сонсоно.

Ажлын хэсгийн гишүүд хэвэндээ. Ажлын хэсгийн гишүүд байж байна.

Мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

Үүн дээр энэ эрх хүлээн авагчтай банктай холбоотойгоор ажлын хэсгийн гишүүд нэмж ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Т.Дэлгэрхүү “Капитал банк” эрх хүлээн авагч, Р.Сансармаа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Ц.Сүхбаатар дарга Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Л.Төр-Од Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Б.Баяраа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Э.Энхжаргал Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Х.Буянжаргал Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Б.Даваахүү Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга, Э.Одонтуяа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ахлах аудитор, шинжээч, Н.Сэлэнгэсайхан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны мэргэжилтэн,

Б.Анхбаяр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, ажлын албаны аудитор, шинжээч, Н.Энэрэл Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Микрофонд Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн тайлан тавина.

**Х.Булгантуяа:** Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн болон “Чингис хаан” банканд байгаа Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг төлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Та бүхэнд танилцуулж байна.

“Капитал банк” дахь банкны эрх хүлээн авагчийн нэхэмжилсэн Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг төлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

Капиталын эрх хүлээн авагч томилогдсон хугацаанаас хойш төлбөр нэхэмжлэх, нэхэмжилсэн төлбөрийг төлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний дүнг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар 11 удаа хэлэлцэж, 6 тогтоол батлагдаж, гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд хандаж төлбөр барагдуулах дарааллыг Банкны тухай хуулийн 73.1.8 Засгийн газарт төлөх өр төлбөр, албан татвараас 73.1.5 даатгагдаагүй хадгаламжийн төлбөрт хамаарах талаар шийдвэрлүүлсэн ба Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд капиталын эрх хүлээн авагч төлбөрийг барагдуулахыг даалгах нэхэмжлэл гаргаж 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 182 дробь ШШ/2020 дробь 02419 тоот шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

Капиталын эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн 104.2 тэрбум төгрөгөөс 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 10.14 тэрбум төгрөг нь мөнгө хэлбэрээр, 25.06 тэрбум төгрөг нь хөрөнгөөр, нийт 35.2 тэрбум төгрөгийн авлага барагдаж, 69 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй хэвээрээ байна.

Холбогдох эрх бүхий байгууллагуудаас авсан зөвшөөрлийн дагуу 25.06 тэрбум төгрөгийн 78 ширхэг хөрөнгө хүлээн авснаас 8.4 тэрбум төгрөгийн үнэтэй 33 ширхэг хөрөнгийг 8.6 тэрбум төгрөгөөр борлуулж, 16.6 тэрбум төгрөгийн 45 ширхэг хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Хөрөнгүүдийг худалдан борлуулахаар 10 удаагийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулсан.

Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байсан 34 аж ахуйн нэгж, иргэнтэй түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж, 256.6 сая төгрөгийн түрээсийн орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж, хөрөнгийн ашиглалт хамгаалалттай холбоотой 44.2 сая төгрөгийн зардал гараад байгаа.

Капиталын эрх хүлээн авагчаас хүлээн авсан хөрөнгүүдийг үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагуудтай хамтран ажиллаж, гэрээгээр борлуулах талаар хэлэлцэн холбогдох шийдвэр гаргах, тус банкны удирдлага болон хөрөнгийн маргааны улмаас хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа асуудлууд шийдвэрлэхэд сангийн нэхэмжилсэн өр төлбөрт тухайн хөрөнгүүдийг тооцон авах зэрэг саналтай байгаа болно.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл саяхан Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бас тайлангаа танилцуулсан. Нөхцөл байдал бас мөн ижил түвшинд байгаа.

“Чингис хаан” банкнаас нэхэмжилсэн нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг төлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай Байнгын хорооны гишүүдэд танилцуулъя.

“Чингис хаан” банк нь 2019 оны 10 дугаар сараас нийгмийн даатгалын төлбөр тооцоог тухайн өдөрт нь гүйцэтгэж чадахгүй болсон тул Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2020 оны 9 дүгээр сард Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг гаргуулах тухай нэхэмжлэл гарган шүүгчийн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 181 дробь ШШ2020 дробь 02624 дүгээр захирамжаар нэхэмжлэлийг бүрэн хангаж, “Чингис хаан” банкнаас 101.7 тэрбум төгрөгийг гаргуулж Нийгмийн даатгалын ерөнхий газарт олгохоор шийдвэрлэсэн.

Энэхүү нэхэмжилсэн дүнгээс 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийтдээ 6.57 тэрбум төгрөг

төлөгдөж, төлбөрийн үлдэгдэл 95.2 тэрбум төгрөг байна.

“Чингис хаан банк” ХХК нь хувьцаа эзэмшигч “Нью Стандарт Финанс” ХХК нь 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр “Баянмөнх техник дэвшил” гадаадын гадаадын хөрөнгө оруулалтын ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулж уг банкны энгийн хувьцааг “Баянмөнх техник дэвшил” гадаадын хөрөнгө оруулалттай хувьцаат компани худалдан авахаар шийдвэрлэж зөвшөөрөл авахаар холбогдох баримт бичгийг Монголбанканд хүргүүлсэн тухай мэдээллийг гэрээ байгуулсан талууд болон Монголбанкнаас тус тус ирүүлээд байгаа.

Худалдан авагч тал болох “Баянмөнх техник дэвшил” нь үндсэн төлбөр болох 64.3 тэрбум төгрөгийг 2023 оны 7 дугаар сараас 2025 оны 6 дугаар сар хүртэл 24 сарын хугацаанд хүү болох 30.9 тэрбум төгрөгийг үндсэн төлбөрт төлөгдөж дууссаны дараа буюу 2025 оны 6 дугаар сараас 2027 оны 6 дугаар сар хүртэл 24 сарын хугацаанд нийтдээ 48 сарын хугацаанд төлөх саналыг гаргасан байгаа.

“Чингис хаан” банкнаас нэхэмжилсэн төлбөр 95.2 тэрбум, капиталын эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн төлбөр 69 тэрбум, нийтдээ 164.2 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ төлбөрийн барагдуулалт удаашралтай. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газар дангаараа шийдвэр гарган хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байгаа юм.

Иймд дээрх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан.

Мөн капиталын эрх хүлээн авах учраас хүлээн авсан хөрөнгүүдийг үл хөдлөхийн хөрөнгө зуучлалын байгууллагуудтай хамтран ажиллаж борлуулах, “Чингис хаан” банкныг худалдан авахаар гэрээ байгуулсан “Баянмөнх техник дэвшил” гадаадын хөрөнгө оруулалттай ХХК-тай төлбөр төлөх хуваарийг баталсан гэрээ байгуулах зэрэг холбогдох шийдвэрүүдийг гаргуулах саналтай байна.

Тус яамнаас Засгийн газрын хуралдаанд бас энэ асуудлыг танилцуулсан.

Тэгээд өнөөдөр Байнгын хорооны хуралд бас танилцуулаад цаашид Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Нийгмийн даатгалын сан бол төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг болж Улсын Их Хурлаар төсөв нь батлагддаг байгаа.

Тийм учраас Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл үүнийг холбогдох Байнгын хороондоо танилцуулж хамтран шийдвэрлэх нь зүйтэй юм гэж үзэж өнөөдөр Байнгын хороондоо танилцуулж байна.

Энэхүү асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

**П.Анужин:** Танилцуулга хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Хүрэлбаатарын Булгантуяад баярлалаа.

Нийгмийн даатгалын сангийн өр, авлагыг барагдуулах талаар Капитал банкны эрх хүлээн авагч Т.Дэлгэрхүү

мэдээлэл хийнэ. 3 номерын микрофоныг нээж өгье.

**Т.Дэлгэрхүү:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Эрүүл мэндийн болон Нийгмийн даатгалын сангийн төлбөр барагдуулалт болон ер нь энэ татан буулгах ажиллагааны энэ 4 жилийн дэлгэрэнгүй тайланг 01 сарын 17-ны өдрийн Байнгын хорооны хуралд танилцуулсан.

Өнөөдрийн хувьд зөвхөн энэ хоёр сангийн тоонуудыг авчирлаа.

Сая Х.Булгантуяа сайдын танилцуулга дээр тоонуудыг нь хэлчхэж байна. Энэ хугацаанд 10.1 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 25.1 тэрбум төгрөгийг хөрөнгөөр, ингээд 35.2 тэрбумын барагдуулалттай, 69 тэрбумын үлдэгдэлтэй байна. Нийгмийн даатгалын сангийн хувьд.

Энэ дээр татан буулгах ажиллагаатай холбоотой 2020 оны Их Хурлын 32 дугаар тогтоол гарсан.

Энэ тогтоолоор нэлээн хэдэн байгууллагуудад үүрэг өгсөн. Улсын Ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, эрх хүлээн авагч нарт хураагдсан хөрөнгүүдээс өр төлбөрийг түргэн шуурхай барагдуулах үүрэг өгсөн.

Энэ хүрээнд сая нийгмийн даатгалынхны танилцуулга дээр орчихлоо.

Тэгэхээр энэ хэсгийг алгасчихъя. Ер нь Их Хурлын тогтоол гарсан. Засгийн газрын хуралд хоёр удаа орсон. Зөвлөлүүдийнх нь хурлууд гарсан. Өөрсдийнх нь шийдвэрүүд, хүсэлтүүд ирсэн.

Мөн төрийн өмчийн бодлого зохицуулалтын хурлууд, төрийн байгууллагууд үнэнч авч байгаа учраас тодорхой шийдвэрүүд нь гарсан.

Ингээд хөрөнгүүдийг хүлээж авсан. Энэ хүлээж авсан хөрөнгүүд бол эрүүл мэнд, нийгмийн даатгал хамгийн гайгүй гэсэн хөрөнгүүдийг нь дангаараа сонгож авсан хөрөнгө байгаа шүү.

Бусад өчнөөн төлбөр авагч нар байгаа. Тэгэхдээ энэ хоёр байгууллага шилж сонгож байгаад хамгийн гайгүйг нь хүлээж авсан. Хөрөнгийн хувьд эхний хоёр жил мөрдөх байгууллага, прокурорын байгууллага хоёр нь битүүмжилчихсэн.

Тэгэхээр хөрөнгө битүүмжилчихээр дуудлага худалдаа явуулж болдоггүй. Нөгөө хөрөнгийг нь мөнгө болгож болдоггүй. Энэ хоёр байгууллага нь мөнгөө нэхэмжлээд байдаг. Прокурорын байгууллага битүүмжилчхээд татан буулгах ажиллагааг ингээд зогсоочоод байсан.

Үүнийг бүх шатад нь ярьсаар байгаад тодорхой шийдэлд хүрээд ингээд дуудлага худалдааг 2021 оноос жигдрүүлж эхлүүлсэн.

Хөрөнгийн үнэлгээний хувьд энэ авч байгаа хоёр байгууллага өндөр байна гээд байдаг. Тэгтэл эрх хүлээн авагчийн зүгээс ингээд тендер зарлаад хөрөнгүүдийг үнэлүүлсэн. Прокурор орж ирээд бүгдийг нь битүүмжилчхээд төрийн байгууллагын хохирол өндөр байгаа учраас дахиж үнэлүүлнэ гээд үнэлгээ тогтоогоод өгчихсэн. Тэр үнэлгээг нь эрх хүлээн авагч бууруулж чаддаггүй. Авсан хүмүүс нь өндөр байна. Авах болохоор өндөр байна гээд байдаг. Прокурорын байгууллага нь болохоор



бид үнэлүүлчихсэн гээд. Ингээд үнэлгээний асуудал яригдаад байдаг.

Хөрөнгө бол худалдан борлуулагдаад, мөнгө төлөгдөөд, гэрээ байгуулагдсаны дараа прокурор битүүмжээр суллаж өгч ингэж явж байсан.

Одоо бол энэ байгууллагуудад бүх хөрөнгүүдийг өгсөн. Энэ дээр бүх хөрөнгө энэ чинь бүгдээрээ хоёр удаагийн үнэлгээтэй, битүүмжтэй, хөрөнгө алдагдах ойлголт байхгүй, үнэлгээ буурах ойлголт байхгүй. Чанар байдал муудаж байгаа. Мэдээж 4 жил болж байгаа. Зардлууд гарч байгаа.

Энэ дуудлага худалдаагаар худалдан борлуулагдахгүй үнэ өндөр гэдэг асуудал нийгмийн даатгал дээр очоод ч адилхан, капитал дээр байгаад ч адилхан. Энэ дээр ерөөсөө хуулийн байгууллагуудын оролцоотой үнэ тогтоочихсон болохоор ингээд дээшээ доошоо болгож болдоггүй ийм асуудал байгаа.

Эдгээр байгууллагуудаас албан бичгээр дандаа ирдэг. Үнэ өндөр байна гэдэг. Үнээ бууруулах боломжтой юу гэдэг ийм байгаа.

Одоо үлдсэн хөрөнгүүд бол энэ хоёр байгууллагын сонгоогүй хөрөнгүүд байгаа.

Одоо баланс дээр 375 орчим тэрбумын өр төлбөр байна. Эндээс бараг 40-өөд хувь нь энэ хоёр байгууллагын өр төлбөр байна. Хөрөнгүүдийг дахин санал болгосон аль аль байгууллагууд нь авахгүй ээ гэж хэлсэн.

Хөрөнгүүдийн хувьд бол байдал ийм байна. Ихэнх нь эрүүгийн хэрэг дээр шалгагдаад одоо банкных нь төв байр

гэдэг ч юм уу, банкн дээрээ байдаггүй. Тэгээд эрүүгийн хэрэг дээр шалгагдаад, тодорхой шийдвэр хуулийн байгууллагууд бол гаргаж өгөөгүй явж байгаа.

Энэ эрүүгийн хэрэг дээр бол энэ хоёр байгууллагынхан оролцож явахгүй байгаа. Энэ дээр эрх хүлээн авагч л хохирогч иргэний нэхэмжлэгчээр оролцоод анхан шатны шүүхийн шийдвэр гарсан.

Уг нь эхний шүүхийн шинжээчийн дүгнэлт 223 тэрбум гэж гарсан боловчиг дахиж шинжээчийн дүгнэлт гаргаад 104 тэрбум болгочихсон. Тэгээд энэ дээр бид гомдол гаргаад давж заалдах шатны шүүхэд хандчихсан байгаа.

Анхан шатны шүүх хурал нь мартер болсон. Давж заалдах шатны шүүх хурал нь наадмаар болох юм шиг байна лээ. Хэвлэлийн мэдээллийн байгууллагуудад мэдээлэл өгсөн боловчиг устгуулаад алга болгочихдог. Хэвлэл мэдээллийн байгууллага энэ капиталын шүүх хурал дээр хэн нь ч очоогүй. “Ийгл телевиз” очсон боловчиг нөгөө улсууд нь шүүхийн арын хаалгаар гараад ингээд яваад өгчихсөн. Одоо давж заалдах шатны шүүх хурал бол яг наадмын өмнө товлогдчихсон одоо товлогдохоор байгаад байна.

Тэгэхээр энэ дээр эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагууд оролцоод хохирлоо энэ буруутай этгээдээс нэхэмжлээд явах ажиллагаа дутмаг байна гэдгийг энэ 4 жилийн хугацаанд хэлмээр байна.

Ердөө энэ капиталын эрх хүлээн авагчаас л нэхэмжлээд байдаг. Тэгтэл энэ дээр байгаа зээл, энэ дээр байгаа хөрөнгө чинь бүгд бүгдээрээ хуулийн

байгууллагын битүүмжтэй, үнэлгээтэй. Бүх чанаргүй зээлүүд нь шүүхээр шийдвэрлэгдчихсэн. Одоо шийдвэр гүйцэтгэл дээр 250-аад ажиллагаа байна.

Энэ Их Хурлын тогтоолоор шийдвэр гүйцэтгэх байгууллага нь бас үүрэг хүлээсэн. Одоо үүнээс хойш дахиад 3 жил болж байна. Уг нь хамтарч ажиллаад л байгаа. Тэгээд мэдээж тал талын нөхцөл байдлуудаас болж байгаа байх. Зээлдэгч нарын зээлээ төлөх чадварууд муу байна.

Өнөөдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 133 тэрбум төгрөг байна. Эндээс хэвийн буюу одоо ихэнх нь ипотекийн зээл 2049 он хүртэлх зээл 9.7 тэрбум байна. Хувиараа тохироод төлөөд явж байгаа 4.1 байна. Шүүх дээр 20.3 тэрбум байна. Бүтэн 4 жил шүүх дээр хэргийг гацаадаг. Нөгөө талуудаас. Мэдээж хуульч, өмгөөлөгч нар авчихдаг. Янз бүрийн байдлаар гацаадаг. Одоо ингээд анхан шатын шүүх дээр 4 жил болж байгаа хэрэг хүртэл байна.

Энэ нь нөгөө холбогдох этгээдүүдийнх нь зээл. Шүүхээр шийдвэрлэсэн 18.7 тэрбум төгрөгийн зээл явж байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дээр 38.7 гээд энэ 2 нийлээд 56, 57 орчим тэрбум төгрөг шийдвэр гүйцэтгэл дээр байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дээр зогсчихсон ажиллагаанууд байна. Мэдээж зээлдэгч нь нас барчихсан, хөрөнгө нь шатчихсан ч юм уу, эсвэл байгаа хөрөнгөө өр төлбөртөө өгөөд дуусчихсан. Өөр төлөх хөрөнгө байхгүй.

Эрэн сурвалжлагдаж байгаа зээлдэгч нар 1.2 тэрбум төгрөг байна. Энэ дээр маш том дүн байгаа. Гэмт хэргийн холбогдолтой шалгагдаж байгаа гээд

одоо энэ хуучин удирдлагуудтай нь холбоотой зээлүүд 38.5 тэрбум төгрөг гээд. Энэ дээр эрх хүлээн авагчаас зөндөө гомдол гаргасан.

Мөрдөх байгууллагаас асуудал тус бүрээр нь шийдвэрлээгүй, цогцоор нь шийдвэрлээд анхан шатын шүүхээс өмнөх удирдлагуудын банкийг төлбөрийн чадваргүй болсон гэм буруутай нь тогтоогдож байна.

Мэдээж түрүүний хэлсэн тэр шинжээчийн 104 тэрбум төгрөг гэдгээр шийдвэрлээд анхан шатын шүүхээс тэнсэн харгалзах байдлаар шийдвэрлэсэн.

Энэ дээр бид тэр хүн дээр ял өгөх дээрээ биш, төрийн байгууллагуудын хохирлыг дутуу тогтоосон байна гэдэг дээр давж заалдах гомдлоо гаргаад ажиллаж байна.

Хөрөнгүүд хэцүү хэцүү. Хамаг олигтойнуудыг нь авсан гэдгийг нь хэлсэн. Энэ хоёр байгууллага бусад төлбөр авагч нараас давуу талаар авсан гэдгийг дахиад хэлье.

Одоо үлдэж байгаа хөрөнгүүд цөөн тоотой боловчиг үнэ нь өндөр. Одоо жишээ нь ингээд банкныхаа төв байрыг 19 тэрбумаар баланс дээрээ бүртгэчихдэг. Энэ банкаа эрүүл харагдуулах гээд байдаг. Тэгтэл одоо энэ чинь 3 давхар, хэдэн зуу, хоёр мянга хэдэн зуун метр квадрат байр. Тэгтэл бараг Улсын Их Дэлгүүртэй адилхан үнэлгээгээр баланс дээрээ бүртгэчихсэн.

Игээд үүнийг нь хуулийн байгууллагуудаар үнэлүүлэхээр Монголбанкнаас томилогдсон эрх хүлээн авагч очоод хөрөнгө үнэгүйдүүлээд байна гээд худлаа хов жив тараадаг.

Гэтэл энэ үнэлгээг нь би өөрөө ч хийчихсэн юм биш. Хуулийн байгууллага үнэлээд өгчихсөн үнэлгээ байж байдаг.

Дээр нь энэ банкных нь төв байран гээд өр төлбөр тооцоод өгье гэхээр банкн дээрээ байдаггүй. Цагдаагийн мөрдөх байгууллагад шалгуулсан боловчиг шийдвэрлэж өгөөгүй. Одоо бид нар дахиад иргэний журмаар шүүхэд хандаад л явж байна. Гэх мэтчилэн ингээд маргаантай гурав, дөрвөн том хөрөнгүүд байгаад байдаг юм.

Бусад хөрөнгүүд ерөнхийдөө 21 аймгаар тарсан жижиг хашаа байшин ч юм уу. Одоо Баян-Өлгийд ч юм уу, Замын-Үүдэд ч юм уу. Одоо ингээд муунууд нь.

Энэ хашаа байшингууд нь болохоор яах вэ, тухайн үедээ зээлдэгч нар нь зээлээ хаахдаа өр төлбөртөө тооцоод өгчихсөн. Өөрсдөө дотроо амьдарч байдаг. Буцаагаад худалдъя гэхээр үнэ өндөр байна. Би ийм төлбөрөөр өгөөгүй гэсэн нэг иймэрхүү тайлбарууд хэлээд байдаг юм.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол одоо мэдээж тодорхой. Шүүхийн шийдвэр гарчихсан. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаа дуусгавар болгоно. Энэ хөрөнгийн асуудлуудаа шийдүүлнэ.

Эрүүгийн хэрэг дээр давж заалдчихсан байгаа. Одоо энэ дээр ингээд шүүхийнх нь ажиллагааг одоо дуусгавар болгуулна.

Энэ дээр нэг асуудал байгаа нь анхан шатын шүүхийн шийдвэр дээр прокурор давж заалдах шатын шүүх рүү эсэргүүцэл бичээгүй. Төрийн байгууллагыг төлөөлж байсан.

Түрүүн хэлсэн 2020 оны тогтоол, 32 тоот Их Хурлын тогтоол гарсан. Яах вэ, прокурорын байгууллагууд үүрэг өгсөн л дөө. Тэгтэл прокурор энэ анхан шатын шүүхийн шийдвэр дээр гомдоогүй. Хугацаа нь мэдээж аль дээр өнгөрсөн.

Энэ дээр эрх хүлээн авагчийн зүгээс энэ төрийн байгууллагуудын хохирол байгаа учраас давж заалдсан гэдгээ хэлсэн.

Энэ шүүхийн ажиллагаанд энэ хохирсон хоёр байгууллагаас хэн нь ч оролцоогүй. Зөндөө олон тэрбум төгрөгийн хохиролтой байж энэ эрүүгийн ажиллагаанд дээр ерөөсөө оролцоогүй.

Одоо ерөөсөө ганцхан эрх хүлээн авагч л оролцоод л яваад байгаа.

Энэ байгаа бүх нөхцөл байдлын талаар бид Монголбанкандаа тайлангаа өгч байдаг. Нэмээд яах вэ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд энэ тодорхой болсон фактуудыг хүргэсэн. Үүгээрээ бид прокурорын байгууллага, шүүхийн байгууллагад нөлөөлж байгаа зорилго байхгүй.

Ямар ч байсан ийм явдлууд болоод байна шүү. Цаг хугацаа ингэж яваад байна шүү гэдэг байдлаар байгаа.

Тэгээд мэдээж байгаа актив бол чанаргүй. Одоо байгаа энэ 133 тэрбум гэдэг чинь зөвхөн зүгээр бүртгэлийн дүн. Монголбанк, Сангийн сайдын баталсан тэр актив ангиллын журмаар бол үүний чанаргүй. Чанаргүй гэдэг чинь бол энэ чинь ерөөсөө бодитой 9, 10 тэрбум орчим руу буухаар л ийм цэвэршүүлж бүртгэж байгаа.

Тэгээд энэ чанаргүй зээлүүд бүгд 100 хувь төлөгдөнө гэдэг бол эргэлзээтэй. Чанаргүй юм чинь.

Хөрөнгийн хувьд энэ их маргаанууд одоо 4 жил болчихоод байхад шийдэгдэхгүй юм. Энэ нь ихэвчлэн одоо тэгээд шүүхийн ажиллагаа. Дээр нь захиргааны байгууллагуудын ажиллагаа байна. Газрынх нь асуудал шийдэгддэггүй.

Жишээ нь, Замын-Үүдэд нэг газар байхад Замын-Үүдийнх нь Засаг дарга хууль бус шийдвэр гаргаад тэр газрыг нь хүчингүй болгочихдог. Тэрийг нь хоёр, гурван жил шүүхдэлцэж байж буцаагаад шүүхээр ялж байж буцаагаад авсан. Одоо тэрийг нь дахиад энэ төрийн байгууллагын өр төлбөр тооцож өгөх гээд явж байна. Гэх мэтчилэн.

Ихэнх энэ цаг хугацаа алдаж байгаа юмнууд бол мэдээж эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалтай хамаараад. КОВИД мэдээж хоёр жил гаруй болсон. Үүгээр зээлдэгч нар зээл төлөхөд хэцүү байсан.

Ихэнх удаж байгаа шалтгаан нь төрийн байгууллагуудын удаан байдал, шийдвэр гаргалтаас болоод удсан юм. Баярлалаа.

**П.Анужин:** Нийгмийн даатгалын сангийн өр, авлагатай холбоотой маш тодорхой мэдээллийг. Одоо үг хэлэх дээр таныг авчихъя. Тэгэх үү?

Маш тодорхой мэдээллийг хийлээ. Нэг зүйл бодогдож байна. Яг энэ асуудлын тайланг бид нар сонсож байхад өнөөдөр Монгол Улсын Их Хурлаар Нийгмийн даатгалын багц хуулийг бид хэлэлцэх гээд л. Тэгээд энэ хуулийн маань гол цөм болсон итгэлцүүрээ нэг шинэчилчихвэл ард иргэдийн маань энэ

нэг тэтгэвэр, тэтгэмж зөв бодогддог болох юм даа. Одоогийнхоо инфляцтай уялдуулаад нэмэгдэх юм даа гээд.

Энэ тэтгэвэр, тэтгэмжээ жил бүр инфляцтай уялдуулж нэмэгдүүлэх юм даа гэдгийг шийдэхийн тулд бид ингээд л 200 тэрбум төгрөг орчим яриад байгаа шүү дээ.

Том хэмжээний шинэтгэл хийхэд л нэг зүйл, заалт дээр 200-аад тэрбум төгрөгийн асуудал шийдчихвэл энэ хүлээж байгаа настайчуудын маань, ард иргэдийн маань асуудал шийдэх гээд байна гээд л 200 тэрбум төгрөг хүргэж ядаж байхад яг нөгөө талаар нь аваачаад л хэдэн зуугаар нь ингээд 200 тэрбум тэрбумаар нь ингээд алдаад явчихдаг.

Нэг талдаа алдаад, нөгөө талдаа олох гэж энэ хуулийн шинэчлэлийг хийх гэж тамаа идэж үе үеийн ерөөсөө Их Хурлаар орж ирж чаддаггүй босго давдаггүй гол асуудал энэ төсвийн тооцоолол байсан.

Тэгтэл нөгөө талдаа алдсан мөнгөө төр нь олж чаддаггүй. Хулгайчдаа тодруулж тодорхойлж чаддаггүй. Ялыг нь өгч чаддаггүй. Ингээд Байнгын хорооны хурал дээр ингээд авч чадахгүй байна, ингээд хуураад байна, авахаар ч юм тэндээс нь алга байна гэдэг л юм бид сонсож байна.

Энэ бол бас Монгол төрийн эмгэнэл, хууль завхарсан байдал, энэ байдал дээр ард иргэдийн дургүй маш их хүрч байгаа юм.

Тэгээд энэ удаагийн Засгийн газар харин энэ эдийн засгийн өсөлттэй байдал дээр хамгийн түрүүнд хийж авч хэрэгжүүлж байгаа алхам бол тэтгэврийн энэ суурь шинэчлэлээ хийе гэдэг том

шийдвэрийг гаргаж энэ хууль ингээд хэлэлцэгдээд явж байна.

Тэгээд энэ их зөрүүтэй байдал, эдгээрийг бид яаж шийдэх ёстой вэ гэдгийг нэг талдаа шийдэж, цаашдаа энэ тэр гэлгүйгээр одоо энэ хөрөнгийг нь яаж үнэлэх юм, яаж энэ өр авлагаа барагдуулах юм гэдэг энэ тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Х.Булгантуяа болон холбогдох хүмүүс хийлээ.

Яг энэ асуудал маань өмнөх Нийгмийн бодлогын байнгын хороогоор орж ирсэн хэдий ч бид нар бас ахиж авч хэлэлцэж нухацтай хандах нь зүйтэй юм гэсэн гишүүдийн санал дээр үндэслэж өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дээр ахин хэлэлцэгдэж байгаа гэдгийг би бас Байнгын хорооныхоо гишүүдэд хэлье.

Тайлантай холбоотойгоор гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Гишүүд үг хэлэхийн өмнө нь Ц.Сүхбаатар дарга үг хэлнэ. Тийм ээ. Нэмэлт мэдээлэл өгье гэж байна.

Ц.Сүхбаатар дарга Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн үг хэлнэ. 2 номерын микрофоныг өгье.

Асуулт асуух гишүүдийн нэрсийг авчихъя. Микрофон асчихсан байна. 2 номерын микрофонд үг хэлүүлчхээд нэр авъя. 3 номерын микрофоныг асаая.

**Ц.Сүхбаатар:** Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Тэгээд нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагыг барагдуулах энэ асуудал Улсын Их Хурлаар орж байгаа нь үндсэндээ нэг бодлын харамсалтай асуудал юм л даа.

Энэ чинь одоо ном журмаараа явсан бол ийм асуудлыг Их Хурал хэлэлцээд тэр банкнаас тэр байшин барилга, тэр юм ав гэж одоо асуудал шийдэх гэж байна шүү дээ.

Тэгэхээр би үүнийг Монголбанктай холбож хэдэн үг хэлье гэж бодсон юм. Монголбанк бол Монгол Улсын Их Хурлын байгууллага. Хэдийгээр хараат бус ч гэсэн. Монгол мөнгөний төрийн бодлого, бүх асуудлыг авч хэлэлцдэг.

Тэгэхээр 1996 оноос хойш би энэ зовлонд оролцож бас энэ даатгалын албыг удирдаж явсан хүний энэ зовлонг нь мэдэх юм. Энэ чинь 1996 оноос хойш л Монголд банк дампуурах асуудал чинь моод шиг болсон шүү дээ.

Үүнээс хойш энэ асуудлыг Монголбанктай холбож авч үзээгүйгээс болоод тэр Монголбанкны удаа дараагийн Ерөнхийлөгч нар ямар ч хариуцлага хүлээдэггүй. Яахаараа Монголбанк байгаад тэр жишээлбэл арилжааны банкууд чинь бизнесийн байгууллага ч гэсэн тэд нарыг чинь хянадаг, шалгадаг, тэр шалгуур үзүүлэлтүүд гээд байдаг шүү дээ. Хуульд. Банкнуудын тухай хуульд.

Ийм ийм шалгуур үзүүлэлтийг хангасан арилжааны банк Монголд үйл ажиллагаа явуулж болно гээд үүнийг нь Монголбанк хянадаг.

Тэгээд л банкууд дампуураад л байдаг. Монголбанкны захирал нь ажлаа хийж байгаад л тэгээд яваад өгдөг. Нөгөө дампууруулсан арилжааны банкны эзэд нь тэгээд л тэр бизнесээ орхиод л тэгээд яваад өгдөг.

Одоо энэ чинь Ард банк гэж байлаа. ХОТШ банк, Сэргээн босголт банк, ЭКСИМ банк, тэгээд л Хөрөнгө оруулалтын банк, Хадгаламжийн банк. Одоо нэрийг нь дурдаад барахгүй.

Энэ чинь 1997 оноос хойш энэ даатгалын хөрөнгө чинь хэд хэдэн тэрбумаараа алга болсон шүү дээ. Тэгээд зөвхөн энэ даатгалын байгууллагын санхүү дээр өмнө нь дампуурсан банкны 5.4 тэрбум төгрөг байгаа шүү дээ. Тэгээд саяын энэ эрх хүлээн авагчийн хэлж байгаа шиг ингээд л жил болгонд хуримтлагдаад л 27 жилийн өр, авлага одоо энд бүртгэлтэй байна шүү дээ.

Тэгэхээр энэ бол Монгол Улсын Их Хурал Монголбанкт хариуцлага тооцоогүйтэй холбоотой л гэж бид үздэг. Үүнийг бусад руу нь чихэж байгаа юм биш.

Тэгэхээр харилцах данс чинь улсын төсвийн харилцах, гаалийн харилцах ч гэдэг юм уу одоо энэ төсвийн том том байгууллагуудын харилцах дансанд байгаа мөнгө тэргүүн ээлжид гараад явчихдаг. Нэлээн сүйхээтэй үйл ажиллагаатай банкны бизнес хүмүүс тэр дансанд байгаа мөнгөө дампуурахаас нь өмнө гаргаад авчихдаг.

Тэгээд яагаад Монголбанк энэ арилжааны банк чинь ер нь дампуурлаа шүү гээд. Ялангуяа иргэдийн хадгаламж гэсэн үг шүү дээ. Энэ шимтгэл чинь. Энэ мөнгийг нь, хадгаламжийг тэргүүн ээлжид гаргадаг бол нийгмийн даатгалын шимтгэлийн мөнгийг гурав, дөрөвдүгээрт тавьдаг. Тэгээд үлдчихдэг байхгүй юу. Тэгээд сүүлд нь одоо энэ банкнуудын эрх хүлээн авагч гээд эд нар дээр нөгөө байшин барилга, элдэв хөрөнгө авах юм руу ингээд шилжээд явчихдаг. Ингээд л одоо дампуурлын ирмэг нь ингэж эхэлж байгаа шүү дээ.

Тэгэхээр миний бодлоор бол тэр нэг банк дампуураад л хэчнээн тэрбум төгрөг гаргаж чадахаа байлаа гэх тэрэнд хяналт тавиагүй тэр Монголбанкны Ерөнхийлөгч, хяналтын байгууллагын хүмүүс нь хариуцлага хүлээдэг байх хэрэгтэй шүү дээ.

Тэгэхээр нэг ч Монголбанкны Ерөнхийлөгчид энэ арилжааны банкнуудаа удирдаж, зохицуулж чадаагүй, мэдээлэл өгөөгүй. Үгүй ээ яахаараа жилийн өмнө наад банк чинь болохоо байлаа шүү гэж хэлж болдоггүй юм.

Тэр бүртгэл, тайлан дээр нь тэр үзүүлэлтүүд нь бүгд цагаан цаасан дээрээ хараар биччихсэн байж байгаа шүү дээ. Одоо энэ цаг агаарын мэдээтэй зүйрлээд хэлэхэд сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр өнөөдөр цастай, маргааш бороотой гээд яг хэлж байна шүү дээ. Үгүй ээ түүн шиг одоо наад банк чинь ер нь дампуурлаа шүү гэж. Зээл нь найдваргүй зээлүүдээр дүүрлээ шүү гээд ингээд хэлбэл тэр чинь эртнээс тэр харилцах дансанд байгаа мөнгөө хамгаалалтад авч болно шүү дээ. Эргүүлээд авна.

Тэгээд бид нар чинь энэ их мөнгийг чинь одоо яах юм бэ. Нийгмийн даатгалын ажилтан болгонд гэрт нь сейф хийгээд тавилтай нь биш. Хүргэн хүүгийн Жамц гуай шиг авдар саванд хийж байгаад хулгайч хулганад идүүлэлтэй нь биш. Энэ чинь банктайгаа л харьцана шүү дээ.

Тэгэхээр энэ бүх удирдлагыг Монголбанк зохицуулж, ялангуяа тэр төрийн, хүний мөнгийг шамшигдуулахаас нь өмнө одоо буцааж тэр байгууллагууд руу нь өгдөг ийм

асуудлыг хийдэггүй. Энэ асуудлыг хийгээгүйгээс болж энэ.../минут дуусав/

**П.Анужин:** Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Ц.Сүхбаатар үг хэллээ.

Одоо саяын тайлантай холбоотой гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг хамтдаа явна.

Түрүүний тэр тайлан дээр нэг ноцтой зүйл гарсан. Хамт хариулаад явчхаарай. Энэ хохирогч байгууллагууд ерөөсөө шүүхийн шатанд ирэхгүй байгаа гэж.

Эрүүл мэндийн даатгалын сан, нийгмийн даатгалын сан ирэхгүй байгаа юм уу? Үүнийг та гишүүдийн асуулттай хамт дараагийн хурал бас хүлээгдэж байгаа учраас үг хамт яваад нэгтгээд хариулаарай.

Хэрвээ ийм бол ноцтой шүү. Хөөцөлдөх хүнгүй болчихсон гэсэн үг байна шүү дээ. Хөөцөлдөх хүнгүй юм чинь хэн мөнгөө авах вэ? Асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя.

Бадарчийн Жаргалмаа гишүүнээр тасаллаа. Үг, асуулт хамтдаа шүү. Гишүүд ээ. Буланы Бейсен гишүүн асуулт асууна. Б.Бейсен гишүүний асуулттай нэгтгээд саяын асуултад хариулаад өгөөрэй.

**Б.Бейсен:** Энэ чухал асуудал орж байна л даа.

Тэгэхдээ энэ хугацаа алдсан, хариуцлага алдсан асуудал байна. Хохирсон байгууллагууд уг нь Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын газар үүнийг нэхэж авах ёстой.

Аль эсвэл энэ дээр эвлэрчхээд байна уу? Тэр орон сууцын асуудал гарсан шүү дээ. Бас юун дээр. Эрүүл мэндийн даатгал дээр. Ноцтой тийм юм байвал ер нь Байнгын хорооны дарга нь анхаараад шүүх юугаар шалгуулах хэрэгтэй байх.

Энэ өр, төлбөрийн асуудал дээр хураагдсан үл хөдлөх хөрөнгө болон улсын орлогоор хураагдсан эд хөрөнгөөс олсон орлогыг эдийн засгийн эргэлтэд оруулах гээд байгаа л даа. Гэтэл энэ Хөгжлийн банк чинь бүх аймгуудын эмийн сангуудыг хувьчилж авсан шүү дээ. Тэр чинь зориулалтын складтай. Дотроо бүр вакцин энэ тэр хадгалдаг юутай. Том эмийн сангийн нэгдсэн газар хувьчлаад авсан байгаа.

Үүнийг нь буцааж авсан уу? Аваагүй бол үүнийг аваад одоо энэ эмийн асуудал Үндэсний аюулгүй байдалтай бас холбоотой. Зориулалтын складтай шүү. Тэр чинь. Дотроо. Баян-Өлгий аймагт том эмийн сангийн удирдах газар байгаа. “Капитал банк” авчхаад. Үүнийг чинь контор, худалдааны төв болгоод ингээд яачихсан. Тэгээд барилга нь байж байдаг. Үүнийг буцааж Эрүүл мэндийн яам Эм, эмнэлгийн эрхлэгчийн газарт нь өгөх шаардлагатай байгаа.

Дараагийн асуудал. Гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй 6 зээлдэгч байна гэж байна. “Капитал банк”-ны өмнөх удирдлагуудтай холбоотой. 38.5 тэрбум гэж байна. Энэ “Капитал банк”-ны удирдлагууд нь байгаа юм уу? Яг хэн хэн гэдэг хүнтэй холбоотой юм. Үүнийг араас нь ороод хөөцөлдөх шаардлагатай юм шиг байна.

13 байршилд 56 тэрбум төгрөгийн нэр бүхий хөрөнгө байгаа юм байна. Энэ зүгээр газар яачхаад тэгээд нөгөө хуулийн байгууллагаар буцааж шийдвэр

гаргуулаад тэгж байна уу? Энэ талаар асууя.

Мөн энэ шүүхийн шатанд 19 зээлдэгчийн 20.3 тэрбум төгрөг. Тэгээд энэ шүүхийн байгууллагатай хуйвалдаад үүнийг буцаагаад байна уу? Одоо 4, 5 жил болж байна шүү дээ. Энэ чинь бараг.

Эрэн сурвалжлагдаж байгаа бас 57 зээлдэгч байгаа юм байна. Эд нарын талаар тодорхой мэдээлэл өгөөч. Энэ банкны удирдлагатай холбоотой байна уу? Энэ талаар асууя.

**П.Анужин:** 2 номерын микрофон эхэлж хариулаад. Дараа нь Нийгмийн даатгалын ерөнхий газар Ц.Ганцэцэг дарга хариулаарай. Эхлээд 2 номерын микрофонд хариулт өгье.

**Т.Дэлгэрхүү:** Энэ хоёр байгууллага оролцож байна уу гэдэг дээр.

Энэ хоёр байгууллагаас юу хийсэн бэ гэхээр дараалалтай холбоотой нэг шүүхийн шийдвэр гаргуулсан. Дараа нь иргэний шүүх дээр нэхэмжилсэн. Тэр бол үнэндээ ямар ч хэрэггүй ажиллагаа.

Яагаад гэвэл эрх хүлээн авагч үүнийг чинь өгөхгүй гэж хэлээгүй. Өгнө өө. Тоо нь ийм байна. Хуульд заасан арга хэрэгслээр дарааллын дагуу өгнө өө гэдэг л шүүхийн шийдвэр шүү дээ. Тэр бол нэг их том шүүхийн шийдвэр биш.

Хамгийн гол нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар энэ ажиллагааг явуулж байдаг мөрдөх байгууллага байна. Энэ дээр нь хяналт тавьж байдаг прокурор байна. Энэ дээр эхнээс нь энэ хоёр байгууллага өөрсдийгөө хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тооцоолж оролцож яваагүй.

Одоо энэ эрүүгийн хэрэг дээр хохирогч, иргэний нэхэмжлэгчээр энэ “Капитал банк” ХХК-г төлөөлөөд эрх хүлээн авч л оролцоод явж байна. Шүүх хуралд эрх хүлээн авч л оролцсон. Анхан шатын шүүх хуралд.

Энэ дээр оролцуулах, оролцуулахгүйг эрх хүлээн авч шийдэхгүй. Энэ дээр мөрдөгч, прокурор хоёр шийддэг. Энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа.

Б.Бейсен гишүүний асуултад хариулъя. Яг 01 сарын 17-нд энэ асуултаа асууж байсан.

Энэ аймгуудад байгаа тэр “Монгол эм, импекс” гээд компанийн эмийн сангууд, бүх эмийн сангууд “Капитал банк”-ны хөрөнгө бол биш. Холбоотой хуулийн этгээд бол мөн. Энэ дээр зарим үл хөдлөх хөрөнгүүд нь “Капитал банк”-ны баланс дээр байсан.

Эд нарыг энэ хоёр байгууллага авахыг нь аваад, худалдахыг нь худалдаад ингээд явсан байгаа юм.

Тэр орон сууц ярьж байна. Орон сууц дээр энэ хоёр байгууллага дээр асуудал байхгүй байх. Тэр чинь өр төлбөрт авсан 51 орон сууцыг энэ хоёр байгууллага хоорондоо ярьж байгаад 51, 49 ч билүү тэгээд хуваагаад авсан юм. Тэрийгээ банкны зээл болгоод мөнгөжүүлээд авчихсан. Тэгээд эд нар өөрсдөө аваагүй гэж би бодож байна. Мөнгөжүүлсэн. Тийм л ажиллагаа байсан байх.

Энэ шүүх дээр удаад байгаа ажиллагаа бол энэ чинь одоо ерөөсөө л энэ процессын хуулийн ажиллагаа. Маш олон янзаар уддаг. Тэгээд яаж л бол яаж л удаадаг ийм ажиллагаа байгаа юм.



Танилцуулга дээр би энэ хөрөнгүүдийг түрүүн уг нь тарааж өгөхдөө тодорхой хэлсэн юм. Тэгээд дахиад хэлье дээ.

Энэ 13 хөрөнгө, 56 тэрбум гээд байгаа. Энэ дээр одоо ингээд жишээ татаад түрүүн төв байрыг нь ярьчихсан. Уг нь банкны төв байр чинь банкныхаа нэр дээр гэрчилгээ нь байх ёстой шүү дээ. Тэгтэл ерөөсөө банкныхаа баланс дээр манай байр юм. Ийм өндөр дүнтэй юм гээд өөрийнхөө хөрөнгийн хүрэлцээ, шаардлага, тэр харьцаанууд дээрээ манай гээд яваад байдаг. Зардал мөнгийг нь гаргаад засаж янзлаад өөрсдөө хэрэглээд яваад байдаг. Гэрчилгээгээ Монголбанкныханд үзүүлдэггүй.

Ингээд сая эрх хүлээн авагч ирээд үзсэн чинь энэ банкных нь төв байр нь банкан дээрээ байхгүй. Өөр газраас зээл аваад явчихсан.

Миний сонссоноор тэр зээлээ бараг. Энэ Бишрэлтийн бусад компаниуд маш сайн яваад байгаа шүү дээ. Банк нь л муу хөрөнгүүдтэйгээ, муу зээлтэйгээ л үлдчихээд байгаа болохоос биш.

Энэ байраа өөрсдөө бараг буцааж авах нөхцөлтэйгөөр тэр олон улсын хөрөнгө оруулалтын банкнаас зээл аваад төлөөд дуусаж байгаа гэсэн аман мэдээ байгаа. Бид үүнийг мэдээж мөрдөгч шиг бусад бизнес рүү нь ороод шалгаад бүр хаалгаар нь ч орох эрх байхгүй шүү дээ. Юугаа ч үзүүлэхгүй шүү дээ.

Тэгэхээр Банкны хууль дээр юу гэж заасан бэ гэхээр хууль бус юм байвал эрх хүлээн авагч хуулийн байгууллагад хандана, мэдээлэл гаргана л гэсэн заалт байгаа. Энэ дагуу уг нь 4 жилийн өмнө гаргаад явсан. 4 ажлын хугацаанд мөрдөх байгууллага энэ төв байран дээр юу ч шийдэж өгөөгүй.

**П.Анужин:** Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууя.

Уучлаарай. Ц.Ганцэцэг дарга гүйцээж хариулна. 4 номерын микрофоныг нээж өгье.

**Ц.Ганцэцэг:** Б.Бейсен гишүүний асуултад нэмэлтээр хариулт өгье. Нийгмийн даатгалын ерөнхий газар. Ц.Ганцэцэг.

Эхний асуултын хувьд энэ хэрэг нь эрүүгийн хэрэг учраас, түрүүн бас банкны эрх хүлээн авагч хэллээ. Мөрдөн байцаагч, прокурорын түвшинд очиж байгаа.

Тэгэхээр нийгмийн даатгалын байгууллагын ерөнхий газрыг бас гуравдагч этгээдээр дуудах гэдэг юм уу ийм үйл ажиллагаа хийгдэхгүй байгаа учраас бид нар энэ дээр оролцож чадахгүй байгаа юм.

Нөгөө талаас бид энэ асуудлаар Авлигатай тэмцэх газар, мөрдөн байцаах газар, энэ шүүхийн байгууллагуудтай байнгын холбоотой албан бичгээр харьцсан, мэдээлэл авсан ийм байдлаар ажиллаж байгаа.

Хоёр дахь асуудлын хувьд Баян-Өлгий аймагт капиталын өр төлбөрт байгаа энэ “Эм, импекс” компанийн байрыг дуудлага худалдаагаар худалдаад үндсэндээ өөрөөр хэлбэл борлогдсон. 1.2 тэрбум төгрөг нийгмийн даатгалын санд төвлөрсөн. Мөнгөн хэлбэрээр орчихсон байгаа.

Гурав дахь асуудлын хувьд, орон сууцууд одоо энэ өр, төлбөрт хөрөнгөөр ирж байгаа. Нийтдээ манай байгууллагын хувьд 28 орон сууцыг хүлээж авсан. Үүнээс 18-ыг нь дуудлага худалдаагаар

үндсэндээ борлуулаад 3.5 тэрбум төгрөг нийгмийн даатгалын санд байршсан. Одоо 10 орон сууц 1.7 тэрбум төгрөгийн өртөгтэй.

Энэ нь нөгөө метр квадратын хувьд харьцангуй өндөр. Хүмүүс ипотекийн зээл гэдэг юм уу ийм юманд орж болохгүй байгаа учраас энэ байр дуудлага худалдаанд борлогдож өгөхгүй ингээд үлдэгдэлтэй байгаад байгаа.

**П.Анужин:** Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууя.

**Б.Жаргалмаа:** Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

“Капитал банк” болон “Чингис хаан” банкны өр авлагын асуудал шүүхийн шатанд бас дэндүү удаж байгаа. Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг үргүй зарцуулсан энэ хэрэг шүүхийн шатанд явж байгаа гэдэг энэ асуудал үнэхээр олон жил яригдаж байгаа.

Сая Ц.Сүхбаатар дарга ч гэсэн хэллээ. 1996 оноос хойш арилжааны банкнууд чинь болохгүй нь ээ гэдэг ийм зүйл ажиглагдаж байсан энэ цаг мөчөөс хойш ер нь банкнууд дампуурсан гээд.

Би бас өнгөрсөн Байнгын хорооны хурал дээр ч гэсэн Нийгмийн даатгалын ерөнхий хууль хэлэлцэж байхад одоо бид нар нийгмийн даатгалынхаа хураамжийг, сангийн хөрөнгөө эрх яаж бүрдүүлэх юм, яаж банкнуудад байршуулах юм. Өнөөдөр банк иймэрхүү нөхцөл байдал үүсгэсэн цаг мөчид бид нар баталгааг нь яаж авах юм бэ. Дахиж ийм асуудал үүсгэхгүйн тулд яах ёстой юм бэ гэдэг зүйлийг асууж байсан.

Гэтэл Монголбанкнаас тогтоосон системийн ач холбогдол бүхий

арилжааны банк цаашид арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламж гэдэг ийм нэр томъёоллоор хуульд орж байгаа.

Ер нь Монгол Улс өмнөх түүхэд ч гэсэн, түүхийн хугацаанд ч гэсэн Монголынхоо газрын доорх баялгаа гадагш нь гаргахдаа ямархуу үнэ ханштайгаар хэрхэн гаргаж байгааг өөрийн банкны системээрээ хянах тэр боломжгүй нөхцөл байдал үүссэнээс шалтгаалаад өнөөдөр бид нүүрснийхээ үнийг ямар үнэтэй зарцуулж байгааг ч мэдэхгүй хугацаа алдсан ийм гашуун түүх бидэнд байдаг.

Тэгвэл энэ түүх ингээд л давтагдаад л байгаа л даа. Одоо бид системийн ач холбогдол бүхий арилжааны банк гэдэг ийм нэр томъёоллоор оруулж ирэх гэж байгаа.

Би Монголбанкны эрх хүлээн авагчаас тодруулмаар байгаа юм. Ер нь бид энэ банкны систем болоод Монголбанк арилжааны банкнуудтай харилцах энэ харилцаа маань яг одоо нээлттэй байх гэдэг юм уу, алдагдалгүй байх, эргээд хариуцлага тооцох тэр боломжит хувилбараа явж чадаж байгаа юу, үгүй юу гэдэг зүйлийг асуумаар байна.

Нөгөөтээгүүр хоёр дахь асуулт. Хөрөнгийн үнэлгээг хийсэн компаниуд байна. Сая сүүлд ч гэсэн 2023 оны 1 дүгээр сард бас дахиад үнэлгээ хийлгэсэн гэсэн байна. Тийм ээ. “Дамно” гэдэг компаниар үнэлгээ хийлгэсэн. Дэндүү өндөр үнээр тооцсон энэ хөрөнгө борлогдохгүй хугацаа алдсанаас шалтгаалан үргүйдэх, үнэгүйдэх ийм нөхцөл байдал үүсэх юм биш үү.

Энэ үнэлгээ хийсэн компаниуддаа дахиж аудит оруулаад яг бодит үнэлгээ

мөн үү, үгүй юу гэдгийг хянах тэр боломж нь ер нь бий юу, үгүй юу гэдэг зүйлийг тодруулмаар байна.

Гуравдугаарт, хэвлэл мэдээллийн байгууллагууд ажиллахгүй байна, мэдээллийг өгөхгүй байна гэж. Би энэ дээр их гайхаж байна л даа.

Хэрэв үнэхээр хууль бус юм байгаа бол хэвлэлийнхэн маань шуураад орох ёстой. Хэвлэл мэдээллийнхэн ажиллах боломж нөхцөлийг нь бүрдүүлэхгүй байгаа юм болов уу? Яагаад оруулахгүй байгаа юм бол. Энэ дээр та нэг тайлбар өгөөч.

Мэдээжээр төрийн хөрөнгийг идсэн, уусан, шамшигдуулсан энэ хэрэгтэй холбогдуулан хэвлэлийнхэн бол хүчээ аваад ажилламаар юм. Ажиллахгүй байгаа шалтгаан нь юундаа байгаа юм бол гэдэг дээр та бас тайлбар хэлээч ээ.

Нөгөөтээгүүр Эрүүл мэндийн даатгалын сангийнхан бас одоо хоёр жилийн өмнө энэ өр төлбөрт авсан орон сууцыг худалдан борлууллаа гэдэг нэг ийм асуудал үүссэн. Мөнгөжүүлээд бас даатгалын сангаа бүрдүүлсэн бол болж байна.

Ер нь нийгмийн даатгалын сан ч гэсэн одоо байгаа энэ хөрөнгийг ашиглах, эргээд борлуулах өөрсдөд нь эрх бий юу? Зөвхөн одоо юу гэдэг ч юм одоо нийгмийн даатгалын сан гэлтгүйгээр Нийгмийн хамгааллын яам аваад шаардлагатай агентлагууд ч гэдэг юм уу, одоо хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ зориулсан ийм үйл ажиллагаа явуулах тэр боломж нь ер нь хуулиар байдаг юм болов уу?

Өөрөөр хэлэх юм бол одоо үхмэл хөрөнгө байлгаад байхаас илүүтэйгээр ашиглах тэр боломж бий юу гэдэг дээр

хуулийн гаргалгаа, боломж нь ер нь хэр байдаг юм бол гэж тодруулах гэсэн юм юм.

**П.Анужин:** 2 номерын микрофонд эхэлж хариулт өгөөд. Ц.Ганцэцэг дарга гүйцээж хариулья.

**Т.Дэлгэрхүү:** Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулья.

Миний хувьд татан буулгах ажиллагааг хариуцаж хийж байгаа.

Тэгэхээр Монголбанкийг төлөөлж байр сууриа илэрхийлэх боломжгүй.

Одоо байгаа зүгээр хуулийн зохицуулалтуудыг бол хэлэх боломжтой. 2008 онд ерөөсөө банкны харилцах хадгаламж тэр чигтээ төрөөс баталгаа гаргаад баталгаатай байсан.

2013 оноос ямар тогтолцоонд шилжсэн бэ гэхээр 20 сая төгрөг хүртэлхийг одоо энэ хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгоё гээд хуульчлаад Хадгаламжийн даатгалын корпорац гэдэг этгээд байгуулаад 20 сая төгрөг хүртэлх харилцах хадгаламжийг Монголбанкны Ерөнхийлөгчийн банкныг татан буулгах шийдвэр гаргаснаас ингээд 10 хоногийн дотор өгөхөөр хуульчилчихсан ийм хуультай явж байгаа.

Хөрөнгийн үнэлгээнүүдийн хувьд бол тийм. Яг хэлснээр нь одоо тэр үнэлгээний компаниуд өндөр үнэтэй тогтоочихсон асуудал бол нөгөө хуулийн байгууллагуудын хийлгэсэн үнэлгээ болчихоод байгаа юм.

Банкны тухай хуулиар банкны эрх хүлээн авагчийн хувьд хуулиар олгогдсон бүрэн эрх байгаа юм. Энэ хөрөнгийн үнэлгээг. Энэ чинь одоо бараг хорин

хэдэн удаа дуудлага худалдаанд орчихлоо шүү дээ. Тэгээд одоо 10 хувь хямдруулаад худалдан борлуулъя гэдэг боломж хуулиараа надад байгаа.

Бусад хуулиар яаж байна гэхээр тэнд шүүхийн ажиллагаа яваад байдаг. Тэнд прокурор битүүмжилчихсэн байж байдаг. Тэр ажиллагааны дундуур тэр үнэлгээг өөрчлөх боломж байхгүй байна л гэж хэлээд байгаа юм.

Энэ ажиллагаа дуусгавар болоод, энэ бүгд эрх хүлээн авагчид шилжээд ирчихвэл хөрөнгийн үнэлгээг дахиж авч үзэх бүрэн боломжтой.

2023 онд мэдээж бол 2021, 2022 он КОВИД-той байсан. 2023 оноос банкны хүүгээс авхуулаад санхүүгийн нөхцөл байдлууд өөрчлөгдсөн.

Тийм учраас тодорхой тооны өссөн байх боломжтой хөрөнгүүд дээр дахиж үнэлгээ хийлгэсэн юм. Тэгээд хийлгэхдээ яах вэ, тэр “Дамно” гээд энэ компанийг тэр хуулийн байгууллагын сонгосон компани юм. Эднийхээр нь хийлгээд яваад байгаа юм.

Яагаад гэвэл ерөөсөө нэг ийм худлаа хэл ам их яваад байдаг юм. Дуудлага худалдаа нууцаар хийж байна. Хөрөнгө хямдруулаад таньдаг хүндээ зараад байна. Үүнийг яах вэ, мэдээж хэн гаргаж байна гэхээр л нэг өмнөх удирдлагууд нь. Ингээд нэг ийм хов живийн юмаар. Тэгээд түүнд нь хүмүүс итгэдэг юм уу, яадаг юм.

Энэ чинь тэгээд л зурагтаар ч зар тавиад л, сониноор ч зар тавиад л нээлттэй дуудлага худалдаагаар оролцоод л ажлын хэсэгт нь эрүүл мэнд, нийгмийн даатгалынхан оролцож байдаг. Дуудлага худалдааны комисст байж байдаг. Дуудлага худалдаа явагдсаны дараа

мөрдөгчийн саналаар прокурор битүүмжийг нь бичиг баримтуудыг үндэслэж суллаж өгч байдаг. Ийм юман дээр ингээд нууцаар хямдруулаад зардаг ойлголт гэж байхгүй.

Тэр хэвлэлийн байгууллагууд бол л яг 01 сарын 17-нд би энд бүр 4 жилийн тайлан тавьсан. Энэ бол шууд явсан. Яах вэ, зарим нэг телевизүүдийн мэдээгээр орсон боловчиг дараа нь хасчихдаг юм байна лээ.

Сонин дээр бол хэвлэчихээр гайгүй юм байна лээ. Сайтуудын мэдээллийг устгуулчихдаг юм байна лээ. Тэгээд энэ дээр би мэдэхгүй байна. Яагаад хэвлэлийн байгууллагууд устгадаг юм. Бараг бүгдийг нь цугларч байхад нь хурал болох гэж байгаа шүү гэж зар хэлээд ирээрэй гэсэн. Ганцхан “Ийгл телевиз” ирээд л явсан. Шүүх бол оруулаагүй. Тэнд мэдээ тавиулах гэсэн юм гэсэн. Тийм юм болсон.

Хөрөнгө худалдан борлуулах энэ хуулийн зохицуулалтыг асуугаад байна. Банкны талдаа энэ бол татан буулгах ажиллагаа. Өр төлбөр барагдуулж байгаа ажиллагаа.

Тэгэхээр энэ хүрээндээ бид нар энэ сангуудад хөрөнгө өгч байгаа юм. Тэгэхдээ үүнийг чинь шахаж өгөөгүй. Эд нар чинь өөрсдийнхөө хүсэлтээр авч байгаа шүү дээ. Энэ бол өр төлбөр барагдуулах ажиллагаа.

Нийгмийн даатгалын сан бүрдэх, тэр мөнгөн хөрөнгөөр бүрдэх харилцаа бол тусдаа.

Тэгэхээр энэ хоёр өөр хуулийн хоёр өөр харилцаа яваад байгаа юм. Тэгэхээр энэ байгууллагууд өөрсдөө шийдвэрээ гаргаад, тэр дуудлага худалдааны журам гаргаад, эсвэл өөр

хүнээр худалдан борлуулах юм уу.../минут дуусав/

**П.Анужин:** Ц.Ганцэцэг дарга гүйцээж хариулья. 4 номерын микрофоныг өгье.

**Ц.Ганцэцэг:** Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулья. Нэмэлтээр.

Нийгмийн даатгалын байгууллага энэ өр төлбөрт авсан бараа, бүтээгдэхүүнийг, хөрөнгийг борлуулах ийм эрх бий юү гэж асууж байна.

Бид Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөрөө бас энэ асуудлыг оруулаад Үндэсний зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслэх, худалдан борлуулах журмыг батлуулсан байгаа.

Тэгэхээр энэ журмынхаа хүрээнд үндсэндээ үйл ажиллагаа явж байгаа. Энэ журмаар юуг зохицуулж байна гэхээр энэ “Капитал банк”-наас авсан нэхэмжлэл хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулж болно гэсэн ийм зохицуулалттай.

Энэ журмын дагуу нийтдээ 10 удаа дуудлага худалдаа зохион байгуулаад бид өнөөдрийн байдлаар энэ мөнгө болохгүй энэ 25 тэрбум төгрөг маань үлдээд байгаа юм.

Ер нь цаашдаа Эрүүл мэндийн даатгалын сантай ингээд бас харилцан туршлага судлаад байхад үл хөдлөх хөрөнгийг зуучилдаг байгууллагуудтай гэрээ байгуулаад энэ хөрөнгийг бас борлуулах ажил нь арай хурдан яваад байгаа юм болов уу гэсэн ийм асуудал бид сонссон.

Тийм учраас Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлдөө энэ дуудлага худалдаагаар борлогдохгүй олон дахин зарлаад хүн орж ирэхгүй, байгууллага орж ирэхгүй байгаа энэ асуудлыг үл хөдлөх хөрөнгийн зуучлал хийдэг ийм компаниудтай бас хамтран ажиллах боломжийг Үндэсний зөвлөлөөрөө хэлэлцүүлээд тодорхой хэмжээний чиглэл аваад явбал бид энэ ажлыг бас цааш нь үргэлжлүүлээд нэг төгрөг ч гэсэн оруулах ийм чин эрмэлзэлтэй байгаа.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Надад зүгээр нэг л асуулт байна.

Ямар ч байсан энэ “Капитал банк” дахь банкны эрх хүлээн авагч Т.Дэлгэрхүү дарга ажиллаж байгаа баг сайн ажиллаж байгаа.

Бид нар олон удаа үзлээ. Алдаа оноо юу байна. Хэвлэл мэдээллээр янз янзын юм гарч байна. Гэхдээ бодит байдлыг аваад үзэхэд үнэхээр энэ “Капитал банк”-ны аль болохоор өр төлбөрийг нь барагдуулчихъя. Үнэхээр эрүүгийн шинжтэй байвал тэрийг нь одоо тэр хууль хүчний байгууллага нь шийднэ биз.

Яг тэр хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудал, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой энэ тэр асуудал дээр мэргэжлийн үүднээс сайн ажиллаж байгаа юм байна лээ. Тэрийг нь бас хэлчихье гэж бодож байна.

Одоо энэ Үндсэн хуулийн цэц дээр нөгөө банкны хадгаламж эзэмшигчдийн холбоотой нөгөө 2013 онд гарсан нэг хууль байгаа шүү дээ. 20 саяас доошоо л одоо ингээд нөгөө эрхийг нь

хамгаална гээд. Үүнтэй холбоотой 20 саяас дээш бол яагаад хамгаалахгүй байгаа ч гэдэг юм уу. Энэ асуудлаар нэг цэцэд маргаан үүсгэгдээд би нөгөө Улсын Их Хурлыг төлөөлж байгаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ингээд очиж хамгаалах юм.

Одоо энэ “Капитал банк” бол хамгийн ганц кэйс юм байна лээ шүү дээ. 2019 онд “Капитал банк” дампуурсан. Тэгэхэд 20 сая төгрөг хүртэлх хадгаламж эзэмшигч хэдэн хувь нь байсан бол.

Түүнээс дээш том хадгаламж эзэмшигч ямар байв? Одоо энэ банкны хадгаламж эзэмшигчтэй холбоотой энэ 2013 оны хууль гарсан нь өөрөө яг та бүхнийг энэ асуудлыг шийдэхэд жижиг хувьцаа эзэмшигчид тэр 20 саяас дооших хувьцаа эзэмшигчид энэ тэрийнхээ эрх ашгийг хамгаалаад өр төлбөрийг нь барагдуулах.

Энэ нь өөрөө цаг хугацаа хэмнээд хурдан түргэн шийдэгдэх боломж байсан эсэх талаар надад бодит мэдээлэл өгөөч гэж би хүсмээр байна. Энэ өөрөө яг 2013 оноос хойш энэ хууль гарсны дараах ганц кэйс бол “Капитал банк” байгаа. Тэгэхээр энэ дээр бас нэг бодит мэдээлэл авахыг хүсэж байна.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний асуултад 2 номерын микрофонд “Капитал банк”-ны эрх хүлээн авагч Т.Дэлгэрхүү хариулна.

**Т.Дэлгэрхүү:** М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Яг тийм. 2013 оны хууль, 2013 оны Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, 2018 оны Банкны хуулийн нэмэлт, өөрчлөлт. Ийшээ шинэчилсэн найруулга гээд.

Яг энэ шинэчлэгдсэн өөрчлөлтийг анх удаа энэ “Капитал банк”-ийг татан буулгахад ашигласан. Хуулийн зохицуулалтууд нь шинэ байсан болох болохгүй юмнууд байсан.

Даатгалын тухайд түрүүн хэлсэн. Энэ хуулиар банкныг татан буулгах шийдвэр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал гарснаас хойш 10 хоногийн дотор өгөх ёстой. Энэ 10 хоног бол ерөөсөө хонон өнжин ажилласан маш ачаалалтай ажилладаг. Энэ дээр мэдээж төлбөр тараах банкныг ХААН банкаар тухайн үед гэрээ байгуулаад ажилласан.

Тэгэхээр ХААН банканд энд байгаа бүх мэдээллийг Ай Ти-гийн хувьд тэр, хүний нөөцийн хувьд тэр ингээд 10 хоногийн дотор өгөөд 20 сая төгрөг хүртэлх валют, мөнгө, одоо төгрөгөөр харилцах хадгаламжтай байсан хүмүүсийнхийг олгосон юм.

Энэ дээр 44.5 тэрбум төгрөг олгосон юм. “Капитал банк” дээр. Энэ 44.5 тэрбум бол харилцагчийн тооны хувьд бараг 99 хувь нь. Мөнгөн дүнгийн хувьд бол мэдээж бага. 5 хувь ч юм уу. Тэгэхэд энэ дээр 20 сая төгрөг хүртэлх. 300. Давхардсан тоогоор шүү. 352, 353 мянган харилцагч байгаа юм. Нэг хүн 10 ч данстай байж болно шүү дээ. Төгрөгийн болон валютын.

Тэгэхээр 352, 353 мянган дансны мэдээллийг хүргүүлээд тэгээд эдгээр улсуудынх нь үлдэгдлийг нь тулган баталгаажуулаад 10 хоногийн дотор хүргэнэ гэдэг бол яах вэ, ажиллагааны хувьд маш нүсэр ажиллагаа юм билээ.

Мэдээж хуулийнх нь зохицуулалт 20 сая төгрөг их бага байна гэдэг бол тэрэнд одоо яг энэ миний хариуцаж байгаа ажилтай холбоогүй учраас

хувийнхаа дүгнэлтийг хэлэх боломжгүй байна.

Өндөр дүнтэй жишээ нь хадгаламжтай улсууд байдаг л даа. Одоо яах вэ жишээ болгож хэлж байгаа шүү. 100 тэрбум төгрөгийн хадгаламжтай хүн бол 20 саяа л авах боломжтой. 17 сая төгрөгтэй хүн бол 17 сая авна.

Зүгээр би энэ хуулийн зорилгыг нь мэдээж санхүүгийнхээ тогтолцоог төрөлжүүлэх. Мэдээж эндээс цугларсан хөрөнгийг цаашаа дахиад хөрөнгө оруулалт хийх ч юм уу, ач холбогдлын хувьд бол ач холбогдолтой өндөр хууль байгаа байх.

Мөнгөн дүнгийн хувьд түүн дээр тодорхой хэлж мэдэх зүйл байхгүй байна. Энэ хууль тал дээр нөгөө төгрөг валютыг ялгаагүй байдаг юм билээ.

Банкны хууль дээр жишээ нь энэ татан буулгах ажиллагааг дарааллын хувьд ч тэр хуульчилсан юман дээр дутуу юмнууд байдаг. Түрүүний энэ хүн хэлж байх шиг байна лээ.

Энэ дээр мэдээж олон улсын зарчим бол байдаг л даа. Иргэн хүнтэйгээ зэрэгцээд төрийн байгууллага нь би урдуур нь орж мөнгөө авна гээд байх зарчим байхгүй учраас банкны дарааллыг тогтоохдоо мэдээж иргэн, хуулийн

этгээд, тэдгээрийн харилцах хадгаламж, ингээд төрийн байгууллага гэдэг ч юм уу, ингээд дамжуулдаг ч гэдэг ч юм уу хуулийнх нь зохицуулалт бол ийм юм. Олон улсдаа ч ийм байгаа юм. Баярлалаа.

**П.Анужин:** Мэдээлэлтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

“Чингис хаан” банканд байршиж буй Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар “Капитал банк”-ны эрх хүлээн авагчийн мэдээллийг сонслоо.

“Чингис хаан” банкнаас Нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрийг “Чингис хаан” банкны хувьцаа эзэмшигч талтай гэрээ байгуулан гэрээнд заасан хуваарийн дагуу үе шаттайгаар бүрэн төлүүлэхийг дэмжиж, төлбөр барагдуулалтын талаар Нийгмийн бодлогын байнгын хороонд танилцуулж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргад даалгаж, хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгож байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд орьё. Хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

---

### Долоо.Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

---

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг сонсох ёстой байгаа.

Ажлын хэсгийн гишүүдийг урьж байна. Ажлын хэсгийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ хэвэндээ байна.

Тайланг Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Нийгмийн даатгалын

үндэсний зөвлөлийн дарга  
Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

**Х.Булгантуяа:** Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаар товч мэдээлэл хийе.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тайлангийн хугацаанд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, Нийгмийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд нийгмийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн нийгмийн даатгалын салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж, нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн системийг бүрэн цахимжуулах, даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг хийж холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Хуулийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг сайжруулах талаар.

Нийгмийн даатгалын салбарын 2022 оны зорилтот түвшин хангагдаж, эдийн засгийн идэвхтэй хүн амд нийгмийн даатгалд даатгуулагчдын эзлэх хувь хэмжээ, нийгмийн даатгуулагчдын тоо, үүнээс албан журмаар даатгуулагчдын тоо, нийгмийн даатгалын үйлчилгээ авсан хүний тоо зэрэг 2022 оны хөгжлийн үзүүлэлтүүд өссөн дүнтэй байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2.4 их наяд төгрөг төвлөрүүлэхээс 2.7 их наяд төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 112.1 хувиар биелүүлж, давхардсан тоогоор 2.8 сая хүнд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 3.4 их наяд төгрөг зарцуулсан.

Улсын Их Хурлаас баталсан нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн дагуу давхардсан тоогоор 2 сая 87 мянга 700 мянган даатгуулагчдад 72.7 тэрбум төгрөгийг буцаан олгосон тул нийгмийн даатгалын сангаар үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оноос 2 сая хүн буюу 70.2 хувиар өссөн дүн гарчээ.

Монгол Улсын Засгийн газрын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 2022 оны 63 дугаар тогтоолын дагуу тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж Нийгмийн даатгалын сангаас болон Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар тус тус нэмэгдүүлэн бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож нэмэгдсэн тэтгэврийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөр эхлэн олгосон.

Уг арга хэмжээнд 469.2 мянган тэтгэвэр авагч хамрагдаж, тэтгэврийн нэмэгдэлд 637.4 тэрбум төгрөг зарцуулсны дүнд дундаж тэтгэвэр 555.6 мянган төгрөгт хүрлээ.

Нийгмийн даатгалын нийт 34 үйлчилгээнээс цахим нийгмийн даатгалын дэвтэр, тэтгэврийн дэвтэр,



архив, шимтгэл төлөлт, шимтгэлийн тайлан гаргах, хүлээн авах, лавлагаа тодорхойлолт гаргах, тэтгэвэр, тэтгэмжийн тооцоолол хийх, өөрчлөлт оруулах, авах зэрэг 24 үйлчилгээг цахимжуулаад байгаа.

Цахимжуулсан үйлчилгээнээс 16-г сонгон хэмнэлтийн судалгааг 2022 оны байдлаар хийхэд нэг жилд 12.4 тэрбум төгрөг төгрөгийг даатгуулагч иргэд, ажил олгогч хэмнэсэн байна.

Эндээс үзвэл цахимжуулалт нь үйлчилгээ түргэн шуурхай, ил тод, авлига, ашиг сонин сонирхлын зөрчлөөс ангид авах боломжийг бүрдүүлж байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн үйлчилгээг цахимжуулсантай холбоотойгоор төрийн мэдээлэл солилцооны “Хур систем”-д 10 төрлийн, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал “e-mongolia”-д 5 төрлийн мэдээллийг шинээр боловсруулан оруулаад байгаа юм.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиудаас бүрдсэн нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд 2023 оны 1 дүгээр сард хэлэлцэхээр өргөн бариад байгаа.

Хуулийн төсөлд олон давхаргад тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, ахмад

настан бүрд суурь тэтгэвэр, иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэх, нэмэгдүүлэх, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих асуудлыг тусгасан байгаа.

Нийгмийн даатгал үндсэн зөвлөлийн гаргасан шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтийн талаар та бүхэнд танилцуулъя.

Нийгмийн даатгалын үндсэн зөвлөл 2022 онд нийтдээ 8 удаа хуралдаж, 17 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 7 тогтоол батлан гаргасан.

Эдгээр тогтоолуудаас оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай, нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай гэсэн нийтээр заавал дагаж мөрдүүлэх 2 тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг 2 сая төгрөгөөр шинэчлэн, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг 3 сая 500 мянган төгрөгөөр тус тус тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр шийдвэрлэсэн байгаа.

Ийнхүү 2016 оноос хойш 6 жилийн дараа оршуулгын тэтгэмжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж, амьгүй донор болон даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмжийг анх удаа олгох болсон нь хүндээр өвчилсөн хүний амь насыг аврах буяны үйл ажиллагааны үнэ тарифт нэмэгдсэн энэ үед нас барсан иргэдийн оршуулгын үйл ажиллагааг явуулахад чухал ач холбогдолтой шийдвэр болсон.

“Капитал банк”-наас нийгмийн даатгалын санд төлөх төлбөрийг барагдуулахтай холбоотой асуудлыг шуурхай хэлэлцэж шийдвэрлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрээр “Капитал банк”-ны эрх хүлээн авагчаас 25.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 86 ширхэг үл хөдлөх хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт суутган авахыг зөвшөөрсөн.

2022 онд ний хөрөнгийн нээлттэй дуудлага худалдаагаар нийт 8 удаа зохион байгуулж, 5.9 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 20 хөрөнгийг 6.1 тэрбум төгрөгөөр төлж, орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.

Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэрийн дансны 2022 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 9.8 хувиар тогтоон холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа.

2023 онд хэрэгжүүлэх ажлын талаар Та бүхэнд товч танилцуулья.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбогдуулан хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн дагуу дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн батлах, хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын салбарын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг шилэн тунгалаг, авлигалаас ангид байлгахад чиглүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Алсын хараа-2050”, Монгол

Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, нийгмийн даатгалын мэдээллийн системийг хөгжүүлэх төслийн хүрээнд нийгмийн даатгалын болон санхүү сангийн санхүүгийн системийг бүрэн цахимжуулах мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нийгмийн даатгалын санд 3.1 их наяд төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, 1.2 сая орчим даатгуулагчдад 3.7 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд зарцуулахаар тусгасан бол зөвхөн тэтгэвэрт 3.3 их наяд төгрөгийг олгохоор байна.

Иймд энэ хэмжээний зарлагад тухай бүр хяналт тавих боломжийг ханган ажиллана.

Нийгмийн даатгалын шимтгэлээр төвлөрүүлэх орлогын хэмжээ 2022 онтой харьцуулахад 700 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн учраас орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

Нийгмийн даатгалын хөрөнгийг найдвартай, оновчтой удирдах, мөнгөн хөрөнгийг хөрвөх чадвар, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангаж, эрсдэлийг бууруулах зорилгоор сангийн хөрөнгийг арвижуулахад удирдлагаар ханган, үр ашгийг өсгөн нэмэгдүүлэх хууль эрх зүйн боломжийг бүрдүүлэн ажиллах, төрийн санд хуримтлуулсан хөрөнгийг өгөөжтэй болгох, эрсдэлийн удирдлагыг чадавх, бүтцийг хөгжүүлэхэд анхаарах болно.

Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч, ажил олгогчдод илүү хүртээмжтэй, ээлтэй болгох, даатгуулагчдын санхүүгийн хуримтлалыг дэмжсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулан бүрэн цахимжуулна.

Ажил олгогчоос авах 383.6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулах, хуримтлагдсан авлагыг бууруулах ажлыг эрчимжүүлэх. Ялангуяа төсвийн байгууллагын хувьд шимтгэлийн өр авлага үүсэхгүй ажиллах, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, төсвийн зарцуулалтад хяналт тавих хяналтыг сайжруулах, төсвийн сахилгыг мөрдөж ажиллах зэрэгт 2023 онд анхааран ажиллахаар төлөвлөж байгаа юм.

Эдгээр зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлснээр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдаж иргэд, даатгуулагчид, ажил олгогчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээ улам сайжирна хэмээн үзэж байгаа юм.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны тайлан чухал ач холбогдолтой нь бид хуучин одоо мөрдөгдөж байгаа хууль дээрээ үнэлэлт дүгнэлт нэг бодлыг хийгээд 2024 оноос шинэ хууль хэрэгжих гэж байгаатай холбогдуулан 2023 он бол бидний хувьд бас шилжилтийн жил байхаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Хөдөлмөрийн хамгааллын яам, харьяа байгууллагуудын хувьд бас нэлээдгүй ачаалал ихтэй хагас жил холбогдох хууль журмуудаа бид гаргахаар ажиллаж байгаа юм.

Мөн сая танилцуулсантай холбоотойгоор авлагыг барагдуулах, эрх

хүлээн авагчтайгаа хамтран эдгээр авлагатай холбоотой шийдвэрүүдийг түргэн шуурхай гаргах ийм чухал он жил байгаа.

**П.Анужин:** Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Хүрэлбаатарын Булгантуяа хийлээ.

Тайлантай холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Асуулт, үг хамт явна.

Үг хэлэх гишүүн. Буланы Бейсен гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн. Цэвэгдоржийн Ц.Туваан гишүүнээр тасалъя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлж, асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Одоо бид нарын хамгийн гол зорилго бол Нийгмийн даатгалын сангаа мөнгөжүүлэх, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангуудаа ашигтай ажиллуулах. Мөн энэ мөнгө одоо аюулгүй байх асуудал их чухал байгаа.

2022 оны хувьд бас тэтгэврийн доод хэмжээ одоо 500 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ одоо 400 мянган төгрөг гээд тодорхой хэмжээгээр тэтгэврийн доод босгуудыг нэмэх асуудлыг шийдээд явсан.

Одоо маш чухал хуулийг хэрэгжүүлнэ. Тийм ээ. 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлээд тэтгэвэр 10 хувиар нэмэгдээд, дээрээс нь инфляцтай уялдуулж 2014 оны нөгөө хувьд тогтоосон тэр юуг өөрчлөх гэж байна.

Тэгэхээр одоо манай Нийгмийн даатгалын сан үндэсний зөвлөлийн бараг бүх гишүүд маань энд сууж байна. Ёстой нөгөө тоо боддог хүмүүс энд хэрэгтэй байгаа гэдэг шиг одоо энэ хуулийг

хэрэгжүүлэхэд тэтгэврийн доод босго хэдээр нэмэгдэх нь 10 хувь. Иргэд одоо хүртэл ингээд жоохон эргэлзээд байна шүү дээ.

Ингээд механикаар бүгд 10 хувь нэмэгдэх гэж байгаа гэсэн ойлголт нэг хэсэг явсан. Гэхдээ 10 хувь нэмэгдэхээс гадна зөрүү арилах. Дээрээс нь энэ нь өөрөө тухайн үед хэдэн төгрөгөөр тэтгэврээ тогтоолгож байсан түүнтэй үүдээд өнөөдрийн 2022 оны инфляцтай уялдаж энд тэтгэвэр нь нэмэгдэнэ гэсэн асуудлууд яригдаж байгаа.

Тэгэхээр энд хэр бэлтгэл хангагдсан байгаа вэ? Одоо 7 сарын 01 болоход хэдхэн хоног үлдсэн байна. Мэдээж нийслэл, дүүрэг, аймаг өөрсдийнхөө төсөв бас батлаад явна.

Одоогийн байдлаар би ялангуяа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нэмж сайн байд бас хариулах байх. Бэлтгэл хэр хангагдсан. Энэ дээр ямархуу том өөрчлөлт орох гэж байгаа гэдэг дээр Үндэсний зөвлөх маань бас итгэлтэй байгаа юу?

Тэгээд энэ дээр та бүхэн маань надад нэг тодорхой хариулт өгөөд. Ер нь ахмадууд маань ядуурлын эгнээнд ороход маш ойрхон байна, яаралтай арга хэмжээ авах хэрэгтэй гээд энэ өрөөнд ингээд хэлэлцүүлэг хийж байсан.

Их Хурал, Засгийн газар хамтраад ямар ч байсан яаралтай энд тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлсийг нэмэх ёстой гэсэн байр сууринаас хандсан. Монгол Ардын намын бүлэг улс төрийн шийдвэрээ гаргасан. Одоо ингээд 7 сарын 01-нээс нэмэгдэх гэж байна.

Тэгээд энэ нь өөрөө хэр хэмжээний нэмэгдэл болж ахмадууд маань, энд тэтгэвэр авч байгаа хүмүүс

маань хэр сэтгэл хангалуун байх бололцоо бүрдэж байгаа гэж үзэж байгаа вэ? Тийм.

Тэгээд энэ дээр тооцоо судалгаан дээр Үндэсний зөвлөл маань хэр ажиллаж байна вэ гэдэг дээрээ бас хариулт авъя.

**П.Анужин:** Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Хүрэлбаатарын Булгантуяа хариулаад, гүйцээгээд 3 номерын микрофонд Ц.Сүхбаатар гишүүн хариулна.

**Х.Булгантуяа:** М.Оюунчимэг гишүүний асуултад хариулья.

Сая 2023 оны төсвийн тодотголыг Улсын Их Хурлаар баталсан. Хуулийн дагуу Улсын Их Хурлаар ерөнхийдөө том дүнгээрээ батлагддаг. Нийгмийн даатгалын сан, ингээд нэмэлтүүд том дүнгээрээ батлагдаад сая 6 сарын 21-ний Засгийн газрын хурлаар бид итгэлцүүрийг тэтгэвэр нэмэх Засгийн газрын тогтоолуудыг батлаад үүнээс хойш манай Нийгмийн даатгалын ерөнхий газар Засгийн газраас батлагдсан тогтоол, шийдвэрийн дагуу ингээд ажиллаж байгаа.

7 сарын 01-нээс бүрэн олголтоо хийхээр бид ажиллаж байна. Мөн нийгмийн даатгалын **ndaatgal.mn** гээд Нийгмийн даатгалын ерөнхий газрын веб сайт дээр иргэд өөрснөө ороод итгэлцүүрээр, мөн 10 хувиар нэмэгдлээр өөрсдийнх нь тэтгэвэр хэрхэн яаж нэмэгдэж байгаа вэ гэдэг талаарх мэдээллүүдийг бид ерөнхийдөө бараг бүрэн оруулаад байна.

Зарим тэтгэвэр авагчдын хувьд бол бид механикаар энэ өөрчлөлт шинэчлэлтүүдийг хийхгүй бол тухайн үед арай өөр нөхцөлөөр байдаг юм уу, тэтгэвэрт гаргачихсан хүмүүс бас

нэлээдгүй байдаг. Эдгээр манай тэтгэвэр авагчдын хувьд Нийгмийн даатгалын ерөнхий газар бүр нэг бүрчлэн шивж шалгаж оруулаад.

Тэгэхээр үүнийгээ дагаад манай бүх сумд, бүх дүүргийн нийгмийн даатгалын харьяа байгууллагууд бүгдээрээ тэтгэвэр авагчдынхаа асуудлуудыг хагас, бүтэн сайнгүй хүртэл ажиллаад ингээд шивээд шалгаад бас явж байгаа.

Тэгээд иргэдийн маань хувьд нэгдүгээрт цахимаар. Хоёрдугаарт, харьяа байгууллагынхаа нийгмийн даатгалын газар дээр очоод бас өөрийнхөө тэтгэврийн асуудлаар хэрхэн нэмэгдэж байгаа талаар мэдээ, мэдээлэл аваад бас шалгуулах боломжтой байгаа.

Энэ удаагийн тэтгэврийн итгэлцүүрээр нэмэгдэх. Дээрээс нь нэмээд 10 хувиар нэмэгдэхэд нийтдээ 400 орчим тэрбум төгрөгийг зарцуулж байгаа. Үүний үр дүнд одоо дундаж тэтгэвэр 555 мянга орчим байгаа бол энэ 600 гаруй мянган төгрөг болж дундаж тэтгэвэр нэмэгдэхээр байгаа.

Тэгээд энэ бол Монгол Улсын Засгийн газраас, Улсын Их Хурлаас төсвийн боломж бололцоо бий болсон хамгийн эхний шатад иргэдийнхээ амьжиргааг дэмжих, ахмад настаныхаа орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч байгаа чухал шийдвэр болсон гэж үзэж байна.

Өчигдөр манай Монголын ахмадын холбооны тэргүүн ерөнхийлөгч Ц.Сүхбаатар дарга бас 500 орчим ахмадуудад энэ тэтгэврийн нэмэгдлийн талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтраад бид мэдээлэл өгсөн.

Ц.Сүхбаатар дарга нэмээд мэдээлэл өгөх үү. Ахмадуудад энэ мэдээлэл маань хэрхэн яаж хүрч байгаа талаар.

Энэ хуулийнх нь дагуу итгэлцүүрийг тогтооход, нэмэгдлүүдийг тогтооход Засгийн газар луу оруулж батлуулахаас өмнө энэ тогтоолуудыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл заавал авч хэлэлцдэг.

Энэ итгэлцүүрийг манай Ахмадын холбоо өөрсдөө маш их нарийн сайн тооцсон байсан. Тэгээд манай Б.Батжаргал даргатай Нийгмийн даатгалын бодлогын зохицуулалтын газар, статистиктай бид энэ тооцооллуудаа харахад бараг ерөнхийдөө ялгаагүй. Маш их ойрхон байсан.

Энэ тооцооллуудыг бид давхар Дэлхийн банкны зөвлөхүүдээр энэ “Актур” тооцооллынхноор бас давхар хийлгэж хянуулсан байж байгаа.

Тэгэхээр харьцангуй манай тооцооллын хувьд харьцангуй сайн гарсан байх гэж бодож байна.

Ц.Сүхбаатар дарга нэмээд хариулах уу.

**П.Анужин:** Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Ц.Сүхбаатар хариулна.

**Ц.Сүхбаатар:** Баярлалаа.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас сүүлийн 20 жил шийдвэрлэж чадаагүй маш томоохон асуудлыг эр зориг гаргаж шийдвэрлэсэнд Монголын 330 гаруй ахмадууд үнэхээр баяртай байгаа.

Үүнээс өмнө арга хэмжээ авч байсан уу гэвэл авч байсан. 10, 20, 30 мянгаар нэмсэн. Тэтгэврийн доод хэмжээг 500 мянга болгосон гээд л.

Тэгээд энэ бүхэн маань зөрүүг улам холдуулж ахмадуудын бухимдал байсаар ирсэн. Үүнийг үндсэндээ нэгмөсөн шийдвэрлэсэн маш чухал арга хэмжээ болсон.

Сая Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар итгэлцүүрийн асуудлыг, тэтгэврийг нэмэх асуудлыг хэлэлцээд Засгийн газарт санал өгсөн юм.

Тэгэхээр энэ үйл ажиллагаа үндсэндээ анхных болсон шүү. Би энэ дээр далимдуулаад хэлчихэд энэ Үндэсний зөвлөлийн саналыг Засгийн газар урьдчилж авдаггүй. Үндэсний зөвлөлийн гишүүн хоёр сайд байгаа. Хууль зүйн сайд, Сангийн сайд хоёр.

Энэ хоёр хүн бол ер нь Үндэсний зөвлөлийн хуралд суудаггүй. Ихэвчлэн Сангийн сайдын чиглэл удирдлагаар тэтгэврийг нэмэхгүй буюу одоо ямар хэмжээгээр нэмэх асуудлыг шийдэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд эрх хэмжээ нь дутсан юм шиг иймэрхүү байдалтай байж ирсэн. Олон жилийн турш.

Харин энэ удаад Үндэсний зөвлөлөөр нэлээн нухацтай ярьж, итгэлцүүрийн тэр хэд байх юм, ямар түвшинд байх юм гэдгийг нь хэлэлцээд Засгийн газарт саналаа өгсөн.

Яг энэ саналын дагуу Үндэсний зөвлөлтэйгөө санал нэгтгэйгээр шийдвэрлэсэн учраас мэргэжлийн өндөр түвшинд энэ итгэлцүүр тогтоогдож тэр олон жилийн турш зөрүүтэй байсан ахмадуудын сэтгэл тайвширч байгаа.

Нөгөө талдаа яах вэ энэ сошиалаар 700 мянга боллоо энэ тэр гээд л хамаагүй явдаг шүү дээ.

Тэгэхээр манай ахмадууд чинь ер нь 700, 800 мянган төгрөг л бид нар авах юм байна. Тэгээд дээд талын тэр өндөр тэтгэвэртэйг нь нэмэх ёсгүй юм байна гэсэн ийм шүүмжлэл буруу ойлголтууд нэлээн явсан.

Бид залруулж байна. Ер нь тэтгэврийн бодлого дотор чинь доод хэмжээгээр авах хүмүүс байна шүү дээ. Үүнийг чинь төрийн бодлого 500 байх уу, 550 мянга байх уу гэдгээ улс орон чинь өөрөө цалин, тэтгэврийн тэнцвэрт харьцаа, бодлогоор барьж явна шүү дээ.

Тэгэхгүй зүгээр хорьхон жил ажилласан. Тэгээд цалин мөнгө байхгүй ийм хүмүүс ялангуяа хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүд, үйлчилгээний бага тушаалын ажилтнууд. Энэ ахмадууд чинь 550 мянган төгрөгөөр хязгаарлаад л тэгээд үнэ инфляцын өөрчлөлтөөр тэр тэтгэвэр нь нэмэгдээд явдаг ийм олон улсын зүй тогтол байна шүү дээ.

Үүнийгээ бид ахмадуудад ойлгуулах хэрэгтэй. Ойлгож байгаа. Зүгээр нийтэд нь нэг тогооны зарчмаар доод хэмжээг нь дээш нь татаад байх юм бол нөгөө зөрүү чинь улам ойртоод цөөхөн жил ажилласан өндөр тэтгэвэр нэмэгдээд байдаг. Масс нь их байдаг. Хөрөнгө их гарна. Нөгөө өндөр тэтгэвэртэй хэд чинь өндөр цалингаасаа олон жил шимтгэл төлсөн учраас тэр хэмжээндээ тохирсон өндөр тэтгэвэр авах нь зөв шүү дээ.

Тэгээд үүнийг ахмадууддаа ойлгуулж байгаа. Өчигдөр нийслэлийн 9 дүүрэг, Улаанбаатар хотын 200 гаруй хорооны ахмадын зөвлөлийн дарга нар

идэвхтэн, идэвхтэй ажилладаг ахмадын сонгуультнуудыг цуглуулж маш дэлгэрэнгүй 2 цаг, 3 цаг шахуу ярилцлага хийсэн. Тодорхой жишээ баримтаар.

Тэгээд энэ дээр сайн ойлголт авсан. Үүний учир нь Улаанбаатарт 170 мянган ахмад байгаа шүү дээ. Бараг 50 хувь нь. Тэгээд энэ ахмадуудад ойлгуулах үүргийг тэр ахмадууддаа өгсөн.

Тийм учраас одоо тэр хороон дээр, хэсэг дээр. Тэгээд ялангуяа одоо бид хөдөө тийшээ сурталчилгаа явуулна. Энэ сайхан шийдвэрийг ахмадууддаа зөв ойлгуулж ийм том алхам хийлээ шүү гэдгийг ойлгуулах үүрэг бидэнд байгаа гэж үзэж байгаа.

Тэгээд энэ тэтгэврийг нэмэх асуудлыг маш зоригтой шийдвэр гарсан Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамандаа Монголын нийт ахмадуудын өмнөөс баяр хүргэж, талархал илэрхийлье. Та нөхдөдөө баярлалаа.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулъя.

**М.Оюунчимэг:** Ц.Сүхбаатар даргад баярлалаа. Тодорхой хэллээ.

Хамгийн гол нь зүйл яг саяынх байхгүй юу. Ерөнхийдөө Сангийн яамны бодлогоор л ороод ирээд явчихдаг. Үндэсний зөвлөл, тэгээд л нөгөө мэргэжлийн байгууллага одоо яг тэр цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж энэ тэр дээр чинь алдагдаад байдаг.

Тэгэхээр Үндэсний зөвлөл авч хэлэлцээд тооцоо судалгаа, тэр тоогоо тулгаж үзээд. Энэ нь өөрөө Засгийн газар дээрээ дахиж орж хэлэлцэгдээд яг тэр Үндэсний зөвлөлд байдаг гурван сайд

нэгдэж сууж байгаад асуудлууд ярих ёстой.

Тэгээд энэ жишиг энэ удаад хүссэн хүсээгүй үнэхээр 7 сарын 01-нээс нэмэх ёстой гээд Их Хурал, Засгийн газрын түвшинд асуудлууд яригдаад ингээд нэг том арга хэмжээг улс төрийн бодлогоор ингээд авчихна шүү дээ.

Тийм учраас одоо үүнийг алдаж болохгүй шүү. Яг энэ Үндэсний зөвлөл нь бас тоо тулгадаг, тооцоогоо гаргадаг, тэрийг нь Засгийн газар дахиж авч үзээд тулгадаг энэ тэр. Бидний өнөөдөр хийгээд байгаа нийгмийн даатгалын багц хуулийн тусгах чухал зүйлүүд байгаа гэдгийг хэлчихье гэж бодож байна. Баярлалаа.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн маш чухал асуудал хөндлөө.

Сая Ц.Сүхбаатар даргын хэлдэг шиг энэ том шийдвэр нь өөрөө сошиалаар юм уу, ямар нэгэн байдлаар буруу хүрч, буруу хүлээлт үүсгээд. Дээрээс нь богино зайнд бас бэлтгэл муутай байж байгаад ингээд талаар болох вий гэсэн маш чухал асуултыг асуулаа.

Энэ асуултад тус яамны сайд Хүрэлбаатарын Булгантуяа бэлтгэл бүрэн хангагдсан. Энэ дээр асуудал үүсэхгүй. Их Хурлын гаргасан чухал шийдвэр асуудалгүй явах бэлтгэл бүрэн хангагдсан гэдэг хариултыг хариуцлагатайгаар өглөө.

Буланы Бейсен гишүүн одоо асуулт асууна.

**Б.Бейсен:** Энэ тайлантай танилцлаа л даа. Би нэг л юм асууя гэж байна.

Энэ ажилгүйдлийн даатгалын сан 2022 онд орлого нь 53.6 тэрбум юм байна. Зарлагын гүйцэтгэл гэхэд 78.7 тэрбум гарчихсан байна. Зарлага нь өмнөх онтой харьцуулахад ер нь 850.2 тэрбум төгрөгөөр буюу 38 хувиар өссөн байна л даа. Энэ талаар нэг тайлбар авъя л даа.

Мөн хүний тоо бас харьцуулсан байна. 2020, 2022 онтой. Ажилгүйдлийн. 2020 онд 21.3 гэсэн байна. Хүний амын тоог. 2022 онд 30.5 болоод нэмэгдчихсэн байна. Энэ хүн амын ажилгүйдэл нэмэгдэж байна гэж дүгнэж байна уу? Энэ талаар нь асууя л даа.

**П.Анужин:** Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Ганцэцэг хариулна.

**Ц.Ганцэцэг:** Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Ажилгүйдлийн даатгалын сангийн хувьд сүүлийн жилүүдэд харьцангуй зарлагын хувьд их өндөр өсөлттэй байгаа.

Орлогын хувьд бас зарлагаа одоо юу гэдэг юм, орлого нь бага, зарлага нь өндөр гараад байгаа ийм үзүүлэлтүүд байгаа.

Энэ дээр нөлөөлж байгаа нөлөөллийг нийгмийн даатгалын байгууллагаас хийсэн байгаа. Сүүлийн жилүүд ялангуяа өнгөрсөн онд оны эхний 5 сарын мэдээгээр бас зарлага нэлээн өссөн ийм үзүүлэлттэй.

Энэ нөлөөлөөд байгаа хүчин зүйл нь болохоор үндсэндээ монголчууд гадагшаа их явж байна. Төрийн алба, Хүний эрхийн комиссын тайлангаар төрийн албан хаагчид ажлаасаа гарч байна. 13 мянган хүн ажлаасаа гарсан. Тэгээд Бүгд Найрамдах Солонгос Улсад

виз гайгүй харьцангуй хөнгөлөлттэй болсон учраас маш их явж байна.

Цөөн хүнтэй гэр бүлийн шинжтэй жижиг аж ахуйн нэгжүүд бие биеийгээ энэ хуулийн зүйл, заалтыг ашиглаад ажлаасаа халдаг, ажилгүйдлийн тэтгэмж авдаг, эргээд ажилдаа ордог үзүүлэлтүүд энэ Ажилгүйдлийн даатгалын сан дээр байгаа.

Тэгээд бид батлагдсан төсвийн хувьд зарцуулж байгаа. Гэхдээ ажилгүйдлийн даатгалын сан маань харилцахын бас тодорхой хэмжээний үлдэгдэлтэй байсан учраас энэ төсвийн хүрээнд зарлага хийгдээд явж байгаа.

Энэ асуудлыг шийдэхээр одоо Улсын Их Хурлаар яг хэлэлцэж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль ажилгүйдлийн даатгалын харилцааг зохицуулж байгаа. Энэ дээр бид тодорхой зохицуулалт оруулсан.

Түүнчлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлдөө шимтгэлийн хувь хэмжээг нийт дүнгээр нь хөдөлгөхгүйгээр ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хэмжээг үйлдвэрлэлийн ослын даатгалаас хооронд нь зохицуулах байдлаар хуулийн төсөл хэлэлцэгдээд дэмжигдээд явж байна.

Энэ хууль ингээд батлагдвал ажилгүйдлийн даатгалын сангийн орлого нэмэгдээд зарлагаа харьцангуй аваад явах ийм боломж нь бүрдэх юм.

**П.Анужин:** Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг хамтдаа.

**Ц.Туваан:** Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тайлан сонсож байна.



Тэгээд тодорхой хэдэн асуулт асууя. Нийгмийн даатгалын энэ салбарыг нэгдсэн удирдлагаар хангах ийм чиг үүрэг хэрэгжүүлдэг ийм зөвлөл.

Тэгээд энэ орон нутагт ажиллаад аймаг, сумдад ажиллаад явахаар нийгмийн даатгалын байгууллагын ажилчид гээд хүмүүс байгаа. Энэ хүмүүс маань сүүлийн үед бид нарыг, ялангуяа энэ байгууллага маань бид нарыг бас харж үзэх. Харж үзэх гэдэг нь нийгмийн асуудал шийдэх талаас нь гэж байгаа шүү. Асуудлыг ерөөсөө ярихаа больчихлоо. Урьд нь нэг хэсэг энэ асуудлыг шийдээд явдаг байсан.

Тэгэхээр энэ асуудал шийдэгдэхгүй байна. Үүнийг бас цааш нь уламжилж өгөөч гэдэг асуулт тавьдаг. Энэ дээр ямар асуудал байна.

Хоёрдугаарт, нийгмийн даатгалын ажилчид дээр хуулиуд бид яах вэ батлаад байдаг.

Тэгэхээр анхан шатанд, ялангуяа энэ суманд босоо бүтэцтэй байгууллагын хувиар нийгмийн даатгалын байцаагч нараа та хэд сургах. Өөрөөр хэлбэл энэ хуулиудыг таниулж цааш нь дамжуулж иргэдэд сурталчлах гэдэг энэ бодлогод чинь ер нь хэр явж байгаа вэ? Үүнийг хариулж өгөөч.

Энэ дээр одоо жишээлэх юм бол би бас санаачлаад энэ Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцох гээд хууль батлагдсан. 10 сарын 01-нээс хэрэгжих гэж байгаа. Үүний бэлтгэл ажилтай хавсаргаад явах хуулиудаа цааш нь таниулах, амьдралд хэрэгжүүлэх тал дээр танай бодлого яаж явж байгаа вэ гэдэг ийм асуултыг тавья.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бас нэг шийддэг асуудал энэ нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл байгаа. Чөлөөт үлдэгдэл маань одоо яг хэд байна аа? Энэ 2022, сүүлийн жилүүдэд жилээрээ Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл улсын төсвөөс биш энэ банканд байршуулах хэлбэрээр бас энэ банкны хүүгийн орлого гэж нэмэгддэг. Тийм ээ. Энэ хэдэн төгрөгөөр яаж нэмэгдэж байгаа вэ гэдэг ийм асуултыг асууя.

Ахмадууд дээр сая тайлбар хийж байна гэж байна. Нөгөө танилцуулга.

Тэгэхээр энэ дээр нэг ийм юм байгаа. Ахмадууд маань нийгмийн даатгалын шимтгэл төлөөд тэтгэвэр бага байна гэж гомдоллохоосоо илүүтэйгээр шударга бус байдлыг маш их ярьдаг. Энэ буруу. Одоо би жишээлбэл олон жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөөр байтал төлөөгүй, нөхөн олгуулсан, сайн дураар төлсөн хүмүүстэй адилхан тэтгэвэр аваад байна гэдэг гомдол их гардаг.

Тэгэхээр энэ асуудал дээр ер нь та хэдийн бодлого ямар байдаг юм бэ?

Мэдээж индекс батлалгүй бид бараг 10 гаруй жил явчихсан. 2011, 2014 он гээд л. Тэгэхээр үүний чинь бас нэг гол нь энэ тэтгэврийн зөрүү арилгах гэж бид нар яриад явчихсан. Зөрүү үүсээд байгаа энэ асуудал чинь яваад байгаа шүү дээ.

Тэгэхээр ахмадуудын энэ гомдол дээр та хэд бас нэлээн жоохон тайлбартай ажилласан нь зөв байх гэж бодож байгаа юм.

Үндсэн хууль 2019 онд батлагдсан. Энэ дотор Баялгийн сангийн тухай хууль гээд.

Ерөөсөө бид Тэтгэврийн нэрийн дансны тухай хууль хэрэгжүүлэх гээд ирэхээр чинь энэ нэрийн дансны чөлөөт үлдэгдэл чинь одоо 23 их наяд байгаа шүү дээ. Үүнийг хангах гээд сая шинэ хууль дээр нэг нэг хувь гээд нэг юм оруулж ирж байна л даа. Энүүгээр хөөгөөд гүйцэхгүй л дээ.

Тэгэхээр энэ Баялгийн сангийн хууль батлуулах тал дээр бас энэ Үндэсний зөвлөлийнхөн маань ямар бодолтой байна.

КОВИД-ын үеэр нийгмийн даатгалын шимтгэлийг жоохон хөнгөлж өгсөн. Одоо компаниуд чинь яг энэ нийгмийн даатгалын шимтгэл төлөлт дээр асар хүнд байгаа шүү дээ.

Тэгэхээр ер нь нийгмийн даатгалын шимтгэлийн хувиуд дээр та хэд цаашдаа ер нь ямар бодлого барих вэ? Энэ түвшинд нь хадгалах бодлоготой юм уу, хасах бодлоготой юм уу, нэмэх бодлоготой юм уу гэдэг дээрээ нэг хариулт өгөөдхөөч ээ гэсэн ийм асуулт байна.

**П.Анужин:** Цэвэгдоржийн Туваан гишүүний асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Хүрэлбаатарын Булгантуяа хариулна.

**Х.Булгантуяа:** Ц.Туваан гишүүний асуултад хариулья.

Нийгмийн даатгалын манай байцаагчдын тогтвор суурьшилтай ажиллах, дээрээс нь нийгмийн асуудлыг шийдэх, сургах энэ ажлууд маш чухал.

Тэгээд сая П.Анужин дарга асууж байна. Одоо бэлэн үү гэж. Бид өөрөө

өөрийнхөө хэмжээнд чадах ядахаараа л бэлдэж байна.

Бид нарт хоёр асуудал байна. Одоо би үүнийг Байнгын хорооныхоо даргад, Байнгын хорооныхоо гишүүдэд танилцуулах нь зүйтэй гэж бодож байна.

Хэдийгээр манайх төрийн үйлчилгээг хамгийн сайн цахимжуулсан яам болж чадсан ч гэсэн сая үүнийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд бүр өөрөө онцлон хэлж байсан. Гэсэн хэдий ч манай салбарынхны ажилтнуудын техник тоног төхөөрөмжийн шинэчлэл маш муу байгаа.

Манай дээр ахмад настай хүмүүс дандаа ухаалаг бид нар шиг ингээд л утас бариад л дандаа нэгж худалдаж аваад л “e-mongolia”, “ХУР систем” рүү ороод байж чаддаг хүмүүс манай дээр байнга ирдэггүй.

Ахмад настай хүмүүс байдаг, зорилтот бүлгийнхэн байдаг.

Тэгээд энэ хүмүүс ирэхэд манай яг анхан шат дээр ажиллаж байгаа иргэдтэй харьцаж ажилладаг албан хаагчдын техник, тоног төхөөрөмж ялангуяа ийм их ачаалалтай үед гацдаг. Дандаа унтардаг. Тийм ээ. Ачааллаа даахгүй, иргэдийг бухимдуулсан ийм тоног төхөөрөмж, компьютертой ажиллаж байгаа.

Тэгэхээр үүнийг бид 2024 оноос авхуулаад. Манай ажилчдын хувьд өөрөө өөрийнхөө ажлын нөхцөлийг сайжруулчихвал бараг өөрийнхөө ар гэрийн амьдралыг шийдүүлэхээс илүү их баяртай байх гээд байдаг.

Тэгэхээр үүнийг шийдэх бид нарт нэн чухал асуудал байгаа.

Хоёрдугаарт, төрийн албаны бүхий л салбарт. Сая хэллээ. 13 мянган төрийн албан хаагч ажлаасаа гарсан байна гэж. Манай салбар дээр ч гэсэн бас адилхан байгаа.

Энэ удаагийн төсвийн тодотголоор бид төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхэд 1 их наядын санхүүжилтийг бид төсвийн тодотголоор батлуулж чадлаа.

Энэ бол ер нь төрийн албанд мэргэшсэн, туршлагатай хүмүүс тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзлийг бий болгох гэж Засгийн газраас, Улсын Их Хурлаас авч байгаа нэг арга хэмжээ.

Тэгээд ийм чадвартай хүмүүс нийгмийн даатгал маш нарийн хуулийн дагуу явдаг. Төсөв, санхүүтэй шууд холбогддог, хариуцлагатай албан тушаал.

Тийм учраас энэ хүмүүсийг бас тогтвор суурьшилтай ажиллуулахгүй бол манай агентлаг дээр агентлагийн харьяа аймаг, орон нутгийн салбарууд хүний нөөцийн хувьд хэцүү болж эхэлж байгаа. Одоо үнэнийг хэлэхэд. Тогтвор суурьшилтай ажилладаггүй. Цалин муутайгаас болоод. Иргэдийн бухимдалтай байнга харьцаж ажилладаг ийм хүмүүс байдаг.

Тэгээд энэ цаг үед энэ хоёр асуудал бидний хувьд хамгийн тулгамдаж байгаа асуудлууд болж байгаа. Тэгээд энэ хоёрыг ялангуяа 2024 оны төсвөөс авхуулаад бид үүнийг шийдвэрлэхийн төлөө Засгийн газар ч ажиллана. Байнгын хороо маань бас дэмжиж ажиллаасай гэж хүсэж байна.

Бид төрийн албан хаагчдын ер нь энэ нийгмийн асуудлыг сая Улсын Их Хурлаар ч гэсэн, Улсын Их Хурлын

гишүүд ч гэсэндээ аймаг, орон нутгаар явж байхад ярьж байсан.

Зарим хуулиуд дээр нийгмийнх нь асуудлууд нь салбарын хуулиуд дээр маш сайн суучихсан. Заримынх нь байдаггүй.

Манай хууль илүү дандаа нийгмийн даатгалын байгууллагын эрх зүйн байдлын хуулиас илүүтэйгээр дандаа нийгмийн даатгал, даатгуулагч талдаа ориулагдсан хууль байдаг. Энэ сангийн хуримтлал, удирдлага зохион байгуулалт руу чиглэсэн хууль байдаг.

Тэгэхээр ер нь энэ төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны тусгайлсан бараг хуультай байх ёстой юм шиг харагдаад байна.

Салбарын сайд нь ч байдаг юм уу, салбар нь Улсын Их Хурлаар өөрийнхөө эрх зүйн байдлыг хангачхаад байдаг. Нийгмийн баталгаагаа хангуулаад байдаг. Тэгж чадахгүй хүмүүс нь нийгмийн баталгаа муутай байгаад байж болохгүй. Адилхан л төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсийн хувьд адилхан л нийгмийн баталгаанаас тодорхой хэмжээгээр хангагдаж байж төрийн алба яг иргэддээ зорьсон хэмжээгээр, хүссэн хэмжээгээр чанартай хүрэх ёстой гэж бодож байгаа.

Тэгэхээр үүнийг бид нар бүр ийм хуультай болох нь зүйтэй юм байна гэж. Сая бас энэ төсвийн тодотголыг ч гэсэн хэлэлцэж байхад Улсын Их Хурлын гишүүд нэлээдгүй ярьж байгаа.

Бид байцаагчдаа, ялангуяа одоо энэ шинэ хууль батлагдсан даруйд сургах, хуулиа сурталчлах ажил бидний хувьд маш чухал. Энэ хууль дээр маш олон давуу талууд бас бий болж байгааг бид сурталчлах ёстой.

Өмнө нь ч гэсэн.../минут дуусав/

**П.Анужин:** Нийгмийн даатгалын ерөнхий газар Ц.Ганцэцэг дарга хариулъя. Чөлөөт үлдэгдэл хэд байна?

**Ц.Ганцэцэг:** Ц.Туваан гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын 4 санд 994 тэрбум төгрөгийн үлдэгдэл байсан.

Энэ оны 5 сарын мэдээгээр 1 их наяд 33 тэрбум төгрөг байгаа.

Өнгөрсөн жилүүдэд сүүлийн хоёр, гурван жил нөгөө КОВИД-ын нөхцөл байдалтай холбоотойгоор банкууд маань энэ харилцахын үлдэгдэлд ямар нэг хүү тооцоогүй учраас энэ мөнгө маань өөрөө үндсэндээ орсон орлогоороо хэвээрээ байгаа.

Харин он гараад энэ КОВИД-ын хууль цуцлагдсан учраас бид арилжааны банкуудтайгаа байгуулсан гэрээгээ 2 сарын 01-нээс шинэчлээд харилцахын үлдэгдэл жилийн 3 хувийн хүү тооцох ийм гэрээг хийсэн.

Энэ 3 хувийн хүүгээр жилдээ 10 орчим тэрбум төгрөг нийгмийн даатгалын санд орно.

Зүгээр хадгаламжид байршуулах асуудал бид Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр асуудал оруулаад байгаа. Үндэсний зөвлөл хуралдвал тодорхой хэмжээний шийдвэр гарах байх. Энэ өөрөө 4 байгууллага, 4 субъектийн шийдвэрээр хийгддэг. Монголбанк, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл.

Тэгэхээр энэ чиглэлээр бид холбогдох санал хүргүүлсэн байгаа.

Харин сая Улсын Их Хурлаар баталсан Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Нийгмийн даатгалын сангаас 300 тэрбум төгрөгөөр Засгийн газрын бонд авах энэ төсөв суусан байгаа.

**П.Анужин:** Үндэсний зөвлөлийн гишүүн Ц.Сүхбаатар гүйцээж хариулъя.

**Ц.Сүхбаатар:** Тэгээд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр яригддаг нэг чухал асуудлын нэг нь энэ Ц.Туваан гишүүний яриад байгаа, хөндөөд байгаа асуудал юм.

Энэ чинь босоо удирдлагатай. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл баталдаг. Тэгээд тэрийгээ орон нутагт хуваарилж өгдөг.

Тэгэхээр энэ хэмнэлтийн хуультай холбогдуулаад нийгмийн даатгалын байгууллагын орон нутагт байгаа, энэ одоо сумд байгаа ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэх талаар тавьсан асуудлуудыг нь нөгөө хэмнэлттэй хуультай холбогдуулаад бүгдийг нь тайраад хаячихсан. Жишээлбэл, орон сууцны асуудал байна, цалингийн асуудал байна. Тэгээд тэрбум төгрөг хасагдсан жишээтэй.

Тэгэхээр Ц.Туваан гишүүн минь Төв аймагт гэхэд байна шүү дээ олон сумд энэ нийгмийн даатгалын байцаагч байхгүй. Сум байцаагчгүй байна шүү дээ.

Нийтдээ улсын хэмжээнд 35 сум нийгмийн даатгалын байцаагчгүй. 109

орон тоо улсын хэмжээнд нийгмийн даатгалын байцаагч байхгүй байна.

Тэгээд энэ юу вэ гэхээр зэрэг нөгөө цалинг нь нэмэх асуудлыг шийдээгүй. Босоо удирдлагатай байгууллагуудад, одоо даатгалын байгууллага гэхэд ажилтнуудын цалинг нэмэгдлийг нь орон нутгаас өгдөггүй. Орон нутгийн хэвтээ удирдлагатай төрийн албан хаагчид нь болохоор цалин нь нэмэгдчихдэг. Тэгтэл босоо удирдлагатай байгууллагуудын цалин, энэ даатгалын байцаагч нарын цалин нэмэгдээгүйгээс нөгөө улсууд нь ялангуяа Төв аймгийнх хотод ойрхон учраас хот руу өндөр цалинтай хувийн байгууллагад шилжиж ажиллаад. Яг нөгөө хөдөө сумд байх байцаагч нь болохоор зэрэг сонгон шалгаруулалтаар ордоггүй. Орсон ч гэсэн тэнцдэггүй. Ингээд орон тоо дутуу байгаа юм.

Тэр тэтгэвэр ер нь шударга тогтоогдож байна уу, шударга бус байна уу гээд.

Одоо энэ бол ер нь засагдаж байгаа шүү. Доод хэмжээгээр тэтгэвэр авч байгаа. Би хэлсэн. Тэр одоо 500 мянга дээр байсан ахмадууд ажилласан жил нь бага, цалин хөлс байхгүй, хамгийн бага ажил хийж байсан хүмүүс нь мэдээж 550 авна. Тэрнээс дээш бүх хүмүүс тэр итгэлцүүрээр бодоод ирэхээр жинхэнэ 500 авч байсан 550-иасаа дээшээ 600, 700, 800 гээд нэмэгдээд. Нөгөө шударгаар шууд авсан цалинг нь үржүүлээд тэгээд нэмэгдэл 10 хувийн нэмэгдэл өгөөд явж байгаа учраас энэ шударга бус, тэгш бус байдал үндсэндээ арилж байгааг манай ахмадууд маань сэтгэл өндөр хүлээж авч байгаа гэж хэлмээр байна. Баярлалаа.

**П.Анужин:** Ц.Туваан гишүүн тодруулж асууя.

**Ц.Туваан:** Малчдын асуудал. Малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг төрөөс төлөх асуудал нэлээн хурц яригдаж байгаа.

Тэгэхээр энэ дээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн байр суурь ямар байгаа юм.

Тэгээд би түрүүн төрөөс олох урамшууллаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл төлөх хуулийн бэлтгэл хангалт дээр ямар ажиллагаанууд явагдаж байгаа юм бэ гэдэг асуулт дээр нэмэлт хариулт авъя.

Дээрээс нь банк. Сая юу ярьчхав. Банк огт энэ чөлөөт үлдэгдэл байрлуулсан дээр хүү төлөөгүй гэсэн үг үү? Тийм. Үүнийг нэг тодорхой хэлээд өгөөч.

Тэр орон нутгийн бид нөгөө ялгамжтай байдал гэдгээ дахиад л үүсгээд байгаа. Тэр нь юу гэхээр энэ босоо удирдлагатай чинь бол тэр нэмэлт 20 хувь огт аваагүй. Нэг ч аваагүй. Үүнийг яаж шийдэх юм? Хэвтээгүүд нь орон нутгийн төсвөөсөө шийдээд явж байгаа учраас энэ чинь шийдэгдчихээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр хариулт авъя. Тэр Баялгийн сангийн хууль дээр та хэд цаашдын бодлого дээрээ нэг үг хэлчихвэл.

**П.Анужин:** Ц.Туваан гишүүний асуултад хариулахад энэ яг одоо Улсын Их Хурлаар хэлэлцэх гэж байгаа Нийгмийн даатгалын багц хуульд тусаж байгаа нэг гол заалт нь одоо тэр Монголбанканд хүүгүй хадгалагдаж байгаа тэр мөнгийг хүүтэй болгох асуудал нь энэ хуулиар зохицуулагдаж тодорхой зүйл, заалт орсноор эрх нь

нээгдэж ингэж хүү бодогдож эхэлнэ. Энэ бас нэг чухал заалт явж байгаа гэдгийг бас хэлье.

Дээр нь нэмээд ажлын хэсгийн гишүүд болоод Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд хариулна биз.

Эхний асуулт. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Хүрэлбаатарын Булгантуяа асуултад хариулна.

**Х.Булгантуяа:** Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Баялгийн сангийн тухай хууль яг боловсруулагдаж байна. Энэ хэсгийн хуримтлалын сангийн тогтолцоог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан бид олон улсын зөвлөхүүдийг аваад үүнийг боловсруулж байгаа.

Нийгмийн даатгалын багц хууль батлагдах юм бол ирэх оноос бидний тэтгэврийн шимтгэлийн 17 хувиас 2 хувь нь мөнгөжиж байршина. Энэ бол жилдээ 370 орчим тэрбум төгрөг болж байгаа.

Энэ дээр дээрээс нь нэмээд Баялгийн сангийн хуваарилалтаас нэмж. Одоо бол ингээд төрийн өмчит компаниуд хэдэн их наядаар ТУЗ нь өөрснөө шийдээд худалдан авалтыг хийж байна гээд нүүрсний сонсголын хүрээнд ч гэсэндээ яригдаж байгаа гол асуудлуудын нэг байгаа.

Тэгэхээр энэ Баялгийн сангийн хуулиар төрийн өмчит компаниудын, тэр тусмаа уул уурхайн баялагтай холбоотой компаниудын ногдол ашиг, орлого энэ бүх шийдвэрүүдийг хэрхэн яаж зохицуулах вэ, сангуудад хэрхэн яаж хуваарилах вэ. Энэ баялгийн.../минут дуусав/

**П.Анужин:** 1 номерын микрофонд Үндэсний зөвлөлийн гишүүн Х.Буянжаргал хариулъя.

**Х.Буянжаргал:** Ц.Туваан гишүүний асуултад үргэлжлүүлэн хариулъя.

Тэгэхээр ер нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлж суугаад 3 дахь хуралдаа бид суусан.

Ер нь 10 гаруй удаа хуралдсан юм байна. 2022 онд. Бид 3 удаа л суусан. Чөлөөт үлдэгдлийг тогтооход. Чөлөөт үлдэгдлийн хүүг 9.7 хувиар тогтоосон. Энэ дээр бидний хувьд, даатгуулагчдын төлөөллийн хувьд чөлөөт үлдэгдлийг Монголбанкны бодлогын хүүгийн хэмжээнээс доошгүйгээр тогтоох ёстой гэсэн байр суурьтай байсан.

Гэхдээ өнөөдрийн тооцоолох аргачлалаар энэ бодлогын хүүг 9.7 хувийг дундаж хүүгээр тогтооно гэсэн ийм заалттай юм билээ.

Тэгэхээр энэ дүрэм, журамдаа өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай юм байна лээ гэж харагдсан.

**П.Анужин:** 1 номерын микрофоныг өгье. 1 минутад гүйцээгээд хариулаарай. Тодорхой хариулт өгөөрэй.

**Х.Буянжаргал:** Тэгэхээр нийгмийн даатгалын салбарын ажиллагсад 1700 орчим хүн байгаа гэж байгаа юм.

Тэгэхээр энэ салбарын ажиллагсдыг бид Монгол Улсын хөдөлмөр эрхлэгчдийн асуудлыг яриад байдаг.

Тэгэхээр яг нийгмийн даатгалын энэ салбарт ажиллаж байгаа 1700 хүний эрх ашгийн асуудал ерөөсөө яригдахгүй байгаа юм. Энэ асуудлаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад Үндэсний зөвлөлийн гишүүнийхээ хувьд би хандсан.

Нийт 6 аймагт ажилласан. Хөдөө орон нутагтаа сумдын байцаагч нар үнэхээрийн дутагдалтай байна, ажиллах хүчний хомсдолд орж байна гэдэг асуудлаар аймгуудын нийгмийн даатгалын дарга нар ярьж байгаа.

Тэр байтугай дүүргийн нийгмийн даатгалын ажилтнуудын тогтвор суурьшлын асуудал ч гэсэн хүнд байгаа гэдгийг бас онцолж хэлэх ёстой.

Тэгэхээр өнөөдрийн Засгийн газрын юунаас гаргасан энэ төсвийн тодотголоор үүнийг засагдсан байх гэдэгт найдаж байгаа гэдгийг хэлье.

Ер нь Байнгын хорооны хурал дээр бид.../минут дуусав/

**П.Анужин:** Ц.Туваан гишүүн тодорхой асуулт асуусан.

Улсын Их Хурал дээр гишүүд өөр өөр байр сууриа илэрхийлээд байгаа. Тэр 50, 50 хувийн асуудал дээр ер нь өөрөө энэ хууль бичиж тийм ээ санаачилж оруулж ирсэн Засгийн газар, харьяа мэргэжлийн яам, байгууллага нь юу гэж үзэж байгаа юм бэ гэдэг чухал асуултыг асууж байна.

Энэ асуултад Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг хариулна.

Хариулахдаа тодорхой хариулаарай. Улсын Их Хурлын гишүүдээр ч энэ өөр байр суурьтай гишүүд асууж байна шүү дээ. Энэ асуух нь зөв. Тодорхой сайн хариулт өгье.

**Ц.Ганцэцэг:** Ц.Туваан гишүүний асуултад нэмэлтээр хариулья.

Нэгд нь, тэр малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцахтай холбоотой заалт Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд орсон байгаа.

Энэ хуулийн үзэл баримтлал, үндэслэл, агуулгын хувьд өнөөдөр мал аж ахуй маань Монгол Улсын хөдөө аж ахуйн үндсэн том салбар. Нүүдлийн мал аж ахуй эрхэлж байгаа малчдын хувьд залуу малчид бас ингээд тогтохгүй байна, мал дээр гарахгүй байна гэдэг энэ үндэслэлээр үндсэндээ малчдын нийгмийн даатгалын асуудал яригдсан.

Тоон үзүүлэлтээр аваад үзэхээр нийт нийгмийн даатгалд хамрагдвал зохих малчдын маань ерөөсөө 20 орчим хувь нь л нийгмийн даатгалд хамрагдаж байгаа. 28 мянган малчин тэтгэвэр авч байна.

Тэгэхээр үлдсэн нь үндсэндээ нийгмийн даатгалын нийгмийн хамгааллын гадна байгаа учраас энэ асуудлыг шийдье гэдэг байдлаар энэ хуулийн төсөл өргөн баригдсан байгаа.

Хоёр дахь асуултын хувьд Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хууль үндсэндээ Улсын Их Хурлаар батлагдсан. Энэ оны 10 сарын 01-нээс мөрдөнө.

Энэ хуулийн 5.1-д энэ шимтгэлийг тооцох, олгохтой холбоотой журмыг

Засгийн газар батална гэсэн ийм зохицуулалттай.

Манай яаман дээр сайдын тушаалаар ажлын хэсэг гараад энэ журмын төсөл дээр үндсэндээ ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газраас бас ажлын хэсэгт ороод ингээд ажиллаад явж байгаа. Журам Засгийн газраар батлагдаад ингээд явна. Журам гарангуут бид орон нутагтаа нийгмийн даатгалын байцаагч нартаа тодорхой мэдээллийг өгнө.

Ер нь хууль маань нийгмийн даатгалын багц хууль ч гэсэн одоо ингээд наадмын өмнө батлагдвал бид эхний ээлжид нийгмийн даатгалынхаа нийслэлийн хэмжээний байцаагч нараа тодорхой мэдээллээр хангая, нэгдсэн сургалт зохион байгуулья гэсэн ийм ажлыг төлөвлөж байгаа.

Тэр дотор мэдээж энэ хууль ороод явна гэж ингэж хэлэх гэж байна.

Дараагийн нэг асуулт бол тэр харилцахын үлдэгдэлд банкууд хүү тооцоогүй. Ер нь хадгаламж үндсэндээ байршуулаагүй. Энэ КОВИД цар тахалтай холбоотой хууль маань харилцахыг үлдэгдэл хүүд тооцохгүй гэсэн бүр зохицуулалттай ийм байсан.

Манай нийгмийн даатгалын сангийн үлдэгдэл шүү дээ. Төрийн сан дээр байршиж байгаа. Тэгээд бусад арилжааны банкнууд дээр байршиж байгаа 994 тэрбум төгрөг маань харилцагч. Тийм. Ер нь тийм байдал.

Харин он гарангуут энэ хууль үйлчлэл зогссон. Бид гэрээндээ өөрчлөлт оруулсан. Наад зах нь харилцахынхаа үлдэгдэлд хүү ав гээд даг байдлаар бид шаардлага тавиад бүх банкнуудтайгаа

гэрээгээ шинэчлээд одоо хүүгээ аваад байж байгаа. Тийм.

Энэ чинь КОВИД-ын нөхцөл байдалтай холбоотой. Тийм.

**П.Анужин:** Ц.Ганцэцэг дарга аа, энэ хуульд өөрчлөлт орж одоо энэ хүүтэй бодогдох тухай. Энэ чухал өөрчлөлт.

**Ц.Ганцэцэг:** Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл одоо өргөн баригдаад хэлэлцэгдэж байгаа хуулийн төсөл, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийнхаа 13 дугаар зүйл дээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага гэсэн бүхэл бүтэн бие даасан зүйл байгаа.

Энэ дээр арилжааны банк гэж ямар банкыг хэлэх юм бэ. Тийм ээ. Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан энэ банкны шалгуурыг хангасан банкттай Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр байршуулж болно.

Ингээд байршуулсан тохиолдолд хадгаламжийн хүүгийн доод хэмжээг Монголбанкны тухайн үеийн бодлогын хүү, арилжааны банкнуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ, арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээнээс тооцсон жигнэсэн дундаж хүүгээс доошгүй байхаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална гэсэн тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлдөө оруулсан байгаа.

**П.Анужин:** Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны тайланг сонсож дууслаа.

Гишүүд асуулт асууж, үг хэллээ.  
/алх цохив/



Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.2.13-д заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо Нийгмийн даатгалын үндэсний

зөвлөлийн үйл ажиллагааны тайланг сонсож дууслаа.

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн сүүлийн асуудалд орёе.

---

### Найм. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын ТОГТООЛ

---

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93.3-д заасны дагуу Байнгын хороонд дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33.3 дахь хэсэгт Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ, хязгаар, тухайн асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тусгасан байх ёстой.

Энэ хүрээнд төсөл санаачлагч гишүүд хуульд нийцүүлж, тогтоолын төсөлд холбогдох өөрчлөлтийг оруулах саналаа Байнгын хороонд албан бичгээр ирүүлсэн.

Байнгын хорооны гишүүд Та бүхэнд энэ саналыг урьдчилж тараасан байгаа.

Одоо тус саналыг үндэслэн ирүүлсэн санал тус бүрээр санал хураалт явуулна.

Нэг санал ирсэн байна. Саналыг Та бүхэнд танилцуулъя.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэл хэсэгт оруулах санал.

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт тухайн асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана гэж заасны дагуу “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэл хэсэгт “34.3 дахь хэсэг” гэсний дараа “Монгол Улсын эмийн үнэ, хүртээмж, худалдан авах боломж, үнэ бүрдлийн судалгаа, эмийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг шалгах шаардлагыг” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн гэсэн ийм саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Ж.Чинбүрэн гишүүний гаргасан санал 72.7 хувиар дэмжигдлээ.

Уг санал дэмжигдсэн учир Байнгын хорооны ажлын алба тогтоолын төсөлд саналыг шигтгээд нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их

Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн  
Чинбүрэн гишүүн танилцуулна.

Нийгмийн бодлогын байнгын  
хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал  
үүгээр өндөрлөсөн тул Нийгмийн  
бодлогын байнгын хорооны хуралдаандаа

идэвхтэй оролцсон нийт гишүүддээ  
баярлалаа. Мөн ажлын хэсгийн  
гишүүддээ баярлалаа.

Нийгмийн бодлогын байнгын  
хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр  
өндөрлөж байна.

*Хуралдаан 2 цаг 56 минут үргэлжилж, 12 цаг 28 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**